

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

1.1 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх нийслэл, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж хэрэгжилтийг хангуулан ажилласан.

1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хамтран хэрэгжүүлсэн 25 арга хэмжээний 2020 оны эхний хагас жилийн биелэлт 59.4 хувь, жилийн эцсийн байдлаар 93.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Дүүргийн нутаг дэвсгэр дэх мал, амьтадыг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд :

Малын хашаа саравч, өтөг бууц тэжээлийн агуулах, түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг, худаг уст цэг зорь агуулах бүхий нийт 209 объектын 66780 кв талбайг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Мал, амьтны 80 гаруй сэг зэмийг хогийн цэгт зориулалтын нүхийг бэлтгэн устгаж халдваргүйжүүлсэн

Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээ буюу халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт 90.5%-тай явагдсан. Вакцинжуулалтад нийт мал сүргийн 92%-ийг хамруулж, хяналт тавьж ажилласан.



Мал амьтны шимэгчлэх өвчнөөс сэргийлж нийт 20039 толгой малаас 15800 малыг угаалгад хамруулж, гүйцэтгэлд хяналт тавьсан.

Бруцеллөз өвчний шинжилгээнд малчин, мал бүхий 493 өрхийн 6728 үхрийг хамруулснаас, 25 өрхийн 77 толгой үхэрт бруцеллөз өвчний эсрэгбием илэрснийг эзэмгүүлж, сүүний чиглэлээр ашиглахгүй байх талаар чиглэл өгсөн.



Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж, нийт 538 өрхийн 33157 толгой мал, амьтан хамрагдаж, 95%-тай явагдсан.

Газар тариалангийн чиглэлээр:

➢ Өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжих, тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн 13, 14 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж буй 13 иргэн, аж ахуйн нэгжийг цахилгааны хөнгөлөлтөд хамруулсан.

➢ Дүүргийн хэмжээнд 2020 онд 160 гаруй га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 144.4 га талбайгаас 2260 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан дүн мэдээг нэгтгэсэн.

➢ Дүүргийн ногоочдын тариалсан 600тн төмс, хүнсний ногооны гарал үүслийн гэрчилгээ олгосон.

➢ Нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор шинэ ургацын хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг 7 байршилд зохион байгуулж, хяналт тавьж ажилласан. Өргөтгөсөн худалдаанд дүүргийн 24, хөдөө орон нутгийн 50 гаруй тариаланч 420 гаруй тн төмс, хүнсний ногоо борлуулсан байна.

"Өрх бүр хүнсээ бэлтгээ" уриан дор 8 төрлийн 2,1 сая төгрөгийн өртөг бүхий 71 кг хүнсний ногооны үрийг 9, 10, 12, 13, 14 дүгээр хорооны 234 өрхөд олгож, өрхийн тариалалтыг дэмжин ажилласан.



Нийгмийн бодлогын чиглэлээр:

"Спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцөлийг бүрдүүлнэ" зорилтын хүрээнд:

Дүүргийн өсвөрийн шигшээ багт сагсан бөмбөг, гар бөмбөг, тэшүүр, ширээний теннис, хөл бөмбөг, чөлөөт бөх, жүдо, зуун буудал даам, крикт гэсэн спортын 10 төрөлд нийт 236 хүүхэд хичээллэж байна.

Мөн Буянт-Ухаа спортын ордонд 2020 оны 08 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан жүдо бөхийн цуврал гранпри /насанд хүрэгчид/тэмцээнд А.Нямхишиг,

Б.Алтанцэцэг, нар мөнгөн медаль, Б.Солонго, Ц.Сүнжидмаа, Д.Наранжаргал, Б. Ганзаяа нар хүрэл медаль тус тус хүртсэн. 2020 оны 11 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Өсвөр үеийн Жүдо бөхийн олон хотын тэмцээн"-ээс алт-4, мөнгө-3, хүрэл-6 хүртэж багаараа 1 дүгээр байрт шалгарч цомын эзэн болсон.

2020 оны жилийн эцсийн байдлаар өсвөрийн шигшээ багийн тамирчид олон улс болон улсын тэмцээнээс алт-10, мөнгө-21, хүрэл-35 нийт 66 медалийг хүртээд байна.



"Нийтийн биеийн тамир, бясалгал, уюу, зохистой хөдөлгөөн /фитнес/-ээр хичээллэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулна" зорилтын хүрээнд:

2020 оны 01 дүгээр сарын 13-24-ний өдрүүдэд "МИАТ" ХХК-ний ажилтан албан хаагчаас бие бялдрын түвшин тогтоох сорил авч, нийт 140 хүн хамрагдсан.

Дэлхийн алхалтын өдөртэй холбогдуулж хөдөлгөөний дутагдал болон дасгал хөдөлгөөний ач холбогдолын талаар сургалт зохион байгуулж 2020 оны 10 дугаар сарын 21-27-ны өдрүүдэд ЗДТГ-ын болон дэргэдэх хэлтэс, албадын 300 албан хаагчийг бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулж, эрүүл амьдралын хэв маяг, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Мөн Сургуулийн өмнөх боловсролын 458 хүүхдийг сорилд хамруулсан.



1.3 Улсын болон нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, иргэдэд үйлчлэх зориулалт бүхий нийт 10 барилга угсралтын ажлын явцтай газар дээр нь танилцаж, мэдээлэл солилцон ажилласан.

Наадамчдын авто замын уулзвараас Яармагийн эцсийн автобусны шинэ буудал хүртэлх авто замын ажлыг ашиглалтад авах улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/293, А/330 дугаар захирамжуудаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 6,784.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн.

Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		Төсөвт өртөг /сая.төг/	2020 онд /сая.төг/		
Хэрэгжиж байгаа 4					
1	60 дугаар сургуулийн дээвэр, цахилгааны засвар	300.0	136.0	7	"СДММ" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 80%. 2021 онд хэрэгжиж дуусна.
2	189 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын хүзүүвч	350.0	150.0	6	"Морин сувд" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 60%. 2021 онд хэрэгжиж дуусна.
3	12 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, дэд өртөө, зам талбайн тохижилтын ажил	426.0	226.0	4	"Рендер бау" ХХК-тай гэрээ байгуулагдаж байна.
4	73 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар	150.0	150.0	7	"Голден прогресс" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хүлээлцэх шатанд.
Хэрэгжих боломжгүй болсон 4					
5	Гэр хорооллын байруудын дулаалга / "Эко яармаг" төсөл/	1500.0	1500.0	4-8	Санхүүжилт татагдсан.
6	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дулааны шугам сүлжээ, дэд станц	2957.9	2957.9	11, 15	"Бумбод" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 90%- тай.
7	Гэр хорооллын гудамж талбайн тохижилт	1000.0	1000.0	4-8	Санхүүжилт татагдсан.
8	Дээд бодь хийдийн барилгын гадна дулааны шугам, халаалтын цогц төхөөрөмж	101.0	101.0	4	Санхүүжилт татагдсан.
Нийт		6,784.9	6,220.9		

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/106, А/324 дүгээр захирамжуудаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		Төсөвт өртөг	2020 онд		
Тендер зарлагдсан 1					
1	Наадамчдын замаас "Арапе" эмнэлгийн баруун тал гэр хороолол дундуур Буянт-Ухаа цогцолбор сургууль хүртэлх авто зам	1,000.0	500.0	10	"Хурдны зам" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 40%-тай. 2021 онд хэрэгжиж дуусна.
Хэрэгжих боломжгүй болсон 1					
2	Цэцэрлэгийн барилга 240 ортой	2,200.0	500.0	4	Санхүүжилт татагдсан.
Нийт		3,200.0	1,000.0		

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/410 дүгээр захирамжаар нийслэлийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

		Санхүүжилт	Хороо	Ажлын явц
--	--	------------	-------	-----------

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая.төг/	2020 онд /сая.төг/	
Хэрэгжиж дууссан 6				
1	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай	75.0	75.0	19
2	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил	80.0	80.0	15
3	Иргэдийн амьдрах орчныг сайжруулах тохижилтын ажил	80.0	80.0	19
4	Гэрэлтүүлэг	70.0	70.0	13
5	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	100.0	100.0	10
6	Жишиг гудамж байгуулах	150.0	150.0	9
Шууд гэрээ байгуулах шатанд				
7	Гүний худаг	30.0	30.0	13
8	Нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт	50.0	50.0	10
Нийт		705.0	705.0	

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин барилгажуулах талаар:

Дүүргийн 1, 2, 5, 20 дугаар хороодын ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 17 орон сууцны 601 сууц өмчлөгч өрхөөс дахин төлөвлөлтийг дэмжсэн эсэх санал асуулга авах ажлыг зохион байгуулж, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг бүрдүүлэн авч, дүнг нэгтгэн, Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 06/840 тоот албан бичгээр Хот байгуулалт хөгжлийн газарт хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/397 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо 5, 6 дугаар байр, 06 дугаар хорооны 20-1, 20-2 дугаар байруудыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр "Шинэ гэр Түншлэл" ХХК шалгарсан. Мөн 2 дугаар хороо, Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар орон сууцны байруудыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр "Хару констракшн" ХХК шалгарч Хот байгуулалт хөгжлийн газраас газар үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигчидтэй гэрээ байгуулах эрхийг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр тус тус олгосон.

Дүүргийн Засаг даргын 2020 оны А/370 дугаар захирамжаар батлагдсан Явуулын нэг цэгийн үйлчилгээгээр 4-10,12-14, 16, 21 дүгээр хороодын оршин суугч иргэдэд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны мэдээлэл, сурталчилгааг танилцуулж ажилласан.

Дүүргийн 10 дугаар хороо, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 34, 35 дугаар байрыг дахин төлөвлөж барилгажуулах тендер 25 дахь удаагаа зарлагдсан боловч шаардлага хангасан тендерийн материал ирээгүй байна. 20 дугаар хороо Арьс ширний 31 дүгээр байруудыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруултанд шаардлага хангасан тендер материал ирээгүй байна.

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх талаар:

Хот дахин хөгжүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороод Яармагийн гэр хорооллын дахин төлөвлөлтийг ажлыг хэрэгжүүлэх байршилд дүүргийн Засаг даргын 2020 оны 03-р сарын 11-ний өдрийн 06/164 тоот албан бичгээр Хот байгуулалт хөгжлийн газарт санал хүргүүлсэн. Дахин төлөвлөлтийн байршлыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 04 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаар хэлэлцэн баталсан. Дээрх байршлуудад Хот байгуулалт хөгжлийн газраас Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зарласан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/28 дугаар захирамжийн дагуу Яармагийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд иргэдийн төлөөллөөр ажиллах 16 иргэний холбогдох материалыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 06/1015 тоот албан бичгээр Хот байгуулалт хөгжлийн газарт хүргүүлсэн.

Дүүргийн 4, 5, 6, 7, 8-р хорооны оршин суугч иргэдээс "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх" этгээдийн төслийн саналыг дэмжих эсэх талаар мэдээлэл өгөх, санал авах ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 10-12-нд, 17-19-ний өдрүүдэд Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газартай хамтран зохион байгуулсан. "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх" этгээдийн төслийн саналыг дэмжих эсэх санал асуулгад "Андын зам" ХХК болон "Томобюлдинг" ХХК хамтран оролцсон төслийг 4 дүгээр хорооны оршин суугч иргэд дэмжиж, ирц хүрсэн боловч Нийслэлийн Засаг даргын батламжилсан захирамж гараагүй байна.

5, 6, 7, 8 дугаар хорооны гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг дахин зарлахаар Хот байгуулалт хөгжлийн газар төндөрийн баримт бичиг боловсруулж байна.

Нисэх, Яармаг Наадамчдын авто зам дагуу зам хөндлөн гарах явган хүний гүүрэн гарцын судалгааг 6 байршилд хийж, төслийн танилцуулга мэдээлэл бэлтгэсэн.



Мөн дээрх гүүрэн гарцыг 2021 онд улс, нийслэлийн төсөвт тусгуулах саналыг дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 06/633 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Авто замын хөгжлийн газруудад уламжилсан.

Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Дүүргийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт шинээр 64 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 10 дугаар тогтоолоор 1 ажил нэмэгдэж, нэмэлт өөрчлөлт оруулсан. /Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 63 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 төсөл, арга хэмжээ/ Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэршил	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/	Ажлын явц
1	Зураг төсөв	-	200.0	Зураг, төсвийн захирамж гарсан.
Хэрэгжиж дууссан - 23				

2	Албан бус насан туршийн боловсролын төвийг шаардлагатай төхөөрөмжөөр хангах Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн өргөтгөлд тавилга, тоног төхөөрөмж худалдан авах	20	40.0	"Гранд премиум" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
3		4	50.2	"Лүндээ-Очир" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
4	Ахмадын хөгжлийн төвийг орон сууц худалдан авч тохижуулах	15	200.0	"Жеопро Монголиа" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
5	Цагдаагийн газарт эргүүлийн авто машин худалдан авах	20	30.0	"Юникплайтс" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Автомашин хүлээлгэж өгсөн.
6	Эргүүлийн авто машин худалдан авах /Замын цагдаагийн хэлтэс/	20	30.0	"Юникплайтс" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Автомашин хүлээлгэж өгсөн.
7	Хорооны байрны зоорин давхрыг тохижуулах	18	40.0	"Мөнх Чандмань Илч" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
8	Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байрны засвар	20	50.0	"Прогресс цамхаг" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
9	Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж авах	20	70.0	"Сүвэн Уул" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
10	Замын индүү худалдан авах	-	90.0	"Жеопро Монголиа" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
11	Шинээр байгуулагдсан хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тавилга, тоног төхөөрөмж	-	50.0	"МЭД БУЯН" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
12	Гудамжны тохижилт /14-р хороо 1-р хэсэг Өлзийтийн 1/1-ээс 2-р хэсгийн МТ колонк хүртэл жишиг гудамж болгох	14	30.0	"Мандал өргөө голомт" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
13	Цагдаагийн кабон байршуулах	-	29.0	"Говийн Очир Отглогч" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
14	Иргэд олноор цуглардаг амралт, зугаалгын бүсэд утасгүй интернетийн сүлжээ суурилуулах	-	20.0	"Итвестмент трейд энд финанс корпорэйшн" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
15	Ахмадын хөгжлийн төвийг орон сууц худалдан авч тохижуулах	17	150.0	"Моншикээ" ХХК-тай гэрээ байгуулагдаж байна. Ажил хэрэгжиж дууссан.
16	Анхан шатны шүүхийн барилгын гадна фасадны засвар	20	80.0	"Юу би жи" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
17	11, 12 дугаар хорооны цахилгааны хүчдэл сайжруулах	11, 12	154.3	"Түнтгэр нөөлөгт Инженеринг" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
18	118-р сургуулийн спорт заалны шалны засвар	8	40.0	"Дуутын нуруу" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
19	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дуут дохиоллын цамхаг суурилуулах /ОБХ/	-	90.0	"Нью теравокс" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
20	Туул голын эрэг дагуу эко зурвас байгуулах	15	257.3	"Вектор ус дриллин" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
21	Эрүүл мэндийн төвийн засвар	20	50.0	"СБМ" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.

22	Ажилчны цагаан хаалгыг засварлах	20	20.0	"СБМ" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 80%.
23	Явган хүний зам /19-р хороо Орчлон хотхонд/	19	20.0	"Алтай шар говь" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
24	Тоглоомын талбай байгуулах	19	20.0	"Вектор ус дриллинг" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
Он дамжин хэрэгжих				
25	Хатуу хучилттай авто зам тавих	-	5,000.0	"Хомын тал" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 40%-тай.
26	Нисэх Яармагт 4 улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах	21	268.1	"Чингисийн отог" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил хэрэгжиж дууссан.
27	Явган хүний зам барих	-	463.6	"Морин сувд" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 80%-тай.
28	Ахмадын сувилалын гадна тохижилт	8	450.0	"Жам" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 60%-тай.
29	Хан-Уул дүүргийн харьяа байгууллага, хороодын байранд засвар	-	160.0	"Центрлайн констракшн" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 60%-тай.
30	Гудамж, зам талбайн засвар, тохижилтын ажил	15, 18	150.0	"Юу би жи" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажлын явц 60%-тай.
31	Тохижилт, үерийн хамгаалалт хийх	9	40.0	"СБМ" ХХК-тай гэрээ байгуулагдсан.
32	Нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт	-	432.0	Шууд гэрээ байгуулах гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд.
33	Орчны тохижилт /ногоон байгууламж бүхий/	-	480.0	Шууд гэрээ байгуулах гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд.
34	Гэрэлтүүлэг	-	900.0	Шууд гэрээ байгуулах гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд.
35	ДИТХ-ын албан хэрэгцээнд авто машин худалдан авах	-	90.0	Шууд гэрээ байгуулах гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд.
Дахин төлөвлөлт болон бусад шалтгаанаар хэрэгжээгүй 28				
36	18 дугаар сургуулийн гадна тохижилт	3	30.0	Шинээр өргөтгөл барихтай холбоотой.
37	18-р сургуулийн хашаа	3	40.0	Шинээр өргөтгөл барихтай холбоотой.
38	Тоглоомын талбай байгуулах	13	40.0	Хэрэгжээгүй
39	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах	16	50.0	Зураг төсөв хийгдсэн. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.
40	Таксины зогсоол байгуулах	10	30.0	Зураг төсөв хийгдсэн. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.
41	Жаргалантын 18-р гудамжны үерийн ус зайлуулах сувгийн засвар /Төсөв – 41 сая төгрөг/	7	41.0	Гэрээ цуцлагдсан.
42	15-р сургуулийн хашаа	3	40.0	Зураг төсөв хийгдсэн. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.
43	Явган хүний гүүр барих /14-р хороо 3-н байршил/	14	60.0	Зураг төсөв хийгдсэн. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.
44	Хуучин байрны орчны засвар үйлчилгээ хийх	19	20.0	Зураг төсөв хийгдсэн. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.
45	Гүний худаг байгуулах	14	30.0	Зураг, төсөвт магадлал хийгдэж байна. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.
46	Гүний худаг байгуулах ажлын /смарт ажиллагаатай/	9	60.0	Зураг, төсөвт магадлал хийгдэж байна. 2021 онд шинээр хэрэгжүүлэх саналтай.

47	65-р цэцэрлэгийн зоорийн шалны засвар	2	20.0	Хэрэгжээгүй.
48	Цэцэрлэгийн барилга	8	2,290.1	Газаргүй.
49	Хуучин орон сууцны засвар, тохижилт	19	68.0	Хэрэгжээгүй.
50	Яармагийн 19-р гудамжны 20 айлыг цэвэр усны шугамд холбох	5	50.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
51	Хаягжуулалт	5	15.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
52	Жишиг гудамж	5	30.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
53	Хаягжуулалт	6	15.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
54	Жишиг гудамж	6	30.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
55	Явган хүний зам тавих	6	15.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
56	Жишиг гудамж байгуулах	7	60.0	Дахин төлөвлөлттэй холбоотой.
57	Авто зогсоол байгуулах / 209-р цэцэрлэгийн гадна/	8	40.0	Тус байршилд бохирын шугам төлөвлөгдсөн тул УСУГ-аас тодруулга хүүсэн.
58	Соёлын ордны засварын ажил	20	80.0	Барилга ашиглалтын шаардлага хангахгүй болсон.
59	Хорооны байрны дээврийг засварлах	16	15.0	Ажил өөр эх үүсвэрээр хэрэгжсэн.
60	Мэдээллийн самбар байршуулах	-	90.0	Гэрээ цуцлагдсан.
61	Гудамж, зам талбайн тохижилт	15	50.0	Ажил хийгдсэн.
62	Био комбинатад иж бүрэн стандарт сагсны талбай байгуулах	12	30.0	Магадлалын төсөв 52.4 сая төгрөгөөр батлагдсан.
63	Спортын ордон барих	8	5,000.0	Газрын маргаан үүссэн.



ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ

№	Төсөл, арга хэмжээний нэршил	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/	Ажлын явц
1	Камержуулалт	1-11, 14-21	591.0	Шууд гэрээ байгуулах шатанд
2	Гүний худаг	12, 13	60.0	Зураг, төсөвт магадлал хийгдэж байна.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-11, 14-21 дүгээр хэрэгжүүлэх камержуулалтын ажлын даалгаврыг 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдөр батлуулсан. 2020.07.24-нд тендер зарлагдаж, 2020.08.24-нд нээлт хийсэн. Гүйцэтгэгчээр "Арш Технологи" ХХК шалгарсан боловч ОХУ болон БНХАУ-ын теле хяналтын камерын систем ашиглахыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр хориглосонтой холбогдуулан камерын

техникийн тодорхойлолтыг НМТГ-аар 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдөр дахин батлуулж, 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр төндөр зарласан боловч шаардлага хангах гүйцэтгэгч шалгараагүй. Тус ажил 2021 онд он дамжин хэрэгжинэ.

Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд тендер зарлах шаардлагатай нийт 23 ажлын зураг төсөл, төсөв, ажлын даалгавар, техник, бараа материалын тодорхойлолтыг боловсруулан хүлээлгэн өгсөн: Үүнд

- Хан-Уул дүүрэг 19-р хороо "UB town" хотхоны дунд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилт
- Хан-Уул дүүрэг 16-р хороо Буянт-Ухаагийн 25-р гудамж Хүүхдийн тоглоомын талбай тохижилтын ажил
- Хан-Уул дүүрэг 18-р сургуулийн урд талын тохижилтын ажил
- Хан-Уул дүүрэг 10-р хороо 61/2 байрны хойд талд байрлах авто зогсоолын ажил
- Хан-Уул дүүрэг 19-р хороо Орчлон хотхон орчим явган хүний зам тохижилтын ажил
- Хан-Уул дүүргийн 3,10,16,19-р хороодын нутаг дэвсгэрт хийгдэх тохижилтын ажил
- Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил /Буянт ухаа 25-р гудамжинд/
- Тоглоомын талбай байгуулах ажил /19-р хороо/
- Явган хүний зам /19-р хороо/
- Сургуулийн гадна талбайн тохижилт /18-р сургууль/
- Таксины зогсоол байгуулах
- Хан-Уул дүүрэг 15-р хороонд баригдах Хурд хорооллын 17,19-р байрнуудын дундах хүүхдийн тоглоомын талбайн засварын ажил
- Хан-Уул дүүрэг 15-р хороонд баригдах Хурд хороолол доторх тамхины цэг байгуулах, цэнгэлдэх хүрээлэнгийн өмнөх явган замын засварын ажил
- Хан-Уул дүүрэг 15-р хороонд баригдах Хурд хорооллын 3,4,17,19,21 байрнууд, хөл бөмбөгийн талбайн хажуугийн авто замын засварын ажил
- Хан-Уул дүүрэг 18-р хороонд баригдах хорооны барилгын үүдний шатанд ХБИ-д зориулсан зам хийх ажил
- Хан-Уул дүүрэг 18-р хороонд баригдах хорооны барилгын өмнөх талбайд авто зогсоол байгуулах ажил
- Хан-Уул дүүрэг 18-р хороонд баригдах 3 байршилд замын хурд сааруулагч засварлах, явган хүний гарц, тэмдэг тэмдэглэгээ хийх ажил
- Хан-Уул дүүрэг 2-р хороо 65-р цэцэрлэгийн дотор босоо шугамын засварын ажил
- Хан-Уул дүүрэг 9-р хороо Буянт-Ухаа 23-р гудамжны тохижилтын ажил
- 18 дугаар сургуулийн тусгаарлах хашаа
- 15 дугаар сургуулийн тусгаарлах хашаа
- 19 дүгээр хороо орчны засварын ажил
- 14 дүгээр хороонд 4 байршилд явган хүний гүүр барих ажил
- 15, 17 дугаар хороонд Ахмадын хөгжлийн төв худалдан авч, тохижуулах
- 18 дугаар хорооны зоорийн давхрын тохижуулах зэрэг болно.

Зураг төсөвт магадлал хийлгэх шатруу хянаж шалган шилжүүлсэн ажлаас хүлээгдэж буй 4 ажил байна. Үүнд:

"Зэндмэнэ тулга" ХХК нь Дүүргийн Засаг даргын А/439 дүгээр захирамжийн дагуу Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх зураг, төсвийн ажлын жагсаалтанд орсон 9,12,13,14 дүгээр хороонд гүний худаг байгуулах ажлын зураг, төсөв боловсруулах ажлыг ХО/50 тоот гэрээний дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд зураг, төсөв экспертизээр хянагдах шатандаа явагдаж байгаа.

Зураг төсвийн 7 байгууллагатай зохиогчийн хяналтын гэрээ байгуулж, хөрөнгө оруулалтын ажилд хамтран хяналт тавьж ажилласан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/194 дүгээр захирамжаар томилогдсон дүүргийн техник хяналтын комиссын бүрэлдэхүүнд холбогдох албан хаагчид орж 122 удаа ажилласан бөгөөд гүйцэтгэгч байгууллагуудын санхүүжилтийн бичиг баримтыг шалгах төрийн санруу шилжүүлсэн 30 ажил, ажил хийгдэх талбайн судалгааны ажил 19 удаа хийгдсэн.

Техник хяналтаар ажиллаж хүлээн авсан болон явцын шалгалт хийсэн гол томоохон ажлуудаас дурдвал: /хийгдэж байгаа ажлуудаас/

1. Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Тайны аманд байрлах "Хан-Уул дүүргийн ахмадын сувилал"-барилгын ажлыг "Голден лайт" ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай.



2. Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Тайны аманд байрлах "Хан-Уул дүүргийн ахмадын сувилал"-ын барилгын гадна тохижилтын ажлыг "ЖАМ" ХХК түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 50 хувьтай.



3. Дүүргийн 2,3,9,11,14,19-р хороонд явган хүний замын тохижилтын ажлыг "Морин сувд" ХХК түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 60 хувьтай.



4. Дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэрт хийгдэх "Цэцэрлэгт хүрээлэн байгуулах" ажлыг "Тэмжин" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн зураг төсвийн дагуу "Чингисийн отог" ХХК хийж байгаа. Ажлын явц 97 хувьтай.



5. "Санттри" ХХК-ийн зураг төсвийг нь хийж гүйцэтгэсэн 18 дугаар хорооны 3 байршилд замын хурд сааруулагч засварлах, явган хүний гарц тэмдэг, тэмдэглэгээ хийх, 15 дугаар хороо Хурд хорооллын 17,19 дүгээр байрны дундах хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил дээр "Юу Би Жи" ХХК шалгаран гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 60 хувьтай.



2020 онд хийгдэж дууссан ажлуудаас дурдвал:

1. "Скай Лайн" ХХК-ий зураг төсвийг нь хийж гүйцэтгэсэн 19 дүгээр хороо, "Туул голын эрэг дагуу эко зурвас байгуулах" ажил дээр "Вектор Ус Дриллинг" ХХК болон "Гарденсити" ХХК шалгаран ажил гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.



2. "Нутаг консалтинг" ХХК-н зураг төсвийг нь гүйцэтгэсэн 20 дугаар хороо, Эрүүл мэндийн төвийн дээврийн засварын ажил", "Ажилчдын цагаан хаалга засварлах ажил"-ыг "СБМ" ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.



3. "Нутгийн босго" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 19 дүгээр хороо "UB Town" хотхоны дунд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил дээр "Вектор ус дриллинг" ХХК шалгарч гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.



4. Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн "Өвсний үндэс" хөтөлбөрийн санхүүжилтээр ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн засварын ажлыг "БЧГ" ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.



5. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн Авто зам арчлалт, засварын газартай хамтран хайрган хучилттай замын ажил 4,5,9,10,16,20 дугаар хороонд хийж гүйцэтгэсэн.



6. Био комбинат 12-р хорооны 38, 53 дугаар байрны авто замыг тэгшилж засварлан хайрган хучилт дэвсэх ажил хийгдсэн.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 4, 5 дугаар хорооны зааг Яармаг худалдааны төвийн зүүн уулзвараас хойших 800 метр, 16 дугаар хороо Баруун Сонгolonгийн гудамжаас Тайнь 7 дугаар гудамж дагуу Наадамчдын зам хүртэлх 1400 метр, 11 дүгээр хороо Дүнжингаравын гудамжаас Ар Зайсан гудамжны 900 метр, нийт урт 3100 метр хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Хомын Тал" ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд ажлын зураг төсвийг Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХЗ, Ус сувгийн удирдах газар, Богд Хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, нийслэлийн Авто замын хөгжлийн газруудтай тус тус зөвшилцөн ажлыг эхлүүлсэн. 16 дугаар хороо Баруун Сонгolonгийн гудамжаас Тайнь 7 дугаар гудамж дагуу, Наадамчдын зам хүртэлх авто замын ажил 60 хувьтай хэрэгжиж байна. Тус ажил 2021 онд хэрэгжиж дуусна.

Дүүрэгт зорчих хэсгийг сайжруулах, түгжрэл бууруулах зорилгоор хэрэгжих боломжтой хатуу хучилттай авто замын судалгаа хийж, танилцуулга мэдээлэл бэлтгэн санхүүжилтийн эх үүсвэрийг судлан ажиллаж байна.



Дүүргийн хэмжээнд засварлах шаардлагатай авто замын судалгааг хороодтой хамтран хийж гүйцэтгэсэн бөгөөд нэн шаардлагатай 7 байршлын авто замыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн 13, 14-р хорооны хүчдэлийн уналттай айл өрхийн судалгаа авч цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг батлуулсан. Мөн 16-р хороо 41-р байрны гадна цахилгааны ажлын зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг батлуулан шууд гэрээний ажлын хэсэгт 11 дүгээр сарын 27-ны өдөр хүлээлгэн өгсөн.

ОНХС-ын санал асуулга зохион байгуулсан байдал:

ОНХС-ийн цахим санал асуулгатай холбоотой сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвтэй хамтран 2020 оны 02 дугаар сарын 03-15-ны хооронд хороодын Зохион байгуулагч, хэсгийн ахлагчдад цахим хэлбэрээр зохион байгуулсан.



ОНХС-ийн цахим санал асуулгын SMART UB аппликейшны ldf.ub.gov.mn цахим системд админ хэрэглэгчээр нийт 21 хорооны 26 зохион байгуулагчийг хорооны эрхээр, 192 хэсгийн ахлагчийг хэсгийн эрхээр нийт 218 хүнийг бүртгэн заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Хотын засаглалыг сайжруулах төслийн холбогдох албаны хүмүүс болон нийслэлийн 9 дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтнүүдтэй санал асуулгатай холбогдон гарч буй асуудлыг хэлэлцсэн.

ОНХС-ийн цахим санал асуулгыг нээх хэвлэлийн бага хуралд ЗДТГ-ын мэргэжилтэн У.Намуун НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, Төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Отгонбаяр, Нийслэлийн Мэдээллийн Технологийн газрын дарга О.Чинзориг, НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга Ц.Мөнхбаатар, Азийн сан "Хотын засаглалыг сайжруулах төсөл"-ийн менежер Г.Халиунгоо нарын хамтаар оролцон хэвлэлийхэнд мэдээлэл өгсөн.

Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 12000 ширхэг тараах материал, постерийг хороодод хуваарилан тарааж, холбогдох мэргэжилтнүүд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 12, 13, 15, 18, 19, 20

дугаар хороодод очиж хэсгийн ахлагчидтай уулзан, арга зүйгээр хангаж, санал асуулгыг эрчимжүүлэх үүрэг, чиглэл өгч ажилласан.



www.khanuul.mn мэдээллийн сайтад Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулгад иргэдийг санал өгөхийг уриалах зорилгоор 4 удаа мэдээ, мэдээлэл бэлтгэн байршуулсан.



Мэргэжилтэн У.Намуун 2 дугаар сарын 10-ны өдрийн ЕСО телевизийн ярилцлагын цагт оролцон 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих ажилд иргэдээс авах цахим санал асуулгын талаар үзэгчдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

ОНХС-ийн цахим санал асуулга нь 3 дугаар сарын 02-ны өдрөөс 4 дүгээр сарын 20 хүртэл нийт 50 хоног үргэлжилж Хан-Уул дүүргийн оролцох боломжит нийт 92540 иргэн байгаагаас 47534 иргэн санал өгч 51.4 хувьтай санал асуулгыг амжилттай дуусгасан. 5, 17, 21 дүгээр хороод санал асуулгыг 100 хувь зохион байгуулж дууссан.

Дүүргүүдийн санал асуулгыг зохион байгуулсан байдал:



ДҮҮРЭГ	ХОРООНЫ ТОО	САНАЛ ӨГӨХ ИРГЭДИЙН ТОО	ЦАХИМ САНАЛ ӨГСӨН ИРГЭДИЙН ТОО	ДҮҮРГҮҮДИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО %
Баянгол	25	130,413	32,245	24,73
Баянзүрх	30	211,048	38,855	18,41
Налайх	8	25,135	20,373	81,05
Сонгинохайрхан	43	190,056	90,958	47,86
Сүхбаатар	20	66,849	46,160	69,05
Хан-Уул	21	92,540	47,520	51,35
Чингэлтэй	19	68,672	57,614	83,90
Багануур	5	19,578	11,391	58,18
Багахангай	2	1,871	1961	104,81
НИЙТ	173	806,162	347,250	43,07%

Дүүргийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/69 дүгээр захирамжаар байгуулагдсан "Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, дүгнэлт гаргах ажлын хэсэг"-ийн шийдвэрээр Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгыг амжилттай зохион байгуулж, хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулсан 17, 5, 21 дүгээр хороодын Засаг дарга нарт Засаг даргын Тамгын газрын "Талархал" мөнгөн шагналыг гардуулан, санал асуулгыг 50%-аас дээш хувьтай зохион байгуулсан 1, 4, 5, 6, 7, 9, 14, 17, 21 дүгээр хороодын зохион байгуулагч нарыг мөнгөн шагналаар шагнаж, урамшуулсан.



Хан-Уул дүүргийн хороодын санал асуулга зохион байгуулсан байдал:

Хорооны дугаар	Иргэдийн тоо	Хамрагдсан иргэдийн тоо	Санал өгсөн иргэдийн оролцооны хувь
1 хороо	5686	3801	66.85%
2 хороо	5230	2263	43.27%
3 хороо	5721	2203	38.51%
4 хороо	5984	3471	57.87%
5 хороо	2794	2809	100.50%
6 хороо	2900	1934	66.69%
7 хороо	2728	1583	58.03%
8 хороо	5641	2750	48.75%
9 хороо	3820	3064	80.18%
10 хороо	3839	1801	46.91%
11 хороо	6202	880	14.19%
12 хороо	3119	1101	35.30%
13 хороо	2828	1210	42.79%
14 хороо	2800	1755	62.68%
15 хороо	7215	3050	42.27%
16 хороо	5847	1562	26.71%
17 хороо	4200	4202	100.05%
18 хороо	2715	1263	46.37%
19 хороо	4989	1693	33.93%
20 хороо	6065	2912	48.01%
21 хороо	2217	2227	100.45%
Нийт	92540	47534	51.37%

Санал асуулгын үр дүнг хороод, ажлын хэсэгтэй хамтран эрэмбэлж 2021 онд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр ДИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан. Үүнд:

№	Хороо	Төсөл арга хэмжээний нэр	Байршил	Төсөвт өртөг /мян.төг/
Шинээр хийгдэх				753,491.9

1	1-11, 13-21	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	730,491.9
2	12	Цагаан эргийн модон гүүрний засвар, шинэчлэлт	Цагаан эргийн гүүр	23,000.0
Он дамжих				651,018.1
1	1-11, 14-21	Камержуулалт	Нийтийн эзэмшлийн талбайд	591,018.1
2	12, 13	Гүний худаг байгуулах	Нийтийн эзэмшлийн талбайд	60,000.0
НИЙТ				1,404,510.0

1.4 Үндэсний хөтөлбөрт заасан хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Монгол Улсын Их хурал болон Засгийн Газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн 39 үндэсний хөтөлбөрийн 160 зорилтын 2019 оны хэрэгжилтийг хүлээн авч нэгтгэн НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст 2020.01.03-ны өдрийн 06/15 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Дүүргийн хэмжээнд хэрэгжсэн Санамж бичиг, хамтран ажиллах гэрээ, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн 2019 оны хэрэгжилтийн талаар шалгуулж, хангалттай үнэлгээ авсан. НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэст Засгийн Газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан санамж бичиг, хамтран ажиллах 7 гэрээний 70 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн 2019 оны хэрэгжилтийн тайланг 2020 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 06/424 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Үндэсний болон нийслэлийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн 3 нэгжийг хуулийн хугацаанд нь дүүргийн архивт хүлээлгэн өгсөн. Эхний хагас жилд дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ хийж, хэрэгжилтийг мэдээлэх, тайлагнах талаар холбогдох хэлтсүүдийн мэргэжилтнүүдэд 10 гаруй удаа зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 24 дэд хөтөлбөрийн 129 зорилтын хэрэгжилтийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст 2020.01.03-ны өдрийн 06/15 тоот албан бичгээр хүргүүлж тайлагнасан.

ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУДААС:

"Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийн хүрээнд: ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Бээжин дэх ЮНЕСКО-ийн төлөөлөгчийн газар хамтран "Богцон дахь соёлын өв" төслийг түгээн дэлгэрүүлэх өвийн боловсрол олгох хүрээнд дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Богцон дахь соёлын өв" сургагч багшид зориулсан сургалтыг 01 дүгээр сарын 02-10-ны өдрүүдэд зохион байгуулж, Ерөнхий Боловсролын сургуулийн бага ангийн багш-36, Нийгмийн ухаан, иргэний ёс зүйн боловсролын багш-32, СӨБ-ын багш-29, Хороодын хөгжлийн нийгмийн ажилтан- 19 нийт 116 албан хаагчдыг хамруулан "БАТЛАМЖ"-г гардуулан өгсөн.



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

Жендэрийн тухай ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр "Хөөрхөн зүрхний аян" ТББ-тай хамтран 21 хорооны нийгмийн ажилтнууд, сургуулийн нийгмийн ажилтнууд нийт 40 албан хаагч 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс Монгол-Солонгосын коллеж, Хүнс, тенхологийн коллеж, Нийлэлийн ерөнхий боловсролын 60, 118 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад 2020 оны 10 дугаар сарын 05-13-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж, нийт 500 оюутан, сурагч хамрагдсан.



Жендэрийн Үндэсний хорооноос зохион байгуулсан төрийн албан хаагчдад зориулсан жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт сургалтад 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 12 эрэгтэй албан хаагч, 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр дүүргийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус хамрагдсан.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ы хүрээнд "ЯГ ОДОО ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЦЭГЛЭЭ" олон нийтийн аяныг 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн хүчирхийллийн тухай ойлголт, түүнээс татгалзах, таслан зогсоох талаарх фрэм, уриалга, сурталчилгааны ажлыг дүүргийн "Хан-Уул дүүргийн иргэд", "Эко Хан-Уул дүүрэг" болон хороо, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан ёсны пейж хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр сурталчилан ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

"Эрэг хандлагыг төлөвшүүлж, Ээлтэй орчныг нэмэгдүүлье" аяны хүрээнд доорх чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас "Эрэг хандлагыг төлөвшүүлж, Ээлтэй орчныг нэмэгдүүлье" уриан дор өртөөчлөн аялуулах аяны тугийг нийслэлийн 6 дүүргийн дунд аялуулсан бөгөөд 09 дүгээр сарын 10-ны өдөр уг тугийг хүлээн авч 1 сарын хугацаанд Хан-Уул дүүрэгт аялуулсан.



Тус ажлын хүрээнд дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуралдуулж 6 чиглэлийн хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа.

✦ Дунд голын замын дуут гэрлэн дохионоос 19-ийн үйлчилгээний төв хүртэлх явган хүний зам засварлах

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоотой хамтран тус замын бодит байдалтай танилцан тус замын хөтөч хавтанг дүүргийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийгдэхээр тусгагдсан явган хүний замын засварын ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж засварлуулсан.



✦ Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх хүрээнд:

- Лифтэнд давхрын дугаар танилцуулах яригчтай болгох талаар лифт хариуцсан компани болох "Hyundai Elevator Mongolia" ХХК-д захиалга өгсөн ба 2020 оны 10 сарын 28-нд суурилуулахаар санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлж 12 дугаар сарын 09-ний өдөр суурьлуулсан.
- Иргэдэд үйлчлэх байрны нэг давхарт тактель зам байрлуулж хүртээмжийг нэмэгдүүлсэн.



- Иргэдэд үйлчлэх төв байрны 6 давхрын ариун цэврийн өрөөний угаалтуурыг намхан болгож хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн.



Төрийн банкны салбарт аяны туг аялууллаа.

Төрийн банкны Хан-Уул салбарт 2020.09.23-25-ны өдрүүдэд аяны тугийг аялуулсан. Тус хугацаанд Төрийн банкны "Хан-Уул салбар" нь харилцагчдад ая тухтай үйлчилгээ үзүүлэх хүртээмжтэй орчинг бий болгох зорилтын хүрээнд банкны үйлчилгээний цонх барьерыг стандартын дагуу намхан болгох ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр хийж гүйцэтгэсэн. Ингэснээр өндөр настан, хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ая тухтай үйлчлүүлэх боломжийг олгож байна.

Цаашид ХУД салбарын харъяа нэгжүүдийн барьерыг намхан болгох ажлыг үргэлжлүүлж байна. Мөн Төрийн банкнаас тусгай хэрэгцээт харилцагчиддаа зориулж **Карт** болон **Гялс банк** үйлчилгээгээр банкны бүх төрлийн үйлчилгээг хүссэн үедээ, хүссэн цагтаа түргэн шуурхай, цаг хугацаа хэмнэн авах боломжийг олгож байна.



"АПУ" ХК-тай хамтран гэрлэн дохионд дуут дохиолоч суурилуулах ажлыг "IN SOLUTION" ХХК-аар гүйцэтгүүлэн ажилласан. Дуут дохиолоч суурилуулах талаар Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр 8 байршилд суурилуулж, дуут дохиолочийн ашиглалтыг 1 жилийн хугацаанд гүйцэтгэгч байгууллага, түүнээс дараагийн хугацаанд Замын Хөдөлгөөний Удирдлагын төв хариуцахаар шийдвэрлэсэн.

1. Апу 4 замын уулзвар
2. Хан-Уул төвөр 4 замын уулзвар
3. Хуучин цагаан хаалганы 3 замын уулзвар
4. МИСургуулийн 4 замын уулзвар
5. Яармаг 1-р буудал
6. Яармаг 2-р буудал
7. Яармаг 3-р буудал
8. Яармаг 118-р сургуулийн буудлын гэрлэн дохионуудад тус тус дуут дохиолоч суурилуулалтаа байна.

Гэрлэн дохионы суурилуулалтын хүлээлцэх ажлыг Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс инженер гаргаж хүлээлцүүлэхээр болсон.

**Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд**

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 99, Чөлөөлөх дайны ялалтын 75, Цэргийн штабын 95 жилийн ойг угтан зохион байгуулж буй "Эх орноо магтан дуулья" хүүхдийн дууны анхдугаар уралдааны нэгдүгээр шатны шалгаруулалтыг

дүүргийн Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжаар 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Соёлын ордонд зохион байгуулсан.

"Эх орноо магтан дууля" хүүхдийн дууны анхдугаар уралдааны нэгдүгээр шатны шалгаруулалтын нээлтийн ажиллагаанд Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Н.Мэндбаяр, Цэргийн штабын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, дэд хурандаа Г.Жаргалсайхан, Боловсролын хэлтсийн Албан ба албан бус боловсрол хариуцсан мэргэжилтэн Б.Лхагвадэмбэрэл болон 15, 52, дугаар дунд сургууль, "Орхон Хасу" олон улсын дунд сургуулийн сурагчид, эцэг эхийн төлөөлөл хүрэлцэн ирж оролцсон.

Дууны уралдааны нэгдүгээр шатны шалгаруулалтын ерөнхий шүүгчээр Хан-Уул дүүргийн Соёлын ордны төгөлдөр хуур, ёочин хөгжмийн багш, МУСТА Р.Цолмонгэрэл, шүүгчээр Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин, МУСТА ахлагч С.Хүрэлбаатар, Боловсролын хэлтсийн Албан ба албан бус боловсрол хариуцсан мэргэжилтэн Б.Лхагвадэмбэрэл нар ажилласан.

Дээрх уралдаанд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 18 сургуулийн 52 сурагч оролцож, нэгдүгээр шатны шалгаруулалт амжилттай болж өндөрлөсөн.

Хүүхдийн дууны анхдугаар уралдааны нэгдүгээр шатны шалгаруулалтаас тэргүүн байранд "Шинэ өнөөдөр" дунд сургуулийн ба ангийн суралцагч Э.Дөлгөөн, дэд байранд ерөнхий боловсролын 60 дугаар дунд сургуулийн 11в ангийн суралцагч Б.Хонгорзул, 12в ангийн суралцагч Б.Эрдэнэцэцэг нар, гутгаар байранд ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 5а ангийн суралцагч А.Анар, "Орхон-Хасу" олон улсын дунд сургуулийн 7е ангийн суралцагч М.Эрдэм нар тус тус шалгарч Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдаж, 10 сурагчид нийслэлийн хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцох эрхийн батламжийг Цэргийн штабын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, төлөөлөлт, сургалтын офицер, дэд хурандаа Г.Жаргалсайхан гардуулж, амжилт хүссэн.



1.5 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн Засаг дарга болон Хан-Уул дүүргийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ 2020 оны 08 дугаар сард албажиж ирсэн тул гэрээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Хэрэгжилт 99.8 хувьтай байна.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс гэрээний хавсралтаар батлагдсан 59 арга хэмжээний биелэлт 2020 оны эхний хагас жилд 57.6 хувь, жилийн эцсийн байдлаар 92.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг 2020

оны 12 сарын 24-ний өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" хөтөлбөрөөр хамтран хэрэгжүүлсэн 9 зорилтын хэрэгжилт 2020 оны эхний хагас жилд 66.6 хувь, жилийн эцсийн байдлаар 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн

Дээрх бодлогын баримт бичгүүдийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 он үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.17 дахь хэсэг, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.1 дэх хэсгийг үндэслэн нийслэл, дүүргийн түүх соёлын дурсгалт газруудтай танилцах "Автобустай аялал"-ыг 10, 26, 59 дүгээр сургуулийн дунд ангийн сурагчдыг хамруулан 2020 оны 10 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус аялалаар Богд хааны ордон музей, Монголын үндэсний музей, Зөвлөлтийн дайчдын хөшөө, Танктай хөшөө, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудыг танилцуулсан.



Тохижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2020 оны А/161 дүгээр захирамжийн дагуу шинэ төрлийн коронавирусын халдвар болон Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг бусад халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэр хорооллын 13496 нүхэн жорлон, 8042 бохирын цооногийг ариутгаж, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/29 дүгээр захирамж, 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд зуслан ногоон бүсийн их цэвэрлэгээг 05 дугаар сарын 23 -ны өдөр зохион байгуулж, хяналт тавьж ажилласан.



Зуслан ногоон бүсийн их цэвэрлэгээнд Засаг даргын дэргэдэх хэлтсүүд, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 2419 аж ахуйн нэгж байгууллага, 55 СӨХ-ны 4982 ажилтан, албан хаагч, иргэд оролцож 66720 м² талбайгаас 64.7 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.



"Эко дүүрэг утаагүй орчин" аяны хүрээнд гэр хорооллын зорилтот бүлгийн 28 айл өрхөд нийт 140 шуудай сайжруулсан түлш олгох ажлыг зохион байгуулсан.



Ковид-19 цар тахлын хүнд үед дүүргийн Засаг даргын санаачлагаар 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хороодын зорилтот бүлгийн нийт 510 айл өрхөд 470,1 тн сайжруулсан түлш олгох ажлыг зохион байгуулсан.



Агаарын бохирдол үүсгэгч гэр хорооллын зуух, авто машины утаа, нам даралтат зуух зэрэг гол эх үүсвэрүүдийг хүний эрүүл мэндэд хортой байдлаар нь 3-15 кВт, 16-100кВт, 100-аас дээш гэж эрэмбэлэн тогтоож, 2020 оны 03 дугаар сард 3-15 кВт-ын хүчин чадалтай зуухны Утааны эх үүсвэрийн улсын тооллогоод 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хороодыг хамруулсан.

Тооллогоор нийт 12435 айл өрх тоологдож ердийн зуухтай 6071 өрх, сайжруулсан зуухтай 6364 айл өрх тоологдсон.

Дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт 16-100 кВт хүчин чадалтай нам даралтын зуухтай 329 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, байршлыг Google Earth програм дээр тэмдэглэн kmz файл үүсгэн Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар хүргүүлсэн.

Нам даралтын 16-100 кВт-ын хүчин чадалтай зуухтай 8 дугаар хорооны 5 өрх, 9 дүгээр хорооны 2 өрх цахилгаан халаалтад шилжсэн байна. Мөн 11 дүгээр хороо Зайсан орчмын Астра вилла хотхон, Женерал таун хотхон болон Зайсан энхжин хотхонууд төвлөрсөн шугамд бүрэн холбогдсон.



Соёл урлаг, сургалт: Монгол улсын Соёлын яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах зорилгоор “Соёлын цаг” хөтөлбөрийг 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл дүүргийн төвийн хэсэг, Нисэх Яармаг, алслагдсан хороодод 24 өдөр, өдрийн 3 удаагийн давтамжтай өөрсдийн тоглолтоо толилуулсан. Тоглолтыг 12.000 орчим иргэд үзэж сонирхсон байна.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хотын хөгжлийн индексийн www.happycity.mn програмыг шинээр нэвтрүүлсэн бөгөөд програм танилцуулах сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 09, 14-ний өдөр зохион байгуулж, 21 хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан, Зохион байгуулагчид хамрагдсан 2018, 2019 оны дата үзүүлэлтүүдийг оруулах ажил 100% хийгдэж дууссан.



Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн дүүрэг, хороодын Хөгжлийн нийгмийн ажилтнуудад зориулсан “Гамшгийн үед нийгмийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” сэдэвт сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс зохион байгуулж, сертификат олгосон.



Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Ноос ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч боловсруулах үйлдвэрүүд /"Шинэ эргэлт", "Эвсэг" "Кашимер холдинг"/-ийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах арга хэмжээнд 25 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж, үйлдвэрлэлийн орчинд хэрхэн ажиллах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны /ХАБ/ зааварчилгаа, техник, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, зориулалтын талаар мэдлэг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан.

1.6 Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан дэд хөтөлбөрүүдийн 2019 оны хэрэгжилтийн тайланг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч 2020.01.20-ны өдрийн 06/97 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

ХОРООНЫ ХӨГЖИЛ-ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ" ДЭД ХӨТӨЛБӨР

"Хорооны хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрөөс 2019 оны 4-р улиралд санхүүжүүлсэн Эрүүл мэндийн төвөөс хэрэгжүүлсэн "Диабетийн төв байгуулах" төсөл, Жирэмсэн эхчүүдийн кабинет тохижуулах" төслүүдийн хэрэгжилтийн тайланг авч Аж ахуйн тасагт хүргүүлсэн.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан "Хороодын хөгжил, төрийн үйлчилгээ" хөтөлбөрийн салбар зөвлөлийн ажлын хэсгийг 3 удаа хуралдуулан 95.3 сая төгрөгийн 5 төслийг хэлэлцүүлэн, ажлын хэсгээр дэмжин дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан дэмжүүлж амжилттай хэрэгжсэн. Үүнд:

1. 17-21 дүгээр хороодын иргэдэд иргэний үнэмлэх, үл хөдлөх хөрөнгийн хуулийн этгээдийн бүртгэлийн талаар зөвлөмж бэлтгэн хүргэх /9.8 сая төгрөг/
2. 17-21 дүгээр хороодыг баннер, нэг удаагийн амны хаалт, бээлий, үзэг балаар хангах /5.2 сая төгрөг/
3. Ахмадын баярыг 21 хороонд тэмдэглэн өнгөрүүлэх /63.5 сая төгрөг/
4. Цагдаагийн газрын, хороодод эргүүлээр ажиллах автомашинд өвлийн дугуй худалдан авах /4 сая төгрөг/
5. БиокOMBинатын хүүхдийн эмнэлэгт шаардлагатай гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх /12.7 сая төгрөг/

"ЗӨВ ХҮҮХЭД-ЗӨВ ИРЭЭДҮЙ" ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ:

Хэрэгжүүлсэн төсөл үйл ажиллагааны тоо	Батлагдсан төсөв	Зарцуулсан төсөв	Төсвийн зарцуулалтын хувь
1	100,000,000	12,699,500	12.6%

- Дүүргийн Засаг даргын "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлэх тухай 2020 оны

02 дугаар сарын 19-ний өдрийн А/93 дугаар захирамжийг батлуулж тайлант хугацаанд тус хөтөлбөрөөс санхүүжилт хүссэн нийт 6 төсөл хүлээн авч, 3 төсөл арга хэмжээг хөтөлбөрийн Санбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжүүлж дараагийн шатны хурлаар хэлэлцүүлсэн.

➤ “Биокомбинатын хүүхдийн эмнэлэгт гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах” төслийг дэмжин 12,699,500 төгрөгийн санхүүжилтээр 12 дугаар хороонд БНХАУ-ын Энхтайван хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр баригдсан 50 ортой хүүхдийн эмнэлэгийн гал тогооны хоол үйлдвэрлэлд шаардлагатай 29 төрлийн 85 ширхэг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авч хүлээлгэн өгсөн.



1.7 Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг улирал тутам тайлагнаж ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар Засаг даргын хэлтэс, алба, байгууллагуудаас холбогдох заалтуудын биелэлтийг авч нэгтгэн, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 91.4 хувьтай хэрэгжсэнийг ДИТХ-д өргөн барьж, ДИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаар тогтоолоор хэрэгжилтийн тайланг хэлэлцээд “хангалттай” дүгнүүлсэн.

Дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/406 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, тус ажлын хэсгээр Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, ДИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар тогтоолоор батлуулсан.

Төрийн Аудитын байгууллагын хяналт, шалгалтын хүрээнд дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтийн зардлын талаарх судалгааг гарган Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж, тайлагнасан.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудаас:

Эрүүл мэндийн чиглэлээр:

“Дүүргийн Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана” заалтын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

➤ Дүүргийн Эрүүл мэндийн төвийн эрчимт эмчилгээ, сэргээн засах, нүд, зүрх судас, лабораторт 70,0 сая төгрөгийн нийт 21 нэр төрлийн 26 ширхэг тоног төхөөрөмж;



➤ Яармагийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт 18 нэр төрлийн 115 ширхэг нийт 50,200,000 төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж;



➤ Шинээр байгуулагдсан 15, 17, 19, 20, 21 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвд 50,0 сая төгрөгийн 8 нэр төрлийн 27 ширхэг тоног төхөөрөмж /нярайн шарлалт хэмжигч аппарат, ургийн доплер, компьютер, принтер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат/;

Олон улс болон төрийн бус байгууллагын чиглэлээр:



➤ "Дэлхийн зөн Монгол" Олон улсын байгууллагын Хан-Уул орон нутгийн хөтөлбөрөөс 7, 8, 9, 10, 12, 13, 16 дугаар хорооны гэрээр айлчлагчдыг чадавхжуулах зорилгоор "Туршлага солилцох аялал"-ыг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.

Тус аялалд 6 хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан, 7 дугаар хорооны Засаг дарга, 46 хэсгийн ахлагч тус тус хамрагдсан.



Мөн "Дэлхийн зөн Монгол" ОУБ, "Хан-Уул орон нутгийн хөтөлбөр"-өөс 2020 оны ажлыг дүгнэх, 2021 онд хийх ажлын саналыг авах зорилгоор зорилтот 7 хороо, 7 сургууль болон дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадтай 09 дүгээр сарын 07-ны өдөр уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах санал авсан.



Монгол улсын хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд, гэр бүлийг дэмжих хамтын ажиллагааны санамж бичгийг "Тайванийн хүүхэд, гэр бүлийг дэмжих сан" Олон улсын байгууллагатай 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдөр байгуулж, 09 дүгээр сарын 22-ны өдөр баталсан.

Дээрх санамж бичгийг байгуулснаар 9 чиглэл бүхий ажил хийгдэх юм.



"Гүүд нейборс" Олон улсын байгууллагаас өнгөрсөн хугацаанд хийсэн ажлыг дүгнэх, 2021 онд хийх ажлын саналыг авах зорилгоор зорилтот 3 хороо, зорилтот 2 сургууль, 4 цэцэрлэг болон дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадтай 09 дүгээр сарын 23-ны өдөр уулзалт зохион байгуулж хамтран ажиллах саналыг авсан.



Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:

Дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс 2020 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр 21 хорооны 500 залууг хамруулсан "Эко дүүргийн хөгжилд залуучуудын оролцоо" чуулганыг зохион байгуулж, залуучуудад тулгамдаж буй асуудал болон залуучуудын оролцооны чиглэлээр илтгэл хэлэлцүүлж, гаргасан санал санаачлагыг, дүүргийн удирдлагуудад уламжилсан.



Залуу үеийнхэнд эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, төр улсаа эрхэмлэн дээдлэх, эх орон ард түмнийхээ өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан чин шударгаар амьдрах, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр "Иргэний андгай өргөх ёслол"-ын үйл ажиллагааг зохион байгуулж, 2020 онд өрөнхий боловсролын сургуулийн 16 нас хүрсэн 135 сурагч андгай өргөж оролцсон.

Сурагчид Монгол Улсын иргэний үнэмлэхээ НИТХ-ын Төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлангийн дурсамжийн хамт гардан авсан бөгөөд Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн газрын дарга О.Сэлэнгэ "Эерэг сэтгэлгээ ба нийслэлийн иргэний 10 зөв дадал" илтгэл тавьж оролцсон.



Үндсэн чиглэлийн хүрээнд хийгдсэн ажлуудаас:

"Дүүргийн ногоон байгууламжийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчноо хамгаалах үйлсэд хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн 5,10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн бямба гараг бүрийг "Мод тарих үндэсний өдөр" болгон зарласан байдаг.

Дүүргийн хэмжээнд 5, 10 дугаар сард "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 548 айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын 2238 иргэн, албан хаагчид оролцож нийт 24624 ширхэг мод бут сөөг тарьж, 10223 м.кв талбайг шинээр зүлэгжүүлсэн.



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас дүүргийн 21 дүгээр хороо Нисэхийн тойргоос урагш 1000 ширхэг нарс модыг шинээр тарьж, 159931 м² талбайг зүлэгжүүлсэн.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/29 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан даалгавраар хороодын Засаг дарга, холбогдох хэлтэс албад, аж ахуйн нэгж байгууллагуудыг үүрэгжүүлж "Хоггүй шинэлцгээ" аяныг 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулж, хяналт тавьж ажилласан.



Аяны хүрээнд Засаг даргын Тамгын газраас удирдлага зохион байгуулалтын талаар хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулсан "Хоггүй шинэлцгээ" аян зохион байгуулах удирдамжийн дагуу хороодын Засаг дарга, холбогдох хэлтэс, албадын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж аяны явц болоод цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцэж, цэвэрлэгээ үйлчилгээ, хог тээвэрлэлтийг эрчимжүүлэх, хяналт тавьж ажиллах, иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх, нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, анхаарч ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

Аяны хүрээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 02 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулж, хяналт тавьж мэдээ, тайланг нэгтгэж 2020 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Шуурхай удирдлага зохицуулалтын төвд dispatcher_ub@yahoo.com цахим хаягаар хүргүүлсэн. Дээрх цэвэрлэгээнд Засаг даргын дэргэдэх хэлтсүүд, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 2419 аж ахуйн нэгж байгууллага, 85 сууц өмчлөгчдийн холбооны 4982 ажилтан албан хаагч, иргэд оролцож 91020 м² талбайгаас 127.0 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Бүдүүвч. Бүх нийтийн их цэвэрлэгээний тоон үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Цэвэрлэгээнээс гарсан хогны хэмжээ	тонн	127.0
2	Цэвэрлэгээ хийсэн нийт талбай	м.кв	91020
3	Хогны машины рейс	тоо	99
4	Цэвэрлэгээнд оролцсон байгууллагын тоо	тоо	2419
4.1	Төрийн /Дүүрэг, хороо, Эмнэлэг, цагдаа гэх мэт/	тоо	99
4.2	Бизнесийн /үйлдвэр, зах, худалдааны төв, дэлгүүр, ТҮЦ, үсчин, гоо сайхан, баар, цайны газар г.м/	Тоо	460
4.3	Ерөнхий боловсролын сургууль/ бара сургууль/	тоо	9
4.4	Их дээд сургууль	тоо	8
4.5	Цэцэрлэг	тоо	20
4.6	СӨХ	тоо	85
4.7	Бусад	тоо	1738
5	Цэвэрлэгээнд оролцсон хүний тоо	хүн	4982

5.1	Төрийн /Дүүрэг, хороо, Эмнэлэг, цагдаа гэх мэт/	хүн	889
5.2	Бизнесийн /үйлдвэр, зах, худалдааны төв, дэлгүүр, ТҮЦ, үсчин, гоо сайхан, баар, цайны азар г.м/	хүн	698
5.3	Ерөнхий боловсролын сургууль	хүн	395
5.4	Их дээд сургууль	хүн	31
5.5	Цэцэрлэг	хүн	1241
5.6	СӨХ	хүн	170
5.7	Бусад /иргэн/		1558
6	Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсээс мэдэгдэх хуудас болон торгууль тавьсан ААНБ	тоо	0
7	Мэдэгдэх хуудас олгосон	тоо	1092
8	Торгуулийн арга хэмжээ авсан	тоо	0
9	Торгуулийн хэмжээ	төг	0

Зураг. Аж ахуйн нэгж байгууллагууд бүх нийтийн их цэвэрлэгээнд орчны 50 м хүртэл талбайн хог хаягдал, цас мөс хөлдүүсийг цэвэрлэх, байгууллагын шатны бариул, орцыг угааж, ариутгах арга хэмжээ авсан.



Аяны үргэлжлэх хугацаанд “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ, “Хан-Уул Арго” ОНӨААТҮГ нэмэлт хуваарийн дагуу ажиллаж орон сууц болон гэр хороолол, аж ахуйн нэгж байгууллагуудын 9434,8 тн хог хаягдлыг 3762 рейсийг ачиж тээвэрлэсэн.



Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран шинээр баригдаж байгаа барилгын ажлуудад хяналт тавьж, хашаанд ил задгай хуримтлуулсан хог хаягдлыг бүрэн тээвэрлүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нисэх 81, 86 дугаар байрны гадна хуримтлагдсан их хэмжээний барилгын хогийг гүйцэтгэгч байгууллага “Монгол Од” ХХК-д шаардлага тавьж ачуулах арга хэмжээ авсан. Мөн 11 дүгээр хороо Рома хотхоны барилгын компани болох “Рома инвестмент” ХХК-д албан мэдэгдэл хүргүүлж дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай 2017 онд байгуулсан хог тээвэрлүүлэх гэрээг шинэчлүүлж, хог тээвэрлэлтийн давтамжийг нэмэгдүүлэх, хотхоны хог хаягдлыг тээвэрлүүлэх арга хэмжээ авсан.



Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Дүүргийн "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын цэгт 24 үйлдвэрлэл эрхлэгчийг түрээсийн төлбөргүйгээр байршуулан нийт 7,3 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжин ажилласан. Мөн борлуулалтын цэгийн үйл ажиллагааг <http://www.jijigdund.mn/> сайтаар дамжуулан сурталчилж, "Хан-Уул брэндиг" бүхий 7 үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүнд "QR код" үүсгэн хаягжуулсан.



ХХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй 137 хоршооны нарийвчилсан судалдаг гаргаж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 29 хоршоонд хөгжлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

ХХААХҮЯ-аас уламжлал болгон зохион байгуулдаг "Улаанбаатар түншлэл" "Намрын ногоон өдрүүд 2020" "Ноос ноолуур арьс ширний бүтээгдэхүүн 2020" зэрэг үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 120 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж хамтран ажилласан.



"Ковид-19" халдварын хорио цээрийн дэглэмтэй холбоотой үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 11 байршилд нөөцийн мах худалдаалах ажлыг зохион байгуулж, **89.8** тонн мах худалдан борлуулсан.



Малчдын хөдөлмөрийг үнэлэх, урамшууллын тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 221, 222 дугаар тогтоолоор "Нийслэлийн тэргүүний фермер", "Нийслэлийн тэргүүний тариаланч"-аар 3 иргэнийг дэмжин, шагнаж урамшуулсан.

Улсын Их хурлын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолын дагуу ноолуурын урамшуулалд хамрагдах 108 өрхийг хамруулсан.

Хаврын улиралд махны үнийн тогтвортой байдлыг хангах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 28 хүнсний дэлгүүр, 13 сүлжээ дэлгүүрээр 188.7 тонн, өргөтгөсөн худалдаагаар 486.5 тонн, дүүргийн хэмжээнд нийт 675.2 тонн нөөцийн мах борлуулж, хяналт тавьж ажилласан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1 Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар биелэлтийг тайлагнах нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 3 тогтоол, 13 заалтын биелэлтийг нэгтгэн, батлуулж, 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 04/542 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

/Биелэлтийн дундаж-32.6%/

2020 оны эхний хагас жилд тайлагнах 5 төрлийн 11 захирамжлалын баримт бичгийн холбогдох 28 заалтуудыг хяналтад авч, биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг болон Засаг даргын дэргэдэх 26 хэлтэс, албадаас нэгтгэн, хяналт шинжилгээ хийлгүүлэн 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 04/542 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. **/Биелэлтийн дундаж-68.1%/**

2020 оны 3 дугаар улирлын байдлаар биелэлтийг тайлагнах 8 тогтоол, 16 заалтын биелэлтийг нэгтгэн, батлуулж, 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 04/1676 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. **/Биелэлтийн дундаж-82%/**

2020 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тооцож, тайлагнах 15 тогтоолын 30 заалтыг хяналтад авч, дэргэдэх 26 хэлтэс, албадаас авч нэгтгэн, хяналт шинжилгээ хийлгүүлэн, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. **/Биелэлтийн дундаж-93.2%/**

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ	ҮНЭЛГЭЭ
2020 оны жилийн эцсийн байдлаар			
Монгол Улсын хууль	1	1	100%
Улсын Их Хурлын тогтоол	1	1	90%
ҮАБЗ-ийн зөвлөмж	1	1	90%
Ерөнхийлөгчийн зарлиг	1	1	90%
Засгийн газрын тогтоол	5	24	93.9%
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	2	90%
ДҮН	15	30	93.2%

Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийн холбогдох 28 заалт, нийслэлийн Онцгой комиссын 2 хуралдааны тэмдэглэлийн 12 заалт, Нийслэлийн Засаг даргын 3 хуралдааны 9 заалтын биелэлтийг тус тус хяналтад авч www.monitoring.ub.gov.mn програмд хугацаанд нь тайлагнасан. /Биелэлтийн дундаж-91%/

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын төсөлд тусгах саналыг нэгтгэн, дүүгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 04/201 дүгээр албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУДААС:

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 2 удаагийн зарлигаар Төрийн дээд одон Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 50 , Алтан гадас одонгоор 140, Цэргийн гавьяаны одонгоор 4, Хөдөлмөрийн хүндэт медалиар 160, Цэргийн хүндэт медалиар 2, нийт 356 иргэн шагнуулж, шагнал гардуулах ёслолын арга хэмжээг тухай бүр зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоол "Төрөөс биеийн тамир спортын талаар баримтлах бодлого"-ын хүрээнд Дэлхийн алхалтын өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Эрүүл мэндийн төв, дүүргийн Биеийн тамир, спорт хороо хамтран "Идэвхтэй алхалтын 10 хоног" аяныг 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан. 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Биеийн тамир, спортын хорооноос дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, СӨББ-ын ажилтан албан хаагчдын дунд "Дасгал хөдөлгөөнийг дадал болгоё", "Ажлын байрны дасгал" сургалтыг зохион байгуулж, ажилтан, албан хаагчдын биеийн бүтцийг ТАНИТА аппаратаар оношилж зөвлөгөө өгсөн. 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн өглөөний 07 цагт дүүргийн хэлтэс, албадын ажилтан албан хаагчид, СӨББ-ийн багш ажилчид төв цэнгэлдэх хүрээлэнгээс дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байр хүртэл явган алхалтыг хийсэн. Тус 10 хоногийн аяны хүрээнд дүүргийн ажилтан албан хаагчид, иргэд ГЭР-АЖИЛ- ГЭР хооронд алхаж, ажил дээрээ цахилгаан шат ашиглахгүй байх, идэвхитэй оролцсон байгууллага, хувь хүн тус бүрийг шалгаруулан нэг сар үнэ төлбөргүй хичээллэх "ФИТНЕСС ЭРХИЙН БИЧИГ"-ээр шагнаж урамшуулсан.



Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, 04 дүгээр албан даалгавар, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны А/451 дүгээр захирамжаар Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвар, томуу томуу төст өвчний өвчлөл, тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 28.060.000 төгрөгийг шийдвэрлэж хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйлтийн хэрэгслийг худалдан авч хороодын ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг ханган ажилласан.



Биеийн тамир, спортын чиглэлээр: Нийслэлийн Засаг даргын 2020.01.20-ны өдрийн А/32 дугаар тушаалаар "Мөнгөн Улаанбаатар-2020" өвлийн спортын наадмын "Цасны баяр"-ын үйл ажиллагааны бэлтгэл ажлыг бүрэн хангасан бөгөөд уг арга хэмжээ "Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор цуцлагдсан.



Эрүүл мэндийн чиглэлээр: Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамж буюу "Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Засаг даргын Тамгын газар, 17 дугаар хороотой хамтран 2020 оны 03 дугаар сарын 1-ний өдөр Масктай машин өргөтгөсөн эргүүлийг хийлээ. Монголын "Пажио клуб" болон "Санхими" ариутгал халдваргүйлтийн компани нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжиж хамтран ажилласан. Нийт 10 байршилд уриалга зөвлөмжтэй самбар байршуулж, давхардсан тоогоор 561 иргэнд амны хаалт, нэг удаагийн бээлий, 13 аж ахуй нэгж байгууллагад ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн

"Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 643 аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, хороод, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийслэлийн Засаг даргын 2020 оны 108 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны 41 дүгээр захирамж, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02-02/328 албан мэдэгдлийг, 3000 ширхэг постер, 10.300 ширхэг зөвлөмж мэдээллийн хамт хүргүүлсэн. Мөн дүүргийн Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 250 гаруй хүүхдэд урьдчилан сэргийлэх зорилгоор амны хаалт өгсөн.



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 187 дугаар тогтоолоор батлагдсан "Гэртээ харих зам" орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх нийслэлийн хөтөлбөрийн 2016-2020 оны хэрэгжилт, биелэлт /5 жилээр/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих" нийслэлийн дэд хөтөлбөрийг 2018-2020 онд

хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлтийг тус тус гаргаж Нийслэлийн Нийгмийн халамжийн хэлтэст хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39, 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 01, 04 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын А/108, А/436, дүүргийн Засаг даргын А/41 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

➤ Нийслэлийн ЗДТГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/846 "Үүрэг чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийн хүрээнд дүүргийн Бүртгэлийн хэлтэс, Биеийн тамир, спортын хороо, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Ерөнхий боловсролын 15, 52, 130 дугаар сургууль, 218 дугаар цэцэрлэгийн удирдлагууд хамтран "Covid-19" буюу шинэ төрлийн Коронавирусын халдвар, томуу, томуу төст өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх эргүүлийн ажилд хуваарь гарган ажилласан.

Хуваарийн дагуу нийт давхардсан тоогоор 382 албан хаагч ажиллаж, 8492 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, давхардсан тоогоор 2242 аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалтыг хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.



Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/577 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2017 оны А/351 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн өмчийн 18 сургууль, 29 цэцэрлэгийн эмч нарт томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах талаарх сургалтыг Эрүүл мэндийн төвтэй хамтран 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан.



Соёл, урлагийн чиглэлээр: Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1106 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт "Номын баяр-2020" арга хэмжээг "Шинэ Хан-Уул" цэцэрлэгт хүрээлэнд 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 09:00-18:00 цагийн хооронд зохион байгуулсан. Номын баярын арга хэмжээнд нийт 1000 орчим иргэд,



оюутан залуус, сурагчид хамрагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: "Гэртээ харих зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэд, 12 дугаар хорооны хогийн цэг дээр ажиллаж, амьдарч буй иргэдийг бүртгэлжүүлэх, мэдээллийн санг шинэчлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр дүүргийн 10 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн туслах байранд зохион байгуулсан.

Тус арга хэмжээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төв, Улаан загалмайн хороо, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс хамтран ажиллаж, нийт 87 тэнэмэл иргэнийг эрүүл мэнд, сүрьеэгийн үзлэгт хамруулж, хувцас тарааж, өдрийн хоолоор үйлчлэн бүртгэлжүүлж ажилласан. Сүрьеэтэй шинээр 1, эмэнд тэсвэртэй 2 иргэнийг илрүүлж дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Өлзийт асар" Төрийн бус байгууллагад байршуулан эмчлүүлсэн. Тэмбүүтэй 11 иргэн илэрч тэдгээрээс архины хамааралтай 8 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мааньт дахь архины албадан эмчилгээнд шилжүүлж, 3 иргэнийг хорооны өрхийн эмнэлэг, цагдаагийн байгууллага хариуцан эмчилж байна.



Дүүргийн Засаг даргын 2020 оны А/41, А/201 дүгээр захирамжийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

➤ "Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс нийт 57.870.000 төгрөгийг төсөвлөж аж ахуй нэгж байгууллагууд халдваргүйтэл түр хийх заавар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж буюу гарын авлагыг 5000 ширхэг, Ковид-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий постер 3000, брошур 10500 ширхэг, 1000 ширхэг амны хаалт, гар ариутгагч 250 ширхгийг тус тус тараасан бөгөөд Төрийн үйлчилгээний байгууллагууд болох Засаг даргын дэргэдэх хэлтэсүүд /Нэг цэгийн үйлчилгээний Мишээл төв, дүүргийн иргэдэд үйлчлэх төв байр, хороодын нэг цэгийн үйлчилгээ, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсүүдийн нэг цэгийн үйлчилгээ гэх мэт байгууллагуудад тарааж иргэдэд мэдээлэл хүргэсэн.



Амны хаалтны хүрэлцээ хангамж муу байгаатай холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газраас 1500 ширхэг амны хаалтыг дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ-үүдээр үйчлүүлж буй хүүхдүүдэд зөвлөмжийн хамт тараасан.



"Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдалд хяналт тавьж 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн газар, 6 дугаар хорооны иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний байр, 6 дугаар хорооны Чанд-Авиа өрхийн эрүүл мэндийн төвд хяналт шалгалт хийсэн.



"Самхими" ХХК-тай хамтран дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байранд 2020 оны 02 дугаар сарын 12 өдөр, хороодод 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн хуваарийн дагуу ариутгал халдваргүйтэл хийх төлөвлөгөө гарган ажиллаж байна.



"Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт" /хэсэгчлэн/ шилжүүлсэнтэй холбоотой эрсдэлтэй бусад ажиллаж байгаа Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг байгууллагуудын ажилтан, албан хаагчдад 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр дүүргийн Засаг даргын нөөцөөс шаардлагатай хамгаалах хувцас, нэг удаагийн бээлийгээр хангасан.



"Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх, тусгай үүргийн онгоц болон орон нутгийн боомтуудаар нэвтэрсэн зэрэг бусад шалтгаанаар тусгаарлалтаас гарч гэртээ өөрийгөө тусгаарлаж байгаа иргэдэд хяналт тавих үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын А/201 дүгээр захирамжаар байгуулсан. Захирамжийн

хэрэгжилтийг хангах хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүн 21 хороодын Засаг дарга нартай цахим хурал хийж гэртээ өөрийгөө тусгаарлаж буй иргэдэд хэрхэн хяналт тавих талаар зааварчилгаа өгсөн.




Дүүргийн Засаг даргын 2020 оны А/196 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийн агуулахад хадгалагдаж байсан хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийх ажлыг зохион байгуулсан.

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр: УБХЕМ-н "Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай" А/134 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу согтууруулах ундаа худалдах худалдааны 85, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 39, нийт 124 аж ахуйн нэгжид дүүргийн Цагдаагийн газар, Татварын хэлтэстэй хамтран хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулан ажиллалаа.



"Хан-Уул дүүргийн Хүнсний дэлгүүрүүд" Дүүргийн онцгой комисс хүнсээр хангах албаны түр пэйж хуудас нээн 600 гаруй худалдаа эрхлэгчдийг нэгтгэн, давхардсан тоогоор 50 гаруй зөвлөмж, зааврыг бэлтгэн хүргэж цаг үетэй холбоотой мэдээ, мэдээллээр ханган, санал хүсэлтийг авч, хэрэгжүүлэн холбогдох албан тушаалтанд уламжилж ажилласан.



Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны талаар:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/1358 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/60 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг давхар

эрхэлдэг барилгын компани, хувийн орон сууцны контор, хууль бусаар байгуулагдсан Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.

2020 оны 03 дугаар сарын 29-ний байдлаар 35 сууц өмчлөгчдийн холбоо, 5 орон сууцны конторын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хяналт шалгалтын тайлан мэдээ, илтгэх хуудсыг нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.



Цэвэрлэгээний хог хаягдал ачилт, тээвэрлэлт:

Бүх нийтийн их цэвэрлэгээг 10 удаа зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 8595 аж ахуйн нэгж байгууллага, 37781 хүнийг хамруулан, гадна орчны цэвэрлэгээг хийлгэж, 945.2 тонн хог хаягдлыг 237 рейсээр төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэсэн.



Ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2020 оны А/109 дүгээр захирамжийн дагуу 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 16 автобусны буудал, 50 ус түгээх цэг, орчны бохирдол ихтэй нийтийн эзэмшийн гудамж талбайн 43 байршлын нийт 25557 м.кв талбайд ариутгал халдваргүйтгэл хийснээр эхний ээлж бүрэн дууссан.



Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/373 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч 21 хорооны орон сууц, гэр хорооллын гудамж, талбайг тусгай зориулалтын 7 автомашинаар ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажилласан.

Нийт хороодыг 7 бүсэд хувааж, хуваарийн дагуу хороо тус бүрээс Засаг дарга, хэсгийн ахлагч нар гудамж талбайгаа зааж өгч, хяналт тавьж ажилласан.

Ариутгалын бодис: Гипохлоридын уусмал 0.02%

Нийт 21 хорооны 700 гаруй гудамж талбайгаар 1648 км³ ариутгал халдваргүйтгэл хийсэн.



Хуваарийн дагуу 3 дугаар сарын 28, 29-ний өдөр 1, 2, 3, 4 дүгээр хорооны 49 тоглоомын талбай, бичил цэцэрлэг, 3 гүүрэн гарц, 120 мянгат цэцэрлэгт хүрээлэн, ажилчны алдар талбай, жаргалант үйлчилгээний төв, нэхмэлийн байр орчим, 10 автобусны буудал, 30 хогийн цэг, орчны бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 4160 м.кв талбайг ариутгаж халдваргүйтгэсэн.



Дүүргийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/104 дүгээр захирамжийн дагуу болзошгүй шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үерийн хамгаалалтын далан суваг, ус нэвтрүүлэх хоолойд хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэж, ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулсан.



Байгаль орчин агаарын бохирдлын чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2019 оны А/363 дугаар захирамжийн дагуу “Шуурхай штаб” байгуулж, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын удирдлагуудаар ахлуулан 130 удаагийн ээлжинд давхардсан тоогоор 700 албан хаагчийг 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэхээр шуурхай албаны жолооч, автомашины хуваарийг баталж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Тус шуурхай штаб нь түүхий нүүрсийг хориглох, сайжруулсан түлшний хэрэглээтэй холбоотой нийслэлээс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг 24 цаг тутамд гаргаж Нийслэлийн онцгой комисс, Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв ОНӨААТҮГ-т тогтмол хүргүүлж ажилласан.

Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд анхлан гэр хорооллын **11783 өрхөд** “Сайжруулсан хатуу түлшийг ашиглах **аргачлал, зөвлөмж, сэрэмжлүүлэг**”-ийг 3 удаагийн давтамжтайгаар 72 цагийн дотор бүрэн хүргэж иргэд, олон нийтийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.



2020 оны 01 дүгээр сард дүүргийн 9, 10, 16 дугаар хороодын 4820 айл, 03 дугаар сарын 28, 29-ний өдөр үлдсэн хороодын 7180 айл өрхөд, нийт 12000 ширхэг “Угаар мэдрэгч”-ийг, хэрэглэгчдэд зориулсан гарын авлагын хамт тараасан. Мөн 24000 ширхэг “Угаарын хордлогын үед үзүүлэх анхны тусламж” брошурыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэсэн.



2020 оны I улиралд авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоод /Өлзийт 1, Өлзийт 2, Морингийн даваа, Таван толгойн пост/-оор 15755,6 тн түүхий нүүрс зөвшөөрөлтэй нэвтэрч, 7672,7 тн түүхий нүүрс дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч, зөвшөөрөлгүй тээвэрлэсэн

6,8тн 36 шуудай түүхий нүүрсний тээвэрлэгч этгээдэд холбогдох арга хэмжээг авч, Амгалан дулааны станцад буулгуулж ажилласан. Өлзийт 1 постоор 17,6тн түүхий нүүрс маршрут өөрчилж тээвэрлэсэн байна.

Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтарч магадлан итгэмжлэх хяналт шалгалтаар 35 халаалтын зууханд 2 удаа шалгалт хийж, 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн төвлөрсөн дулааны шугамд холбогдох талаар мэдэгдсэн. Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс Нийслэлийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын баталсан хуваарь, удирдамжийн дагуу агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад байнгын хяналт, шалгалт хийж, түүхий нүүрс төлсөн 8 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 4,950,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулсан.



12, 13, 14 дүгээр хороодыг 2020-2021 оны халаалтын улиралд сайжруулсан түлш түлэх, агаарын чанарыг сайжруулах бүсэд шинээр нэмж оруулсан.

Дүүргийн 6 дугаар хороо Яармаг, 10 дугаар хороо Морингийн даваа, 12 дугаар хороо Биокомбинат гэсэн 3 байршилд хангамжийн бааз байгуулсан.

"Таван толгой түлш" ХХК-д 73 иргэн түлш борлуулалтын цэг ажиллуулах хүсэлт хүргүүлсэнээс 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хороодод 58 борлуулалтын цэг ажиллаж байна. Тус цэгүүдэд түлшний нөөц тасраагүй, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Дүүргийн 6 дугаар хороо, Энканто хангамжийн баазад 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1567 тн түлш, 10 дугаар хороо Морингийн давааны хангамжийн баазад 108 тн түлш, 12 дугаар хороо Дөл хангамжийн баазад 585.75 тн түлш, нийт дүүргийн хэмжээнд 2260.75 тн түлшний нөөцтэй байна.



Хангамжийн бааз



2.2 Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажилтай холбоотой мэдээлэл:

Нэг хот-Нэг стандарт болзолт уралдааны хүрээнд:

Дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/88 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Нэг хот- нэг стандарт" болзолт уралдааны хүрээнд тус дүүргийн 1,2,10-р хороодын хэсгийн ахлагчдын багийн ажил, 7,14,17,18, 20-р хороодын 1-р улиралд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2020 оны 03 дугаар 26-нд хүлээн авч хуралдан "Тэргүүний хороо"-оор 7, 18, 20 хороодыг, "Хэсгийн ахлагч нарын тэргүүний баг"-аар 2, 10 дугаар хороог шалгаруулан тайланг, ЗДТГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 04/584 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Нэг хот-Нэг стандарт болзолт уралдааны нэгдүгээр улирлын дүнг дүгнэх тухай" А/525 дугаар захирамжаар 2020 оны 1 дүгээр улирлын "Тэргүүний хороо"-оор Хан-Уул дүүргийн 7 дугаар хороо, "Хэсгийн ахлагч нарын тэргүүн"-ий багаар Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо тус тус шалгарсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн "Нэг хот-Нэг стандарт болзолт уралдааны 2 дугаар улирлын үр дүнг дүгнэх тухай" А/1005 дугаар захирамжаар 2020 оны II улирлын "Тэргүүний хороо"-оор Хан-Уул дүүргийн 3, 15 дугаар хороод, "Хэсгийн ахлагч нарын тэргүүний баг" -аар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо шалгарсан.

Нийслэлийн Засаг даргын А/1343 дугаар захирамжаар батлагдсан "Нэг хот-Нэг стандарт" болзолт уралдааны зөрчлийн бүртгэл, хяналт, удирдлагыг иргэдийн амьдрах орчны зураглалын систем /manaikhoogo.mn/-ийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Энэхүү системийн өргөтгөл болох ухаалаг гар утсанд зориулсан програм хангамж ашиглалтад орсонтой холбоотойгоор програм хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглахтай холбоотой сургалтыг нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Дээрх сургалтад нийт 18 Зохион байгуулагч оролцсон.

"Нэг хот нэг стандарт" зорилтот жилийн хүрээнд хотын стандарт, норм, дүрмийг аж ахуйн нэгж, байгууллагуудад танилцуулах уулзалтыг 2 удаа зохион байгуулж 223 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ, Худалдаа, хоол үйлдвэрлэл, аялал жуулчлал, авто үйлчилгээ, ахуйн үйлчилгээний салбарын 1013 иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн фото зураг, кадастрын зургаар мэдээллийн сан үүсгэсэн.



Тохижилт нийтийн аж ахуйн чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын А/239 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийж зөрчил арилгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлыг 6 удаа зохион байгуулж, 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 15-ний өдөр хүртэл төлөвлөгөөний дагуу ажиллан, Нийслэлийн мэргэжлийн хяналтын хэлтэс, Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, нийслэл, дүүргийн Газрын зохион байгуулалтын



албаны 58 мэдэгдэл, 40 шаардах хуудсыг зөрчилтэй 72 аж ахуйн нэгж байгуулага, иргэнд хүргүүлсэн.

Дээрх ажлын хүрээнд мэдэгдлийн дагуу засварлах, шинэчлэх ажлыг хийж байгаа 45 иргэн аж ахуйн нэгж байна. Ашиглахгүй удсан, стандарт шаардлага хангахгүй 17 хашааг албадан буулгах ажил хийгдсэн.

3-р хороо "Витафит" ХХК



1-р хороо "Ус дулаан дамжуулах 88 төв



Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд ашиглах боломжгүй 4 хүүхдийн тоглоомын талбайг буулгаж, аюулгүй байдлыг хангуулсан. 28 байршилд тоглоомын талбайн өнгө үзэмжийг сайжруулах, 3 дугаар хороо Эрчим хүчний гудамжинд нийтийн эзэмшлийн талбайд 250 ширхэг мод бут сөөг, 1 дүгээр хорооны 14, 15, 16, 17 дугаар байрнуудын гадна талбайд цэцэг тарих, зүлэгжүүлэх ажлууд тус тус хийгдсэн.



Явган замын орц, гарц хаасан 2 байршилд чөлөөлсөн



2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Чингисийн өргөн чөлөө, наадамчдын зам, Нисэх, Их монголын гудамжны төв зам дагуух 38 таггүй гэрэлтүүлгийн шонг тагжуулж 31 түгжээгүй тагийг бэхлэж нийт 69 гэрэлтүүлгийн таг засварын ажлыг гүйцэтгэж аюулгүй байдлыг хангасан.



Хаягийн байгууламжийн чиглэлээр: Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, хана, гэрэлтүүлгийн шон дээр зөвшөөрөлгүй байршуулсан 33 ширхэг худдаасан хэвлэл, 72 ширхэг төмөр самбар, 26 аж ахуйн нэгж байгууллагын стандартын шаардлага хангаагүй хаягийн

байгууламж, 4 ширхэг А самбар нийт 143 аж ахуйн нэгж байгууллагын 136 ширхэг хаяг, хаягийн байгууламжийг буулгаж стандартыг мөрдүүлж ажилласан. Хөдөө аж ахуйн их сургуулийн хашаанд олон жил зөвшөөрөлгүй байршуулсан том оврын тулгуурт самбарыг буулгасан.

Самбар авахын өмнө

Ажлын явц

Самбар буулгасны дараа



Тус ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Наадамчдын зам, нисэхийн тойргоос Морингийн даваа, айдсын даваа хүртэлх авто замын 2 талаар зөвшөөрөлгүй байршуулсан өнгө үзэмж муутай, ногоон байгууламж халхалж байршуулсан 21 төмөр самбарыг буулгасан.



Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хайс, хашлага, гэрэлтүүлгийн шон дээр зөвшөөрөлгүй байршуулсан 1085 массаж зар, хаяг рекламьг хуулсан.



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн шуурхай зөвлөгөөнөөр өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу давс бодис цацах төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж, туршилт тохируулгыг хийж баталгаажуулж ажилласан.

Хан-Уул Агро ОНӨААТҮГ давс, бодис цацах тусгай зориулалтын 2 тоннын багтаамжтай төхөөрөмжийг шинээр худалдан авч, туршилт тохируулгыг хийж ажилласан. Тус төхөөрөмж нь давс болон бодисыг тусгаарлах тусгаарлагчтай, тус бүр нь 1тн-ийн багтаамжтай, бензин хөдөлгүүртэй бөгөөд хэмжээг гараар тохируулдаг онцлогтой.

Аюулгүй ажиллагааг хангах үүднээс 15м зай барьж явах анхааруулга бичиж, цацруулагч наасан.



"Хог хаягдлын тухай хууль" болон "Хот тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний талаар байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс дагаж мөрдөх журам"-д тусгасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хүлээх үүрэг, хориглох зүйл заалтуудыг оруулсан 36 танилцуулга, постерыг бэлтгэж Хан-Уул дүүргийн иргэд бүлгэмд байршуулж сурталчлах ажлыг зохион байгуулсан.



ГУРАВДУГААР БҮЛЭГ: "БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН"

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 10 удаа зохион байгуулагдан нийт 116 үүрэг даалгавар өгөгдөн, 110 үүрэг даалгавар нь 80.6%-тай хэрэгжиж, 6 үүрэг даалгавар нь хэрэгжих шатандаа байна. Биелэлтийг 14 хоног тутам пүрэв гаригт хугацаанд нь <https://backend.ulaanbaatar.mn/> програмд болон erp.ulaanbaatar.mn-д мэдээлж байна.



Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг журмын дагуу 5 удаа зохион байгуулсан. Шуурхай зөвлөгөөнөөс Засаг даргын өгсөн нийт 50 үүрэг даалгавар 83%-тай биелэгдсэн. Үүрэг даалгавар болон биелэлтийг <http://www.khanuul.mn/> сайтад тухай бүр байршуулж байна.




Засаг даргын зөвлөлийн хурал: Дүүргийн Засаг даргын Зөвлөл 2020 оны жилийн эцсийн байдлаар 10 удаа хуралдаж, "Ахмадаа дээдлэе", "Зөв хүүхэд-зөв ирээдүй", "Хорооны хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ зохион байгуулах, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэрлэх асуудал, цаг үеийн тулгамдсан ажилууд зэрэг 54 асуудлыг хэлэлцэн шийдвэр гарган, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн: Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2020 онд хугацаанд 12 удаа зохион байгуулж, 89 үүрэг даалгавар өгөгдөн 85.3 %-ийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Засаг даргын Тамгын газрын тайлан, төлөвлөгөөний хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89, 2019 оны 37, 38 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын даргын 2019 оны 47 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 2017

оны А/335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан, сар, хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг тус тус нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтад танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тус тус тайлант хугацаанд нь <https://erp.ulaanbaatar.mn/> цахим сайт болон бичгээр албажуулан хүргүүлсэн.



Гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт

Засаг даргын Тамгын газрын "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн батлуулсан. Тус төлөвлөгөө нь нийт 3 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд **нэгдүгээр хэсэг** "Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээнд 77 зорилт, 81 арга хэмжээ, **хоёрдугаар хэсэг** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээнд 16 зорилт, 17 арга хэмжээ, **гуравдугаар хэсэг** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд / хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг / 7 зорилт, 14 арга хэмжээ, **гуравдугаар хэсэг** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд / хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг/ 31 арга хэмжээ, нийт 100 зорилтын хүрээнд 143 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

2020 оны жилийн эцсийн байдлаар **Нэгдүгээр хэсэг** Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлт 93.2%, **Хоёрдугаар хэсэг** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний биелэлт 89%, **Гуравдугаар хэсэг** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт 82.9% / хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг/, **Гуравдугаар хэсэг** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт 90% /хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг/ тус тус хэрэгжсэн. /Гүйцэтгэлийн тайлангийн жилийн эцсийн дундаж биелэлт 88.7 хувь/

Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дэд салбар	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ		Дундаж хувь
				Эхний хагас жил	Жилийн эцэс	
1.	Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл	11	11	57.7%	90.9%	74.3%

	ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд					
2.	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	8	8	62.5%	99%	80.7%
3.	Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд	35	37	57.2%	90%	73.6%
4.	Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд	23	25	52.5%	92.9	72.7
	Нийт	77	81	57.4%	93.2	75.3

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Үйлчилгээний төрөл	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Биелэлт /жилийн эцэс/
1.	Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ	4	4	85%
2.	Мэргэжилтэй ажилтанд зориулсан үйлчилгээ	9	10	85.5%
3.	Иргэнд чиглэсэн үйлчилгээ	3	3	96.6%
4.	Нийт	16	17	89%

**ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

/ ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ /

№	Эрх зүйн акт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Биелэлт
1	Хөдөлмөрийн тухай хууль	1	1	100%
2	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	1	5	98.6%
3	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	1	1	100%
4	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль	1	1	90%
5	Тамхины хяналтын тухай хууль	1	1	100%
6	Засгийн газрын 37, 38 дугаар тогтоол	1	3	90%
7	Засгийн газрын 258 дугаар тогтоол	1	1	92%
	Нийт	7	14	82.9

**ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

/ ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ /

№	Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтууд	Арга хэмжээний тоо	Биелэлт /жилийн эцэс/
1.	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага	12	94.4%
2.	Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх	5	60%
3.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах	1	100%
4.	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	4	100%
5.	Төсөв, санхүүгийн хэрэгжилтийг зохион байгуулах	5	86%
6.	Хяналт, шинжилгээ, үнэлгээ	4	80%
Нийт		31	86.7

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЕРӨНХИЙ БҮТЭЦ**

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ		
№	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ		
1	77	81
Хоёр. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ		
2	16	17
Гурав. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ / хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг /		
2	7	14
Гурав.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ / хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг /		
4	-	31
Нийт	100	143

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Япон улсын Хоккайдо мужийн Саппоро хотод “тогтвортой хөгжил” сургалтад хамрагдсан тухай:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/09 дүгээр тушаалаар Япон улсын Хоккайдо мужийн Саппоро хотын 2020 оны 02 дугаар сарын 06-12-ны өдрүүдэд хүний нөөцийг чадавхжуулах гадны улс орнуудын туршлага судлах зорилгоор “Тогтвортой хөгжил” сэдэвт сургалтад ЗДТГ-ын 11 албан хаагч хамрагдсан. Сургалтын хугацаанд төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа болон Япон улсын Саппоро хотын хөгжилтэй танилцсан.

Энэхүү сургалт нь ЗДТГ болон анхан шатны нэгж болох хороодын ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг авч буй иргэдэд таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Сургалтын зорилго нь:

- Төрийн албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх,

- Судалсан арга, туршлагын дагуу дүүргийн иргэдэд чанар, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх
- Япон Улсын Саппоро хотын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай танилцах, тэргүүн туршлагыг судалж, нэвтрүүлэх

Сургалтад хамрагдсан албан хаагчид

№	Нэр	Албан тушаал
1.	Б.Янжинлхам	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
2.	Б.Нарантуяа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч
3.	Б.Тулга	Санхүү төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлагын мэргэжилтэн
4.	О.Мөнгөншагай	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтцийн хөгжил, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
5.	Б.Янжмаа	Аж ахуйн тасгийн Нягтлан бодогч
6.	О.Ганхуяг	4 дүгээр хорооны Засаг дарга
7.	П.Наран	15 дугаар хорооны Засаг дарга
8.	А.Отгон-Эрдэнэ	20 дугаар хорооны Засаг дарга
9.	М.Эрдэнэбат	12 дугаар хорооны зохион байгуулагч
10.	Т.Энхцацрал	12 дугаар хорооны хөгжлийн нийгмийн ажилтан
11.	Д.Дагинацоо	17 дугаар хорооны зохион байгуулагч



Үр

дүн, дүгнэлт: Сургалтад

хамрагдсанаар дүүргийн иргэд, оршин суугчдад чанартай, хүртээмжтэй сургалт, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

Цаашид "Эко дүүрэг" болох зорилтыг хүрээнд байгальд ээлтэй эко технологийг хороодод нэвтрүүлэх, иргэдэд үйлчлэх үйлчилгээний орчны тав тух, ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулах, оршин суугчдын амьдрах орчны ая тух, тохижилтыг дээшлүүлэх нь чухал гэж үзэж байна.

Швед улсад туршлага судалсан тухай:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс хэрэгжүүлж буй "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төсвийн менежментийг сайжруулах, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, төлөвлөлтийг нэвтрүүлэх, эрчим хүчийг хэмнэх замаар үр ашгийг нь нэмэгдүүлэх чиглэлээр Швед Улсад туршлага судлах сургалтад 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаагаар ахлуулан, дүүргүүдийн Засаг даргын орлогч, НЗДТГ, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон Сангийн яамны төлөөлөл бүхий нийт 13 хүний бүрэлдэхүүн хамрагдсан.

Албан томилолтын зорилго:

Швед улсын Стокгольм, Хабо, Тиресо, Сандибург хотуудын нутгийн удирдлага болон, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, тухайн орон нутгийн цэцэрлэг, сургуулийн барилгын эрчим хүчний хэмнэлт бүхий шийдэл, төсвийн хөрөнгө оруулалтын менежмент, жөндөрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалыг судалж, нийслэл Улаанбаатар хотын төр, захиргааны байгууллагуудад нэвтрүүлэхэд оршино.



Бүгд найрамдах турк улсад сургалтад хамрагдсан тухай:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн захиалгаар Бүгд найрамдах Турк улсын Анталья хотын Акдениз Их сургуульд 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдах олон улсын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай танилцах, Анталья хотын төсөв, санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн сургалтад хамрагдах Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Цогзолмаа хамрагдсан.

Сургалтын зорилго:

НББОУС-ын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн онцлог, бодлого, Турк Улсын санхүү эдийн засгийн өнөөгийн чиг хандлагатай танилцах

Сургалтын сэдэв:

- **НББОУ-ын** стандартын хэрэгжилт
- **БНТУ-ын** НББ-ийн бодлого, онцлог
- Эдийн засгийн хөгжил, дэвшил
- Хувьцааны зах зээл, түүний ач холбогдол, өгөөж ба эрсдэл
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын тогтолцоо
- Хувь хүний хөгжил
- Дотоод хяналт шалгалт, үүрэг, түүний ач холбогдол

Шагнал урамшууллын талаар: 2020 онд дүүргийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар Засаг даргын шагнал "Хүндэт тэмдэг"-ээр 150 иргэнийг "Жуух бичиг"-ээр 50, "Өргөмжлөл"-өөр 55, Нийслэлийн 380 жилийн ойн медалиар 150, "Хан-Уулын авьяастан" медалиар 50 нийт 455 иргэн тус тус шагнагдсан.

Засаг даргын албан бичгээр Засгийн газар болон яамны шагналаар шагнуулахаар Зам, тээвэр хөгжлийн яаманд 25, Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 70, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд 6, иргэний материалыг дэмжин уламжилж хүргүүлсэн.

Мэдээлэл технологийн чиглэлээр:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон 21 хороодод Нийслэлийн Архивын газрын Албан хэрэг хөтлөлтийн EDOC.UB.GOV.MN болон ERP.ULAANBAATAR.MN нэгдсэн систем, Khanuul.mn, Eoffice.khanuul.mn болон 21 хороодын цахим хуудаснуудын мэдээллийн баяжилт болон веб серверүүдийн өдөр тутмын тасралтгүй хэвийн ажиллагаанд хяналт тавин ажилласан.



Хан-Уул Дүүргийн Засаг Даргын Тамгын газар болон хороодод цаг бүртгэлийн нэгдсэн системийг бүрэн хянаж, ажлаас чөлөөлөгдсөн болон шинээр ажилд томилогдсон албан хаагчдын бүртгэлийг цаг тухай бүрд нэмж, 300 орчим албан хаагчдын нэгдсэн болон дэлгэрэнгүй тайланг шуурхай гарган ажилласан. Нийслэлийн дотоод удирдлага хяналтын цогц систем ERP.ULAANBAATAR.MN-д ажлын цаг ашиглалт, хурууны хээний бүртгэлийн програм хангамжийг холбосон.

Засаг даргын Тамгын газарт мэдээллийн аюулгүй байдал болон дотоод сүлжээний эрсдэлийн үнэлгээ IT INSITE XXX-тай хамтран хийгдлээ.

Засаг даргын Тамгын газар болон хороодын сүлжээний тоног төхөөрөмжийг өргөтгөл, шинэчлэлт хийх ажлыг "Оюу-Бичиг" ХХК-тай 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/06 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулан тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэлтийг хийж, гүйцэтгэн цахим мэдээллийн аюулгүй байдал, нууцлал хамгаалалтыг зохих түвшинд ханган, хяналт тавьж ажилласан. Мөн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Цонж Алтай ХХК-тай 1/22 дугаартай гэрээг байгуулан, Засаг даргын Тамгын газрын 7 давхрын хурлын өрөөний аудио системийг бүрэн шинэчилсэн.

Ашиглалт хэвийн, хяналт тавин ажиллаж байна.

Засаг даргын Тамгын газрын вэб сервер, санхүүгийн сервер, цаг бүртгэлийн сервер, СМС илгээх програм хангамжийн сервер, Kaspersky серверүүдийн байнгын найдвартай хэвийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавьж байна.



Засаг даргын Тамгын газар болон хороодын дотоод сүлжээ, интернетийн сүлжээний байнгын хэвийн ажиллагааг хангаж, дуудлагаар сүлжээний эвдрэл гэмтлийг цаг алдалгүй хурдан шуурхай засвар хийж ажилласан.

Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, захын болон алслагдсан гэр хороолол, амралт зугаалгын бүсэд ашиглах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд тус дүүргийн иргэд олноор цуглардаг 3 байршилд утасгүй интернетийг суурилуулж ашиглалтад бүрэн оруулсан.

Иргэдэд үйлчлэх төв байр болон 21 хорооны байрны аюулгүй байдлыг хамгаалах, нэгдсэн системийн нийт 43 ширхэг хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг ханган, засвар үйлчилгээг хариуцан ажилласан.

ХОРООДТОЙ ХОЛБООТОЙ ХИЙСЭН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хорооны Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн: Хорооны Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 2020 онд 4 удаа зохион байгуулж, 20 үүрэг даалгавар өгөгдөн 90 хувьтай хэрэгжсэн.

Дүүргийн Засаг даргын хороодод ажилласан талаар:

Хан-Уул дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга Ж.Алдаржавхлан, дүүргийн ИТХ-ын дарга Б.Цэрэн, Засаг даргын нэгдүгээр орлогч Г.Батсайхан, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга В.Батсайхан нар 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр 1,2, 11,15,17,18,19,20 дугаар хороодод, 03 дугаар сарын 21-ний өдөр 9,10,16,21 дүгээр хороод, 03 дугаар сарын 25-ны өдөр дүүргийн 12,13,14 буюу алслагдсан хороодод ажиллаж, "Өндөржүүлсэн бэлэн байдлын үе"-ийн үйл ажиллагаа, хорио цээрийн дэглэмийн дэг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа



Мөн дүүргийн Засаг даргын удирдамжаар батлагдсан 1 дүгээр ажлын хэсэг 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 1, 2,3,11,14,15,17, 18, 19, 20 дугаар хороодын хэсгийн ахлагчдын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ өгч ажилласан.

Дүүргийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тээвэрлэлтийг хориглох тухай” А/120 дугаар захирамжаар Төв аймгийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудын хайрга, дайрганы тээвэрлэлтийг хийж байгаа хүнд даацын автомашинуудыг дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхийг хориглож, карьерын үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд явуулахыг хязгаарласантай холбогдуулан дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж ажиллав.



Дүүргийн Цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг мэргэжлийн байгууллагуудын албан хаагчид байнгын хяналт тавин ажиллаж байгаа ч хайрга, дайрга тээвэрлэсэн автомашинууд шөнийн цагаар зөрчил гаргасаар байгаа тул захирамжийн дагуу тухайн зөрчил гаргасан автомашинуудад байнгын хяналт тавьж, журамлан саатуулах хашаатай болох, мөн нэмж 2 хяналтын пост байрлуулах зэрэг үүрэг чиглэлийг дүүргийн Засаг дарга холбогдох албаныханд өгсөн.

Үргэлжлүүлэн 13 дугаар хороонд шинээр баригдсан 26 дугаар сургуулийн спорт заал, хөл бөмбөгийн талбай, 3,4 дүгээр байрны засвар шинэчлэлийн ажлын явцтай танилцсан. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1800 кв талбайд орчин үеийн стандартад нийцсэн хөлбөмбөгийн талбайн ажлын явц 80 хувьтай үргэлжилж байна.



Дүүргийн Засаг даргын Тамгын газар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Туул голын сав газрын захиргаатай хамтран хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын төлөөлөл нийт 63 албан хаагчдад “Хөрсний бохирдлоор дамжин газрын доорх усны чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах нь” сэдэвт сургалтыг 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Сургалтын үеэр Усны тухай хуулиар Засаг дарга нарын хүлээсэн эрх, үүрэг, COVID-19 халдвар, Ус ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж, урьдчилан сэргийлэх, Улаанбаатар хотын хөрсний бохирдол, Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн шийдэл, түршлага, ололт, сургамж сэдвээр Туул голын Сав газрын захиргаа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв байгууллагуудаас илтгэл танилцуулсан.



Хороодын дунд ур чадварын тэмцээн байгуулсан тухай:

ЗОХИОН

Дүүргийн 21 хорооны албан хаагчдын дунд “Ажил мэргэжлийн ур чадварын тэмцээн”-ийг 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан.

Ажил мэргэжлийн ур чадвар шалгах энэхүү тэмцээн дөрвөн төрлөөр явагдсан бөгөөд албан хаагчдын хуулийн мэдлэгийг шалгах, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой кейс, хороодын мэндчилгээ, спортын буухиа зэрэг багтсан.

Тэмцээний "Шилдэг Засаг дарга"-ын Тэргүүн байранд 17 дугаар хорооны Засаг дарга Д.Энхжаргал, Дэд байранд 9 дүгээр хорооны Засаг дарга Н.Насанжаргал, Гутгаар байранд 2 дугаар хорооны Засаг дарга Э.Батмөнх нар шалгарсан бол "Шилдэг зохион байгуулагч"-аар Нэгдүгээр байранд 1 дүгээр хорооны Зохион байгуулагч Д.Алтансүвд, Хоёрдугаар байранд 1 дүгээр хорооны Зохион байгуулагч Р.Солонго, Гуравдугаар байранд 18 дугаар хорооны Зохион байгуулагч Э.Энхханд нар тус тус шалгарлаа.



Мөн "Шилдэг Хөгжлийн нийгмийн ажилтан"-аар Нэгдүгээр байранд 1 дүгээр хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан Э.Сарангэрэл, Хоёрдугаар байранд 9 дүгээр хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан Л.Дэлгэрмаа, Гуравдугаар байранд 6 дугаар хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан Ц.Энхсаруул нар тус тус шалгарч мөнгөн шагналаар шагнагдсан.

Дөрвөн төрлөөр зохион байгуулагдсан тус тэмцээний нийлбэр дүнгээр "Шилдэг хороо"-оор нэгдүгээр байранд 13 дугаар хороо, хоёрдугаар байранд 1 дүгээр хороо, гутгаар байранд 2 дугаар хороо тус тус шалгарлаа.



Хэсгийн ахлагчдын зөвлөлдөх уулзалт:

Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлангийн санаачилгаар жил бүр зохион байгуулагддаг "Хороодын хэсгийн ахлагчдын зөвлөлдөх уулзалт"-ыг "Гурван ухааны эрин" ТББ-тай хамтран 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалт

уулзалтад 21 хорооны 187 хэсгийн ахлагчид хамрагдан "Ажлын байран дахь сэтгэлийн тав тух" сэдвээр лекц сонслоо.



Уулзалтад Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга Б.Цэрэн, Засаг дарга Ж.Алдаржавхлан, Засаг даргын зөвлөх Ч.Бат-Оргил, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Н.Буянхишиг, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн албан хаагч нар оролцон хэсгийн ахлагчдын санал, хүсэлтийг сонсон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар ярилцсан.

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙГ ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар нь 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 4927 албан бичгийг цахим болон цаасан хэлбэрээр хүлээж авсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 4821 бичиг хүлээн авч энэ хугацаанд ирсэн бичгийн тоо 106-аар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 2019 оны жилийн эцсийн байдлаар 93.53% байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 95.50% байна.



Хариутай бичгийн тоо 2020 оны жилийн эцсийн байдлаар 373 буюу 94% байна.

Зөрчлийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 720 байсан бол 2020 оны жилийн эцэст 303 буюу 41%-оор буурсан үзүүлэлт гарсан байна.

Хан-Уул дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн мэдээ: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем ашиглагч нийт 92 байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 7, 14 хоног тутамд гаргаж Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн, Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн, Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нийт 26 мэдээг бэлтгэн танилцуулсан байна.

Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж дээд шатны байгууллагад танилцуулан ажилладаг. Энэ ажлын хүрээнд сар тутмын 12, улирал тутмын 4 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Архивын газарт хүргүүлээд байна.



Хүснэгтээс харахад тус дүүргийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар 33840 албан бичгийг хүлээн авч шийдвэрлэсэн бол 2020 оны жилийн эцэст 36354 буюу 2514-өөр өссөн байна.


Дүүргийн хэмжээнд нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 93,79% байсан бол 2020 оны жилийн эцэст 96,02% байна.

Хариутай бичгийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 10327 байсан бол 2020 оны жилийн эцэст 8033 буюу 2294-өөр буурсан бөгөөд хаалтын хувь нь 2019 жилийн эцэст байдлаар 92,69%, харин 2020 оны жилийн эцэст 95,31% байна.

Зөрчлийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 2456 байсан бол 2020 оны жилийн эцэст 1172 буюу 1284-өөр буурсан үзүүлэлттэй байна.

Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд явуулсан бичгийн мэдээ:

Засаг даргын Тамгын газраас төлөвлөн явуулсан албан бичгийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 2888 байсан бол 2020 оны жилийн эцэст 2260 буюу явуулсан албан бичгийн тоо 628-аар буурсан байна.




Дүүргийн хэмжээнд явуулсан албан бичгийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 19784 байсан бол 2020 оны жилийн эцэст 17536 буюу явуулсан албан бичгийн тоо 2248-аар буурсан үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт хийсэн мэдээ:

Нийслэлийн Архивын Газрын даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар дүүргийн төр, захиргааны байгууллагуудын баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих эрхийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор шилжүүлсэнтэй холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан.

Тус ажлын хүрээнд тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт өссөн дүнгээр **34072** албан албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж үүнээс 33547 албан бичгийн шийдвэрлэлтийг **хангалттай** гэж үзэн баталгаажуулж, 493 албан бичгийн шийдвэрлэлтийг **хангалтгүй** гэж үзэн цуцалсан байна.



Захирамж, тушаалын мэдээ:

Д/д	Төрөл	2019 оны 12 сар	2020 оны 12 сар
1	Засаг даргын А захирамж	472	523
2	ЗДТГ-ын даргын А тушаал	237	113
3	Нийт	709	636

Дүүргийн Засаг даргын А захирамжийн тоо 51-ээр өссөн бол Засаг даргын Тамгын газрын даргын А тушаалын тоо 124-өөр буурсан байна.

Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан MNS 5140-2011 стандартыг мөрдлөг болгон ажилласан.

Архивын чиглэлээр:

Архивын Ерөнхий газрын даргын 2018 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан "Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам"-ын дагуу дүүргийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх эх үүсвэрийн жагсаалтад орсон дүүргийн харьяа 102 байгууллагын архивын тоон тайланг <http://burtgel.archives.gov.mn/> системд цахим хэлбэрээр шивэх ажлыг хугацаанд нь хийж дүн мэдээг Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн.

Хувийн хэргийн бүрдүүлэлт хийгдээгүй 18 байгууллагын хувийн хэргийн бүрдлийг ТААҮЗ-ын дагуу гүйцээж хийсэн.

Дүүргийн архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн 72 байгууллагын 42671 хадгаламжийн нэгжийн бүртгэлийг нягтлан шалгаж, дүүргийн архивын хөмрөгийн нэгдсэн жагсаалтыг шинэчилсэн.

Нөхөн бүрдүүлэлтээр дүүргийн дэргэдэх 6 байгууллагын байнга хадгалах 644 хадгаламжийн нэгжээр төрийн архивт баяжилт хийгдсэн.

Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудад 2019 онд үүссэн цаасан суурьт 573 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч эмхлэн цэгцэлж, дугаарлан лавлагаа хуулбар өгөхөд бэлэн болоод байна.

"Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх" ажлын хүрээнд үйл ажиллагааны явцад үүссэн 1033 захирамжлалын баримтад цахим хувь үйлдэн онлайн хэлбэрээр мэдээлэл, лавлагаанд ашиглуулах нөхцөлийг ханган ажиллаж байна.

Дүүргийн харьяа 27 байгууллага Archive edoc системд Захирамжлалын баримтаа шивснийг батлан шалгаж дуусгасан.

Монгол улсын Архивын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу 1042 лавлагаа хуулбар, дотооддоо 125 баримтыг түр ашиглуулсан.

2020 онд Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийгдэх Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Биеийн тамир спорт хороо, Эрүүл мэндийн төв, Соёлын ордон зэрэг төлөвлөгөөт 5 байгууллагын данс бүртгэлд арга зүйн заавар зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.

Хяналт шалгалт: Хан-Уул дүүргийн Засаг даргын А/213 дугаар захирамжаар батлагдсан "Хан-Уул дүүргийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны явц, үр дүнд Хяналт, шинжилгээ үнэлгээ хийх удирдамж"-ын дагуу Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажил хуваарийн дагуу явагдсан.

Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай: Дүүргийн архивт хөмрөг үүсгэсэн 6 хөмрөгийн 957 хадгаламжийн нэгжийн бүртгэлийн мэдээллийг Төрийн архивын нэгдсэн системд баталгаажуулж, нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Засаг даргын Тамгын газарт 2019 онд үүссэн

- Засаг даргын захирамж "Б"-20
- Засаг даргын захирамж "А"-472
- Тамгын газрын даргын тушаал "Б"-304
- Тамгын газрын даргын тушаал "А"-240 нийт 1036 захирамжлалын баримтыг скайнердаж /[Archive Edoc](#)/ системд агуулга шивж нягтлан шалгалтыг хийж дуусгасан.

Дүүргийн харьяа 107 байгууллага 2019 оны захирамжлалын баримтыг /[Archive Edoc](#)/ системд шивэх үүрэгтэй бөгөөд үүнээс шивсэн 81 байгууллагын 154 хадгаламжийн нэгжийн

- Дэргэдэх хэлтэс албад /20 байгууллагын/
А-Тушаал-1311
Б-Тушаал-1338
Тогтоол-70

- Хороод / 15 хорооны/
Захирамж-274

- Сургууль, цэцэрлэг /46 сургууль/
А-Тушаал-3001
Б-Тушаал-2900

нийт 8904 баримтад батлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагааны явцад үүссэн

- Байнга хадгалах 402 хн
- Түр хадгалах -756
- Сонгогчдын нэрсийн жагсаалт-60 хн
- Тусгай төрлийн 117 хн нийт

Орон нутгийн Хурлын сонгуулийн үйл явцад үүсч хөтлөгдсөн

- Байнга хадгалах 445 хн
- Түр хадгалах -530 хн
- Тусгай төрлийн -58хн
- Сонгогчдын нэрсийн жагсаалт-60 хн нийт 2428 баримтаар хэрэг бүрдүүлэн бүртгэл

үйлдэн Нийслэлийн Архивын газарт холбогдох акт, бүртгэлийн дагуу шилжүүлэн өгсөн.



Дүүргийн архивын баримтаас лавлагаа, хуулбар үнэн олгосон байдал: Дүүргийн архивын сан хөмрөгийн баримтыг судлах, сурталчлах болон мэдээлэл лавлагаа, танин мэдэхүйн зорилгоор байгууллага, иргэдэд ашиглуулахтай холбогдсон үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Төрийн архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар, Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам, эрх зүйн бусад холбогдох актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Монгол улсын Архивын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу лавлагаа хуулбар болон дотооддоо баримтыг түр ашиглуулсан.

Д/д	Хуулбар олгосон баримтын төрөл	Хуулбар олгосон баримтын огноо	Хуулбар олгосон баримтын тоо	Хуудасны тоо
1	Газрын холбогдолтой захирамж	2007-2020	25	251
2	Захирамж /А/	2006-2020	24	150
3	Захирамж /Б/	2016-2020	21	22
4	Тушаал /Б/	1981-2020	84	125
5	Тушаал /А/	-	-	
6	Санхүүгийн холбогдолтой баримт бичгүүд	1989-2019	14	350
7	СӨХ-ын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг	2006-2019	13	227
8	Малын А данс	1998-2018	293	610
9	Б маягт	1999-2014	12	12
10	Албан бичиг	2002-2020	24	65

Архиваас дотооддоо түр олгосон баримт:

Д/д	Хэлтэс, тасгийн нэр	Баримтын оны хязгаар	Баримтын тоо
1	Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс	2009-2019	72
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2012-2019	88
3	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс	2013-2019	21
4	Нийгмийн бодлогын хэлтэс	2017-2019	11
5	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	2016	3
6	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	2019	2
7	Хууль зүй, архивын тасаг	2012-2016	16

8	Аж, ахуйн тасаг	2012-2019	510
---	-----------------	-----------	-----

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Шүүхэд төлөөлөх, хууль хяналтын байгууллагатай харилцах

Нийслэл дэх Захиргааны болон Иргэний хэргийн шүүхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын нэхэмжлэлээр Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргад холбогдуулан үүсгэсэн 26 хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон холбогдох материалуудыг судалж тайлбар, нотлох баримт гаргаж, газрын үзлэг 35, бичиг баримтын 18 үзлэг хийхэд байлцан, бүх шатны 48 шүүх хуралдаанд оролцсон.

Дээрх хэрэг маргаанаас иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны актын холбогдох хэсгийг хүчингүй болгосон 3, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн 4, актын биелэлтийг түдгэлзүүлсэн 2 хэрэг байна.

Нийт хэрэг, маргааны тоо	26
Он дамжсан	12
Тайлант хугацаанд гардсан нэхэмжлэл	14
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон тоо	4
Нийт оролцсон шүүх хуралдаан	48
Анхан шатны	32
Давж заалдах шатны	10
Хяналтын шат	6
Шүүхийн үзлэг/ Газар, баримт/	53

Захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр: Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гаргасан Засаг даргын 262 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 248 тушаалын төслийг хянаж бүртгэлжүүлсэн, 2020 оны эхний хагас жилийн Засаг даргын 113 захирамжийн үүрэг болгосон 169 заалтын хэрэгжилт 93.35% буюу хангалттай хэрэгжиж байна.

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр: Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 117 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, бүртгэлжүүлсэн байна.

№	Гэрээний индекс	Хэлтэс	Хагас жил
1	1/01	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	18
2	2/01	Санхүү, төрийн сангийн хэлтэс	27
3	3/01	Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс	6
4	4/01	Нийгмийн бодлогын хэлтэс	31
5	5/01	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	14
6	6/01	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	16
7	Ц/01	Цэргийн штаб	12
8	Х/01	Хууль зүй, архивын тасаг	1
9	А/01	Аж ахуйн тасаг	48
		НИЙТ	117

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 20 аж ахуй нэгж, байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээг хянан бүртгэлжүүлсэн.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн төсвийн орлогын талаар:

2020 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 51 тэрбум 474.7 сая төгрөг байхаар батлагдаж, 12 сарын 20-ны байдлаар гүйцэтгэл 52 тэрбум 050.5 сая төгрөг буюу 101.1 хувийн биелэлттэй байна.

Дүүргийн төсвийн орлогыг жигд ханган биелүүлэх, нэмэгдүүлэх, татварын хуулиудын хэрэгжилтийг ханган ажиллахын тулд Засаг даргын "Улс, нийслэл болон орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах зарим арга хэмжээний тухай" 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/27 дугаар захирамжаар томилогдсон хэлтэс, албад хамтран мэдээлэл солилцон ажилласны үр дүнд дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөө биелэгдсэн.

Орон нутгийн төсвийн орлогын мэдээ

/ Өссөн дүнгээр төг /					
	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөн дүнгээр /	Гүйцэтгэл /өссөн дүнгээр /	Давалт /өссөн дүнгээр/	Биелэлт /хувиар/
0	НИЙТ ДҮН	51,474,746,000.00	52,050,452,788.07	575,706,788.07	101.12
1	1. Татварын орлого	48,201,656,000.00	48,940,777,091.42	739,121,091.42	101.53
2	1.1.1 Үйл ажиллагааны орлого	6,700,000,000.00	21,123,535,831.00	14,423,535,831.00	315.28
3	1.1.2 Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого	12,020,000,000.00	10,676,294,306.71	(1,343,705,693.29)	88.82
4	1.1.3 Иргэний ҮХХБорлуулсны ОАТ	2,200,000,000.00	4,105,185,676.94	1,905,185,676.94	186.60
5	1.1.4 Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан ОАТ	9,400,000,000.00	6,447,609,304.28	(2,952,390,695.72)	68.59
6	1.1.5 Газрын төлбөр	9,304,000,000.00	1,672,535,844.10	(7,631,464,155.90)	17.98
7	1.2. Хөрөнгийн албан татвар	99,500,000.00	54,464,000.00	(45,036,000.00)	54.74
8	1.2.1 Бууны албан татвар	99,500,000.00	54,464,000.00	(45,036,000.00)	54.74
9	1.3 Бусад татвар, төлбөр, хураамж	8,478,156,000.00	4,861,152,128.39	(3,617,003,871.61)	57.34
10	1.3.1 Улсын тэмдэгтийн хураамж	6,650,000,000.00	3,382,881,711.73	(3,267,118,288.27)	50.87
11	1.3.2 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	78,156,000.00	34,710,037.41	(43,445,962.59)	44.41
12	1.3.4 Ус, рашаан ашигласны төлбөр	-	17,484,617.80	17,484,617.80	100.00
13	1.3.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,750,000,000.00	1,426,075,761.45	(323,924,238.55)	81.49

14	2. Татварын бус орлого	3,273,090,000.00	3,109,675,696.65	(163,414,303.35)	95.01
15	2.1 Нийтлэг татварын бус орлого	3,273,090,000.00	3,109,675,696.65	(163,414,303.35)	95.01
16	2.1.1 Торгуулийн орлого	3,000,000,000.00	2,862,657,929.12	(137,342,070.88)	95.42
17	2.1.2 Төсөвт байгууллагын өсрийн орлого	253,090,000.00	170,377,703.53	(82,712,296.47)	67.32
18	2.1.3 Бусад орлого	20,000,000.00	76,640,064.00	56,640,064.00	383.20

Төсвийн төлөвлөлтийн талаар :

Орон нутгийн байгууллагуудад олгосон санхүүжилт: 2020 оны 12 дугаар сарын орон нутгийн төсөвт байгууллагуудын **4,510,109.8** мянган төгрөг, өссөн дүнгээр нийт **62,735,783.5** мянган төгрөгийн төсвийн зарлага хариуцан ажилласан.

/мян.төг/

№	Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд	12-р сарын ЗЗБ	2020 оны ЗЗБ /Өссөн дүнгээр/
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	114,466.5	3,929,517.1
2	Засаг даргын Тамгын газар	634,927.3	9,476,533.9
3	Туул тосгоны ажлын алба	62,399.7	493,775.8
4	Худалдан авах ажиллагааны алба	32,121.7	225,233.1
5	Дотоод аудитын алба	27,671.4	212,085.1
6	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	31,256.5	435,495.1
7	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн төв	54,021.0	446,361.8
8	Усан спорт сургалтын төв	86,178.1	548,964.0
9	Биеийн тамир, спортын хороо	35,663.3	481,251.9
10	Соёлын ордон	85,175.2	409,985.0
11	Аж ахуйн тооцоот байгууллагууд	1,136,189.8	10,751,639.3
12	Төсвийн хөрөнгө оруулалт	-30,604.4	14,381,054.1
13	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг	1,289,929.1	15,119,473.0
14	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлууд	910,746.2	5,173,396.2
15	Орон нутгийн хөгжлийн сан	39,968.4	651,018.1
16	Нийт санхүүжилт	4,510,109.8	62,735,783.5



Дүүргийн орон нутгийн байгууллагуудын 2020 оны төсвийн сар, улирлын хуваарийг нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн төсөв хоорондын харилцаатай уялдуулан, боловсруулж Фискал програмд шивж, 12 дугаар сарын ЗЭБ-ийг Сангийн ямаар татуулан санхүүжилтийг хуваарилсан.

Тайлант 12 дугаар сарын байдлаар цаг үеийн байдалтай холбоотойгоор ИТХ, ЗДТГ, ХАААЛба, Орон нутгийн нөөц хөрөнгө, Байгаль хамгаалах, тоосжилтыг бууруулах, Хан-Уул Зам засвар, арчилгаа ОНӨААТҮГ, Орон нутгийн сонгуулийн зардал, Засаг даргын нөөц хөрөнгө, ТЗШ-ийн зарим байгууллагуудын шаардлагатай урсгал засварын зардлуудын 3-12-р саруудын хуваарьт шаардлагатай зохицуулалтуудыг хийсэн. Төсвийн нийт зохицуулалтын дүн 2,934.0 сая төгрөг.

Тайлант хугацаанд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Хилийн 0218-р анги, Эрүүл мэндийн төв, Татварын хэлтэс, Боловсролын хэлтэс, ГБХЗХХ-ийн нийт /өссөн дүнгээр/ 2,867.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг нээж, зардлын дансдуудад хуваарилав.

2019 оны Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг Э-Тайлан цахим програмтай тулган, байгууллага бүрээр тайлбартайгаар хийж Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

Дүүргийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал болон орон нутгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулж Нийслэлийн СТСХ-т хүргүүлж хамгаалсан. Мөн тухайн төсвийн төслийг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн фискаль програмд байгууллага нэг бүрчлэн шивж орууллаа.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудад олгосон санхүүжилт:

Дүүргийн тусгай шилжүүлгийн байгууллагуудын сар бүрийн хуваарийг хийж батлуулан, санхүүжилтийг хугацаанд нь олгуулан ажилласан.Үүнд:

		/мян.төг/
№	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	12 сарын санхүүжилт /өссөн дүнгээр/
1	Ерөнхий боловсролын сургууль	28 826 617.9
2	Сургуулийн өмнөх боловсрол	24 117 094.1
3	Өрхийн эрүүл мэндийн төвүүд	5 189 471.6
	Нийт	58 133 183.6



46 байгууллагад нэмэлт санхүүжилтаар орж ирсэн 1 757 770.9 мянган төгрөгний зарцуулалтын эрхийг тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн холбогдох зардалд нээн өгч ажилласан.

СӨБ, ЕБС-ийн байгууллагын 743,545.6 мянган төгрөгийн зохицуулалтын санал хүлээн авч нэгтгэн төлөвлөлтийн програмд оруулж хуваарьт өөрчлөлт оруулан Нийслэлийн СТСХэлтэст, Сангийн яаманд хүргүүлэн зарцуулалтын эрхийг нээлгэсэн.

Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Боловсролын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу СӨБ, ЕБС-ийн 46 байгууллагын 2,698,260.8 мянган төгрөгийн хүүхдийн хоол болон үдийн цайны зардлын хэмнэлтээс зохицуулалтын санал хүлээн авч нэгтгэн, төлөвлөлтийн програмд оруулж хуваарьт өөрчлөлт оруулан төвлөрүүлсэн.

Мөн Сангийн яамнаас ирүүлсэн зарим зардалд хязгаарлалт хийсэн төсвийн баазыг байгууллага нэг бүрчлэн тулгаж төсөв хоорондын харилцаа зөрсөн өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийн хуваарийг төлөвлөлтийн програмд өөрчлөлт оруулан Сангийн яаманд нэгтгүүлэхээр хүргүүлсэн. Мөн төсөв хоорондын харилцаанд тааруулан төлөвлөлтийн баазад өөрчлөлт орсон тухай бүрд нь өөрчлөлтийг хийж баазаа нэгтгүүлэн татуулсан.

2019 гүйцэтгэл батлахтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2019 оны гүйцэтгэлийг гарган төсвийн зарлагын мэргэжилтэнд нэгтгүүлсэн.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1А/2788, 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 1а/2975 тоот албан бичгүүдийг үндэслэн тусгай шилжүүлгийн байгууллагуудын батлагдсан төсөвт багтаан өр, авлагагүй байхаар ирүүлсэн чиглэлийн дагуу 1,705.0 сая төгрөгийн зохицуулалтын тооцоолол хийн хөтөлбөр хооронд зохицуулалт хийлгэн 2020 оны төсвийн нэмэлт өөрчлөлтөөр батлуулсан.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон урсгал зэсварын зардлын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төлөвлөгөөний төслийг авч нэгтгэн хуулийн хугацаанд нь Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

Төсөвт байгууллагуудын 2020 онд хэрэглэгдэх жижиг мөнгөн сангийн зарцуулалтын хэмжээг хэлтсийн даргаар батлуулан сангийн яаманд хүргүүлж зарцуулалтын эрхийг нээлгэсэн.

2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн 69 төсөвт байгууллага болон сангуудын аудитын асуулгын бүртгэлийг нэгтгэсэн.

58 байгууллагын 2019 оны цалин байгууллагын орон тооны судалгааг Нийслэл дэх төрийн аудитын газарт нэгтгэж өгсөн.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын 2017-2019 оны төсвийн гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийг байгууллага тус бүрээр гарган Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 9 сар хүртэл түр зогсоосонтой холбогдуулан А/196 дугаар захирамжийн ажлын хэсэгт орон 29 цэцэрлэгийн хүнсний үлдэгдэл бүтээгдэхүүний нэгтгэлийг бүтээгдэхүүний нэр төрөл, байгууллага тус бүрээр 5 ангилалаар, хугацаагаар нь ангилж гаргасан.

Нийслэлийн Боловсролын газарт төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн 1-3 сарын хувьсах зардлыг олгосон санхүүжилтийн судалгааг холбогдох маягтын дагуу гаргаж хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн 1-4 сарын хувьсах зардлыг олгосон санхүүжилтийн судалгааг гаргаж хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст 4, 5 дугаар саруудын хүүхдийн хоол, үдийн цайны зардлын хэмнэлтийг төвлөрүүлсэн мэдээг байгууллага тус бүрээр гаргаж хүргүүлсэн.

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар :

Энэ жил "Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем"-ийн сүлжээ буюу "V7" програмын журнал ваучераар орон нутгийн 12 байгууллага, 7 хөтөлбөр, Засаг даргын нөөц, ОНХО, ОНХСн, 9 ОНӨААТҮГ-аар, ТШБ-ын тогтмол зардлын санхүүжилтэнд нийт 32,498,049.9 мянган төгрөг, тусгай шилжүүлгийн 179 байгууллагад 57,504,080.0 мянган төгрөг нийт 90,002,129.9 мянган төгрөгийн зарлага, санхүүжилт олгож 54,692,822.0 мянган төгрөгийн орлогыг ерөнхий орлогын дансанд, нийслэлд 15,119,473.0 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрүүлэв.

Орон нутгийн байгууллагуудад олгосон санхүүжилт

/төгрөг/

№	Төсвийн байгууллагын нэр	Жилийн батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3 578 829 400.00	3,374,679,700.00
2	Засаг даргын Тамгын газар	8 202 675 900.00	6,220,989,100.00
3	ЗД-ын нөөц хөрөнгө	550 000 000.00	550,000,000.00
4	Ахмадын хороо	123 358 000.00	123,358,000.00
5	Татварын хэлтэс	50 500 000.00	50,228,000.00
9	Б/Хам-х, тоосжилт бууруулах	300 000 000.00	236,116,600.00
11	Өвөлжилтийн бэлтгэл хангах	150 000 000.00	74,639,000.00
12	Хорооны хөгжил-Төрийн үйлч	100 000 000.00	80,230,500.00
13	Орон нутгийн ХО	14,381,054,100.00	5,350,000,000.00
14	ТААлба	493 775 800.00	469,081,200.00
16	ХАААлба	218,233,100.00	196,811,400.00
17	ЖДҮДТөв	435 495 100.00	425,023,800.00
18	ГБХЗХХэлтэс	446 361 800.00	430,738,800.00
19	Дотоод аудит	212 085 100.00	182,441,811.00
20	Усан спорт сургалтын төв	478,344,000.00	400,232,235.00
21	НҮАлба /ӨЗМТ тогт/	1,822,478,600.00	1,822,478,600.00
22	НЭЗТ	965,818,500.00	910,818,500.00
23	Цэцэрлэгжүүлэлт, тохижилт	500,000,000.00	-
24	Хог тээвэр	5,638,377,600.00	5,638,377,600.00
25	Нобель	521,712,000.00	521,712,000.00
26	Камер засвар үйлчилгээ-НҮА	345,000,000.00	345,000,000.00
27	Зам засвар, арчилгаа	713,333,400.00	713,333,400.00
28	"ЭКО" ахмадын сувилал	47,449,200.00	47,449,200.00
29	Хан-Уул Яармаг худалдааны төв	85,000,000.00	85,000,000.00
30	БТСХороо	473 251 900.00	442,530,845.00
31	Соёлын ордон	354,985,000.00	303,706,700.00
32	ЕБС-ийн тогтмол зардал	2 994 302 300.00	2,112,385,600.00
33	СӨБ-ийн тогтмол зардал	2 123 485 900.00	1,343,847,800.00
34	ТНЭ тогтмол зардал	55 608 000.00	46,839,500.00
35	Орон нутгийн сонгууль	351,225,700.00	
36	НИЙТ ДҮН	46,712,202,400.00	32,498,049,891.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг	15 119 473 000.00	15,119,473,000.00

Тусгай шилжүүлгийн байгууллагуудад олгосон санхүүжилт

/төгрөг/

№	Төсвийн байгууллагын нэр	Жилийн батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт
1	Ерөнхий боловсролын сургууль	28 238 700 000.00	28 238 700 000.00
2	Сургуулийн өмнөх боловсрол	24 117 094 100.00	24 117 094 100.00
3	Өрхийн эрүүл мэндийн төв	4 749 160 000.00	4 749 160 000.00
4	Туул тосгоны Нэгдсэн эмнэлэг	399 126 400.00	399 126 400.00
	ДҮН	57 504 080 500.00	57 504 080 500.00

2019-2020 онд он дамжин хэрэгжих 3,193.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээнээс хэрэгжсэн 6 төсөл арга хэмжээнд 1,468.3 сая төгрөг, 2020-2020 онд хэрэгжих 15,403.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл арга хэмжээнээс 23 төсөл арга хэмжээнд 3,891.7 сая төгрөг, нийт 5360,0 сая төгрөгийг үндсэн баримтыг үндэслэн хянаж баталгаажуулав.

Дүүргийн төсөвт бүх байгууллагын 3ЗБ№1-ийг /жилийн төлөвлөгөөг сар бүрээр шивж/ тухай бүр хөтөлж хувийн хэвшлийн 20 сургууль, 96 цэцэрлэг, ОНӨААТҮГ-ын санхүүжилтийг нэхэмжлэл, хүүхдийн ирцийн мэдээ, боловсролын хэлтсээс ирүүлсэн тооцооллыг үндэслэн хуулийн хугацаанд олгов.

Дүүргийн төсөвт болон төсвөөс санхүүжилт авдаг хувийн хэвшлийн байгууллагуудын бүртгэл хөтөлөлт, тайлан тэнцэл гаргалтын үйл ажиллагааг зохион байгуулж дүүргийн санхүүгийн ажилнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нийт 208 нэгж байгууллагын 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг өөрийн ажлын байранд ширээний уулзалт хэлбэрээр зохион байгуулан салбар, салбарын баг бүрд мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгийг танилцуулж санхүүгийн тайлангийн агуулга, ач холбогдол, цагалбар, ня-бо нар гаргасан тайлангаа шалгах барианууд, санхүүгийн тайлангийн бүтэц, төрөл, тайлан гаргах маягт, аргачлал, төсвийг хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал тус бүрээр хэрхэн ангилдаг, "Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем"-ийн сүлжээ буюу "V7" програмын кодын блокийн тухай асуулт хариулт хэлбэрээр харилцан ярилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Төсвийн тухай хуулийн 54.2-т "ТЭЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн тайланд хамруулна" гэж заасны дагуу Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 208 нэгж, байгууллагын 2020 оны эхний хагас жил, 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайланд байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авав. Тайлангийн хугацаа хожимдуулсан Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Туулын ажлын алба, 49, 250 дугаар цэцэрлэгийн захиргаанд мэдэгдэх хуудас илгээсэн.

№	Байгууллагын нэр	Тоо
1	Орон нутгийн байгууллага	12
2	БХСан, ОНХСан	2
3	ОНХО, барьцаа	2
4	Хөтөлбөр	7
5	ОНӨААТҮГ	7
6	Ерөнхий боловсролын сургууль	19
7	Хувийн хэвшлийн ЕБС	20
8	Сууц өмчлөгчдийн холбоо	29
9	Хувийн хэвшлийн СӨБ	95
10	Өрхийн эрүүл мэндийн төв	15
	НИЙТ	208

Төрийн сангийн тайланг гаргаж, Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд дээрх байгууллагуудын хоорондын тооцоо, тохируулах болон устгах бичилтүүдийг хийж дүүргийн нэгдсэн тайланг Нийслэлийн төрийн сангийн хэлтэст тойрох хуудасны хамт хянуулж нэгтгүүлээ.

Бүх төсөвт байгууллагын касс харилцахын нэгтгэл, 2020 оны эхний хагас жилийн ОНБ-ын 3,308,900,0, ТШБ-ын 164,191,9, нийт 3,473,091,9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагын тайланг нэгтгэж Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.

2020 оны эхний хагас жилийн нэгтгэсэн тайланд Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартын дагуу нэгтгэл хийх горимыг гүйцэтгэж давхардсан ажил, гүйлгээг устгах бичилтийг хийв. Үүнд: ҮДТ-д 137 буюу 59 589 402,2, МГТ-д 138 буюу 59 730 372,7 Бусад хоорондын тооцоогоор 31 буюу 8 723 550,6, 31 буюу 8 722 148,1 мянган төгрөг нийт 337 бичилтээр 1 367 654 73,6 мянган төгрөгийн хоорондын тооцоо үүсгэж тулган баталгаажуулав.

Төрийн сангийн үйлчилгээний талаар :

Төрийн сан банк нь 2020 оны дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын нийт 25.840 ширхэг 182,066,001,712 төгрөгийн гүйлгээ анхан шатны баримтыг үндэслэн хяналтын хуудастай тулган "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээлэл" системийн

сүлжээ буюу “Фрибланс” програмын зардлын ваучерт шивэгдсэнийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын дансны формат, хүлээн авсан огноо, төлбөрийн хэлбэр, ТЭЗ-ын харилцах дансыг зөв сонгосон эсэх, ерөнхий дэвтрийн дансанд төсвийн ерөнхийлөн захирагчаар өглөг хэрхэн үүсгэсэн эсэх, кодын блокгийг зөв оруулсан эсэхэд хяналт тавьж тулган баталгаажуулж ажилласан.

Бүртгэлийн үйлчилгээний талаар:

Хан-Уул дүүрэгт харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Зөрчил шалган шийдвэрлэх, Зөрчлийн тухай хууль, Сангийн сайдын 46-р тушаалыг баримтлан Тайлан баланс, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг Сангийн яамны шинэчилсэн “E-Balance” нэгтгэлийн програмд бүрэн шивүүлж илгээсэн тайланг заасан хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан, нэгтгэлийг заавар журмын дагуу тайлагнаж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар:

- ✓ Ирсэн бичиг-46, явуулсан бичиг-27, шийдвэрлэсэн бичиг-46
- ✓ Шинээр бүртгүүлсэн- 2850 ААНБ
- ✓ Татан буугдсан – 36 ААНБ
- ✓ Завсрын тайлан баталгаажуулсан-78 ААНБ
- ✓ Залруулгын тайлан- 113 ААНБ
- ✓ Нэр сольсон-11 ААНБ
- ✓ Нууц код сэргээсэн- 221 ААНБ

Санхүүгийн тайлан хоцроосон нийт 53 аж ахуйн нэгж, байгууллага Зөрчлийн тухай хуулийн дагуу нягтлан бодогчын хариуцлагын арга хэмжээ авч торгуулийн мөнгө болох 21,200,000 /Хорин нэгэн сая хоёр зуун мянган/ төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Мөн 8 зөрчлийн хэрэг үүсгэн ажиллаж байна.

Сар бүр Прокурорын газар Шийтгэл оногдуулалтын мэдээг хүргүүлж ажилласан.

Шинээр ААНБ бүртгэхэд шаардлагатай материал,тайлан хүлээн авалттай холбоотой мэдээллийг тогтмол хүргэж байна. Мөн утсаар болон биечлэн арга зүйн зөвлөгөө өгсөн /2850 ААНБ/



Орон нутгийн хөгжлийн сангаар хийсэн ажил үйлчилгээ :

2019-2020 он дамжин хэрэгжиж 3,193.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл хэмжээ батлагдсанаас 2,692.4 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээний гэрээ байгуулж үүнээс 6 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 1,468.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон,

2020 онд хэрэгжих 15,403.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл арга хэмжээ батлагдсанаас 7,805.4 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээ гэрээ байгуулж үүнээс 23 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 3,891.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 651.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ батлагдсанаас төндөр зарлагдаж төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихээр шийдвэрлэсэн.

Бүрэн хэрэгжсэн 29 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгахад хяналт тавин ажиллаж 13 байгууллагад данс бүртгэх тусгах тухай албан бичиг хүргүүлж, хороод болон нийтийн эзэмшлийн зам талбайд хийгдсэн засвар, тохижилтын 16 төсөл арга хэмжээг Тамгын газрын бүртгэлд тусгуулсан.

Зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний 68.8 сая төгрөгийн өртөгтэй 12 төсөл арга хэмжээний гэрээ байгуулж, 62.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 6.0 сая төгрөгийн 1 зураг төсөл он дамжин хэрэгжихээр шийдвэрлэсэн.

Дотоод ажил / олон нийтийн/

Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/55 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын өмч, эд хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын 9 хэлтэс, тасаг алба, дэргэдэх 6 хэлтэс, 21 хороо болон Оригл рашаан сувилалыг тоолж дуусгасан.

Тооллогод орон нутгийн 2 байгууллага, улсын төсвийн 5 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 2 байгууллага, төрийн бус өмчийн 1 байгууллага нийт 10 байгууллагад ашиглагдаж буй 87 нэр төрлийн 1772 тоо ширхэг бүхий нийт 135 сая 999 мянга 161,74 төгрөгийн эд хөрөнгө хамрагдсан бөгөөд тооллогын үр дүн, тооцоо бодсон акт, тооллогоор илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудал, өмнөх тооллогын комиссын өгсөн дүгнэлтийн биелэлтийг нэгтгэн тайлагнав.

Тооллогын дүнгийн хурлыг ЗДТГ-ын Өмч хамгаалах комисст слайдаар тайлагнасан.

Төсвийн "тээг" үлдэгдэлтэй дансдаас татварын орлогын буцаалт болон зарлагын гүйлгэээ олгох талаар;

2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар татварын орлого бууруулах болон нэр төрлийн залруулгын хүсэлтийг хянуулан нийт 1 тэрбум 167 489,1 мянган төгрөгийг 1447 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгон дансны хуульгйг тухай бүр тулган, хянан ажиллалаа.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

Эрүүл мэндийн чиглэлээр: Иргэдэд үйлчлэх төв байранд нэвтэрч буй иргэд, ажилтан, албан хаагчдын биеийн халууныг хэмжиж, гараа ариутгах, амны хаалт зүүж үйлчлүүлэх шаардлагыг тавьж ажиллаж байна. Тус үйл ажиллагаа 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үргэлжилсэн бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх нийт 18 хэлтэс, албадын албан хаагчид хуваарийн дагуу ажилласан.



Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвтэй хамтран 03 дугаар сарын 06-20-ны өдөр хүртэлх хугацаанд хуваарь гарган Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 346 албан хаагчдыг ДОХ, Тэмбүү, Элэгний В, С вирусийн шинжилгээнд хамруулсан.



Дүүргийн Улаан загалмайн хорооноос "Covid-19" цар тахлын үед цусны донорын эгнээг өргөжүүлэх, цусны нөөцийг бүрдүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх зорилгоор цусны донорын өдөрлөгийг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, нийт 42 албан хаагч хамрагдаж 14.7 литр цусны нөөцийг бүрдүүлсэн.



Эрүүл мэндийн сайдын "Коронавируст халдварын талаар" сургалт зохион байгуулах тухай А/259 дугаар тушаалын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан.

Тус сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх 14 хэлтэс, албадын 20 ажилтан, албан хаагчид хамрагдсан.

Соёл урлагийн чиглэлээр:

"Дондогдулам хатны номын өргөө" түүхийн дурсгалт объект-д хууль бусаар амьдарч буй 3 өрхөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 07/178, 07/179, 07/180 дугаар албан мэдэгдлийг хүргүүлсэн.



"Хотын соёл" олон нийтийн аяныг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зарлаж 9 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. "Хот соёлтой болгоё" аяны хүрээнд хотын соёлд уриалсан брошур, тараах материал 3300 ширхэгийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, гудамж, талбай, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад тараан байршуулж сурталчилан ажиллаж байна. Аяны хүрээнд цахим мэдээллийн санд уриалга, фремиг байршуулж дүүргийн нийт 500 гаруй албан хаагч нэгдсэн.



Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн албан мэдэгдлийн дагуу түүх, соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтад хяналт, шалгалт хийх 2020 оны төлөвлөгөөт шалгалтыг 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд хийсэн. Шалгалтын дүнд 7 төрлийн зөрчил илэрсэн бөгөөд тус зөрчлүүдийг арилгахаар дүүргийн Соёлын ордонтой хамтран ажилласан.

13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар болох Тоорил хааны ордны туурь, эртний дөрвөлжин булш зэрэг газруудад нарийвчилсан судалгаа, он цаг, түүх соёлын дурсгалт газрын эрдэм шинжилгээний тайлан дүгнэлтийг гаргуулахаар Монголын үндэсний музейд хандан хамтран ажилласан.

Монголын үндэсний музейн тайлан дүгнэлтийг үндэслэн тус 2 газрыг дүүргийн тусгай хамгаалалтад авах саналыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулахаар Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 07/400 дугаар албан бичгээр уламжилсан.

11 дүгээр хорооны нутаг дэвсгэр Богдхан ууланд байрлах Чингис хааны сэрэг дүр бүхий шохоон чулуун дүрс зургийн өнгийн сэргээж, засварлах ажлыг Дэлхийн Монгол туургатны өв соёлыг хамтран хамгаалах их голомт сантай 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 04/23 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хамтран ажилласан.

Дээрхи нөхөн сэргээлтийн ажилд дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын хамт олон Чингис хааны сэрэг дүр орчмын газрын зэрлэг өвсийг цэвэрлэсэн.

Засвар хийхээс өмнөх зураг:

Засвар хийсний дараах зураг:



Олон
улс
болон

Төрийн бус байгууллагын чиглэлээр:

"Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллагын Хан-Уул орон нутгийн хөтөлбөрийн хөгжлийн чиглүүлэгч Ерэнбаатар "Дундын хадгаламжийн бүлэг" нэртэй сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 19 хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан болон Нийгмийн бодлогын хэлтсийн 4 мэргэжилтэн хамрагдсан.



Засаг даргын Тамгын газрын зүгээс дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Олон улс болон Төрийн бус байгууллага руу тусламж дэмжлэг хүссэн албан бичгийг хүргүүлсэн. Уг бичгийн хүрээнд 4 ОУБ, 2 ТББ нийт 4560 ширхэг амны хаалт, 2020 ширхэг гар ариутгагч, 30 ширхэг хамгаалалтын хувцас, 400 ширхэг зөвлөмж зэргийг Дүүргийн онцгой комисст хүлээлгэн өгсөн байна. Үүнээс:

➤ "Тайванийн хүүхэд, гэр бүлийг дэмжих сан" олон улсын байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Жоу Мэй Миао нь дүүргийн онцгой комисст тусламж дараах дэмжлэгийг үзүүлээ. Үүнд:

- Амны хаалт- 1000 ш
- Гар ариутгагч-520 ш
- Хамгаалалтын хувцас- 30 ш



➤ "Дэлхийн Зөн Монгол" ОУБ-аас дүүргийн онцгой комисст тусламж дэмжлэг үзүүлээ. Үүнд:

- Амны даавуун хаалт- 500 ш
- Гар ариутгагч- 500ш



- “Гүүд Нейборс” ОУБ-аас дүүргийн онцгой комисст тусламж дэмжлэг үзүүллээ. Үүнд:
- Амны хаалт- 1000 ш
 - Гар ариутгагч- 1000ш
 - Зөвлөмж- 400 ш



- “Кристина Ноблийн хүүхдийг ивээх сан” олон улсын байгууллагаас дүүргийн онцгой комисст тусламж дэмжлэг үзүүллээ. Үүнд:
- Амны хаалт- 1000 ш



“Зүүний хүчний холбоо” ТББ-ын Хан-Уул дүүргийн салбарын тэргүүн Л.Отгонжаргал нь дүүргийн онцгой комисст тусламж дэмжлэг үзүүллээ. Үүнд:

- Амны хаалт- 1000 ш
- “Тереза эх” ахмадын асрамжийн төвөөс дүүргийн онцгой комисст тусламж дэмжлэг үзүүллээ. Тусламж дэмжлэгээр:
- Амны хаалт- 60 ш
 - Гарын шингэн саван- 8 ш
 - Ариун цэврийн цаас- 24 ш
 - Эмнэлэгийн спирт- 5 литр
 - Гар ариутгагч- 5 литр
 - Хлорамин- 1 хайрцаг
 - Нэг удаагийн бээлий- 100 ш

Боловсролын чиглэлээр:

"Covid-19" цар тахлын үед зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотойгоор элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн 10-12 дугаар ангийн 4400 сурагчдад хичээл завсардлаас урьдчилан сэргийлэх, шалгалтанд дэмжлэг үзүүлэх шат дараатай арга хэмжээ авч байна. Тус ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Мобиком корпораци" ХХК-аас хүүхэд бүрт 11 сарын хугацаанд ашиглах сар бүр 9 GB-ийн дата эрхтэй дугаарыг нийгмийн хариуцлагын хүрээнд үнэ төлбөргүйгээр нийт 1700 хүүхдэд олгосон.



Улсын онцгой комиссын хурлын 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэл, 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны сайдын А/194 тоот тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/196 дугаар захирамжийн дагуу "Covid-19" цар тахлын улмаас сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийн агуулахад хадгалагдаж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийх ажлыг зохион байгуулсан.



Тус ажлын хүрээнд хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт хамгаалалт, хугацаа, үйлдвэрийн шошгын бүрэн бүтэн байдлыг шалган нийт 60 нэр төрлийн 1799 ширхэг, 6,258,590 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг "Өсвөр- Үе хүнс" ОНӨААТҮГ буцаан татан авсан бөгөөд дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Л.Мөнхсаруул нь төрийн өмчийн 29 цэцэрлэгийн хүнсний агуулахад хадгалагдаж байгаа хугацаа дууссан, стандартын шаардлага хангаагүй 50 нэр төрлийн 1879 ширхэг, 229.5 кг нийт 4 808 369 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг устгуулахаар дүүргийн Засаг даргын дэргэдэх устгалын комиссад шилжүүлэн ажилласан.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх олголт: Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хүгээлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 508 иргэнийг бүртгэн үнэмлэх олгож, 418 иргэний үнэмлэхний хугацааг сунгасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлийн 2020 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг дэргэдэх хэлтэс, албадаас авч нэгтгэн, төлөвлөгөөнд 9 зорилт 37 арга хэмжээг тусган 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 37 арга хэмжээнээс 2020 оны жилийн эцсийн байдлаар 33 арга хэмжээг зохион байгуулж 89 хувийн хэрэгжилттэй биелэгдэж 4 арга хэмжээ "Covid-19" цар тахлын улмаас хойшлогдсон байна.

Дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний салбар зөвлөлийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх үйлчилгээний ээлтэй орчин бүрдүүлэх тухай 07/220 тоот мэдэгдэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 449 аж ахуйн нэгж байгууллага, төрийн 63, нийт 512 байгууллагад хүргүүлсэн.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 25, түүнээс дээш ажилтантай ААНБ 348, хөгжлийн бэрхшээлтэй хүн, одой хүнийг ажиллуулдаг ААНБ 150, ажиллуулаагүй бол сар бүр төлбөр төлдөг 23 ААНБ-ын судалгааг нэгтгэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газарт хүргүүлсэн.

2020 оны 09 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд ЕБС болон СӨБ-ын удирдах ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан суралцуулах сургалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Монголын хараагүйчүүдийн холбоо, Боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулж 130 гаруй ажилтнуудыг хамруулсан.



"Тайваны хүүхэд, гэр бүлийг дэмжих сан" олон улсын байгууллагатай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд дүүргийн зорилтот өрхийн 4 айлд гэр олгох болсны дагуу гэр хүссэн иргэдийн судалгаанаас нэн шаардлагатай байгаа айлуудыг сонгон тус айлуудын гэрт очиж нөхцөл байдалтай нь танилцаж 6, 9, 11, 13 дугаар хорооноос айлууд сонгосон байна. Гэрийг 12 дугаар сарын 04-ний өдөр тухайн иргэдэд хүлээлгэн өгсөн.



Хөгжлийн бэрхшээлтэй асаргаанд байдаг хүүхдийн судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг иргэдийн судалгаа, 2-оос дээш хөгжлийн бэрхшээлтэй өрхийн судалгааг тус тус гаргаж Нийслэлийн онцгой комисст хүргүүлсэн.

Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:

Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны залуу гэр бүл М.Нанзаддорж, О.Сэлэнгэ нар нь 2020 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 3 ихэр охинтой болсныг тохиолдуулан дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан хүүхдүүдэд хүүхдийн бүүвэйлэгч, нярайн живх зэрэг зүйлсийг бэлэглэж дурсгалын зураг татуулсан.



Жендэрийн Үндэсний хорооноос зохион байгуулсан дараах үйл ажиллагаанд төрийн албан хаагчдыг хамруулсан.

- 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

"Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, дундаж наслалтыг нэмэгдүүлэх" стратеги төлөвлөгөө боловсруулах цахим хуралд Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Н.Мэндбаяр;

- 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

дүүргийн ЗДТГ болон дэргэдэх хэлтэс албадын 12 эрэгтэй албан хаагчдад "Жендерийн тухай ойлголт";

- Жендэрийн сургагч багш бэлтгэх

сургалтад 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус хамрагдсан.



"Тэмүүлэл" ТББ-аас хүүхдийн асрамжийн газар байгуулах, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг өгөх үйл ажиллагаанд төрийн болон ТББ-аас нэг хүн 3000 төгрөг аяныг дүүргийн ЗДТГ-т 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн хагас болон бүтэн өнчин хүүхэд, зорилтот өрхийн 2100 хүүхдэд дүүргийн Засаг даргын гарын бэлгийг гардуулсан.



Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй хүүхдийг хөдөлгөөний дутагдалаас урьдчилан сэргийлэх, тоглоомын талбайг байгуулах ажлын хүрээнд НЦҮТ-ийн гадна талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүүхэд гэр бүлийг хүчирхийллээс хамгаалах зорилгоор "Дэлхийн зөн Монгол" ОУБ-тай хамтран 08 дугаар сарын 21-ний өдөр 7, 8, 9, 10, 12, 13, 16 дугаар хорооны 48 гэрээр айлчлагч, 7 хорооны хөгжлийн нийгмийн ажилтнуудад "Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг" сургалтыг урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлыг хэрхэн хийх ойлголт, тэр дундаа хүүхдийг гэр бүлд нь хамгаалах хамгийн энгийн аргууд сэдвүүдийн хүрээнд явуулж чадавхжуулсан.

Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан "Асуудал ба шийдэл" ур чадварын тэмцээнд 9 дүгээр хорооны Хамтарсан баг оролцож нийслэлийн 173 хорооноос 3 дугаар байрт шалгарсан.



Боловсролын чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2019 оны А/07 тоот захирамжаар байгуулсан "Хяналт, шалгалтын ажлын хэсэг" дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад дотоод орчны аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийж, эрсдлийг үнэлэн хүүхдийн аюулгүй орчинд суралцуулах арга хэмжээ авсан.



Сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн өмчийн 28, төрийн бус өмчийн 98 цэцэрлэг, төрийн өмчийн 18, төрийн бус өмчийн 21 сургуулиудад:

- "Коронавирусээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалын дэглэмийг сахих"
- "Ариутгал халдваргүйтлийг хэрхэн зохион байгуулах"
- "Сургуулийн Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд" сэдэвт сургалтыг 08 дугаар сард зохион байгуулсан.



Дүүргийн 28 цэцэрлэгийн элсэлтийг "Коронавирусээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалын дэглэмийг сахих" түр журмын хүрээнд 1 ангид хамрагдах хүүхдийн тоо 25-аас дээшгүй байхаар тооцоолж 21 хороодоос "Нийгмийн халамж, хамгаалалт шаардлагатай хүүхэд"-ийг 28 дугаар цэцэрлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, 2020-2021 оны хичээлийн жилд тус цэцэрлэгт хорооны Засаг даргын тодорхойлолт, нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн нийт 250 хүүхдийг хамруулсан.

11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг "Зайсан Гэрэлт ордон" цэцэрлэгээс "Тус цэцэрлэгийн орчинд барилгын ажил явагдаж хүүхдийн аюулгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй орчин үүссэн" тухай ирсэн гомдлын дагуу газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцсан бөгөөд дээрх барилгын ажлыг явуулж буй холбогдох хүмүүстэй уулзаж аюулгүй байдлыг хангуулан норм, стандартын дагуу хамгаалалт хийн ажиллах шаардлага тавьсан.

19 дүгээр хороонд байрлалтай 218 дугаар цэцэрлэгийн салбар "НОМУУХАН" цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж тус хорооны хүүхдүүдийг дээрх салбар цэцэрлэгт хамруулах боломжийг судлаж шийдвэрлэх чиглэл өгсөн.

ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

2021 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай ажлын саналын жагсаалтыг хороод, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сургууль, цэцэрлэгүүд, дэргэдэх хэлтэс, албадаас авч, нэгтгэн боловсруулж улс, нийслэлийн төсвийн төсөлд тусгуулахаар 1,420.0 сая төгрөгийн 25 ажлын саналыг НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 06/1162 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг дарга болон Хан-Уул дүүргийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээний төслийг НЗДТГ-т хүлээлгэж өгч, гэрээ байгуулагдсан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын дарга нартай байгуулах дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээг батлуулсан.

Дүүргийн шинээр байгуулагдсан 15, 17, 19, 20 дугаар хороодын цогцолбор байрны газрын байршлыг ХУД-ИЙН Газар, зохион байгуулалтын албаар судлуулж, кадастрын зургийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд тус газруудын гэрээ, гэрчилгээг гаргуулахаар ЗДТГ-ын дугаар албан бичгийг даргын 2020.10.26-ны өдрийн 06/ 1162 албан бичгийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Цогцолбор барилгын төслийг улс, нийслэлийн төсөвт уламжилсан.



Ногоон байгууламжийн чиглэлээр:

- 120 мянгатын 14,15 дугаар байрны 2500м² талбайн нөхөн зүлэгжүүлэлт хийж, 10 мянган ширхэг цэцгийн үрсэлгээ, 3700 ширхэг хайлаас, 55 ширхэг шилмүүст, 25 бут сөөг тус тус тарих ажлыг 46 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийсэн
- 11 дүгээр хороо Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтийн ажил болон ногоон байгууламж, 40 мянган ширхэг цэцгийн үрсэлгээг тарих ажил шинээр хийгдсэн.



Мод хэлбэржүүлэлтийн чиглэлээр: Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайн, орон сууц хороолол дундах 3273 ширхэг улиас модны хэлбэржүүлэлтийн ажил хийгдсэн.



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч дүүргийн 1 дүгээр хорооны 8, 10, 11, 12, 32, 37 дугаар байруудын дунд нийтийн эзэмшлийн талбайн 4 байршилд ойн төгөл байгуулах, Нисэхийн тойргоос Чингисийн хүрээ хүртэлх зам дагуу мод, бут, сөөг тарих ажлыг гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 10 ширхэг монос, 223 ширхэг далан хальс, 505 ширхэг

тэхийн шээг, 25 ширхэг агч, 10 ширхэг гацуур, 24 ширхэг хус, 1185 ширхэг улиас, 49780 ширхэг хайлаасыг шинээр тарьсан.



Дүүргийн нутаг дэвсгэрт асахгүй байсан нийт 1276 гэрэлтүүлгийн толгойн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр, хороолол, орон сууцны гэрэлтүүлэгт 6 удаагийн хяналт шалгалт хийсэн. Гэрэлтүүлгийн асалт 98%-тай байна.



Нисэхийн тойрог, Гэгээнтэнгийн уулзвар болон 5, 16 дугаар хорооны гэр хорооллын гудамжинд унасан байсан 5 гэрэлтүүлгийн шонг засварлаж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.



Хог хаягдал цуглуулах, ачиж тээвэрлэлт:

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, гэр хороолол, орон сууц хороололоос нийт 708975.51 тн хог хаягдлыг нийт 25009 тн удаагийн рейсээр тээвэрлэсэн.



Зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ:

"Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ, "Хан-Уул Агро" ОНӨААТҮГ - ууд хариуцсан нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайг тогтмол хуваарийн дагуу цэвэрлэж 570,4 тн хог хаягдлыг 148 рейсээр ачиж тээвэрлэсэн.



Нийтийн эзэмшлийн талбайд байрлах 5 бункерийг будаж өнгийг сэргээв.



Хан-Уул дүүргийн 9, 10, 12, 13, 14, 16-р хороодын үерийн далан, суваг шуудууг цэвэрлэх ажлыг иргэдийн бүлэгтэй хамтран хийж гүйцэтгэсэн. Нийт 8 рейсээр 14,5 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн ажиллалаа.

Байгаль орчин агаарын бохирдолын чиглэлээр:

2020 оны 01 дүгээр сард Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын "Агаарын чанарын хяналтын хэлтэс", Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газартай хамтарч 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуух эзэмшигч 32 аж ахуйн нэгж байгууллагад тус зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд яндандаа шүүлтүүр суурилуулах, түүхий нүүрс тээвэрлэх эрх авах, маршрут батлуулах чиглэлээр 4 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан.



Эрсдэлтэй айл өрхийн судалгааг гаргаж дүүргийн Засаг даргын 2019 оны А/399 дүгээр захирамжаар эрсдэлтэй айл өрхүүдийн зуух, янданг сэлбэх, засварлах засварын 3 бригадыг байгуулж ажиллуулсан бөгөөд тус засварын бригад 262 өрхийн янданг хөөлж, 279 өрхийн зуухны ан цавыг битүүмжлэх, 230 өрхийн зуухны эвдрэлийг галнаж засварлах арга хэмжээг авч нийт 771 өрхийг угаартах эрсдэлээс урьдчилан сэргийлсэн. Мөн судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн өрхүүдээс гадна 348 айл өрхийн ханан пийшинг хөөлөх, яндан засварлах, зуух гагнах болон 798 өрхөд угаар мэдрэгч суурилуулах ажлыг гүйцэтгэсэн.



Дүүргийн Засаг даргын 2020 оны А/120 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан газрын хөдлөлт гэсэлтийн хугацаатай холбогдуулан түгээмэл тархацтай ашигт малтмалын тээвэрлэлтийг хязгаарлах, хориглох ажлыг 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан. Захирамжийн хүрээнд нийт 1079 тээврийн хэрэгслийг шалгаж 631 зөрчил илрүүлснээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 561 тээврийн хэрэгслийн жолоочид 12,740,000 төгрөгийн бэлэн бус торгууль ногдуулж, цагдаагийн нийтлэг үүргийн дагуу 11 зөрчил илрүүлсэн бөгөөд тухай бүр зөрчил заагдсан аж ахуйн нэгж байгууллагад албан мэдэгдэл хүргүүлж ажилласан байна.



Замын цагдаагийн хэлтэстэй хамтарч дүүргийн болон Төв аймгийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудаас тээвэрлэлт хийдэг авто тээврийн хэрэгслийн жин, оврын зөвшөөрөгдөх даацын үзүүлэлтээс хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011 стандартад заасны дагуу хязгаарлах, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авч, тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Засаг даргын 2020 оны А/178 дугаар захирамжаар хайрга, дайрга олборлодог аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа, тээвэрлэлтэд хяналт тавих зорилгоор 13 дугаар хорооны 7 дугаар хэсэг, 21 дүгээр хорооны 6 дугаар хэсгийн нутаг дэвсгэрт шинээр 2 хяналтын цэг, 2 автомат хаалт, 1 механик хаалтыг шинээр байгуулсан.



ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

ХҮНС,

Салбарын хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэх үүднээс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 623, хоол үйлдвэрлэлийн 316, аялал жуулчлалын 24, ахуйн үйлчилгээний 108, жижиг, дунд үйлдвэрлэлийн 96, авто засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 40, нийт 1013 иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрчилгээ олгосон.



Тамхи худалдах тусгай зөвшөөрийг 140 иргэн, аж ахуйн нэгжид олгож, дүүргийн төсөвт 35 сая төгрөг төвлөрүүлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтран 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 380 гаруй аж ахуйн нэгж хамрагдаж, гарсан зөрчлийг арилгуулж ажилласан.

Хураагдсан 4376 ширхэг архи, тамхийг үнэлүүлж, улсын орлого болгох ажлыг зохион байгуулсан.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зөвшөөрөлгүй байршуулсан ТҮЦ-ийг дүүргийн Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын алба, хороодтой хамтран нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.



БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР:

Цэргийн бүртгэл: Дүүргийн Засаг даргын 2019 оны А/434 дүгээр захирамжаар 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 07-ны өдрийг дуустал зохион байгуулагдсан 2020 оны цэргийн бүртгэлийн нэгдсэн семинарыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж 21 хорооны Засаг дарга нар 76.1 хувь, /1, 2, 3, 4, 5, 6 дугаар хорооны Засаг нар оролцоогүй/, Зохион байгуулагч нар 100 хувийн ирцтэй тус тус оролцсон.

Семинарын хөтөлбөрийн дагуу Тоо бүртгэлийн офицер, ахмад Н.Насанбат цэргийн бүртгэлийг зохион байгуулах талаар сургалт, мэдээллийн аюулгүй байдлын офицер, ахмад Н.Цэцэгбал мэдээллийн аюулгүй байдлыг сахиж ажиллах талаар зөвлөмжийг тус тус өгч, төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу 16 хорооны Засаг дарга, 21 хорооны зохион байгуулагч нараас төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг /маягт№2/ гаргуулсан.

2020 оны цэргийн бүртгэл зохион байгуулахад хөтөлгөдөг маягт, хаяг, сурталчилгааны зурагт хуудас, хорооны цэргийн бүртгэлийн мэдээллийн сан, бүртгэлийн тэмдэг, цэргийн үүрэгтний үнэмлэх бусад шаардлагатай зүйлсийг 21 хороонд бүрэн хүлээлгэн өгсөн.

2020 оны 18-50 насны иргэдийн цэргийн бүртгэлийг зохион байгуулах дүүргийн Засаг даргын 2019 оны А/434 дүгээр захирамжаар батлагдсан комисс, цэргийн бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулах, хороо хариуцсан хэлтэс, албадын дарга нарт цэргийн бүртгэлийг хороонд зохион байгуулах, хяналт тогтоох, хамтран ажиллах, батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх талаар дэмжлэг үзүүлж ажиллах чиглэл зөвлөмж өгч, хороодод ажиллах хуваарийг танилцуулан хэлтэс, албадын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан.

Цэргийн бүртгэлийн бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн Статистикийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн хүн амын бүртгэлийн 17-49 насны иргэдийн тоог хорооны хүн амын А данстай тулган, цэргийн бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээллийн баазтай тулгалт хийн бүртгэлд хамрагдах иргэдийн тоог хороо бүрээр гарган өгч, мэдээллийн сангаас хороодын цэргийн бүртгэлийн мэдээллийн санг файлаар нь гаргасан. Бүртгэлийн үед шаардагдах маягт, хүснэгтүүдийг стандартын дагуу хэвлүүлэн, дүүргийн аж ахуйн нэгж байгууллагад нэрийн жагсаалтаар бүртгэл явуулах албан даалгаврыг хүргүүлэн, мэдээлэл сурталчилгааны ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажилласан.



Цэргийн бүртгэлийн явц: Дүүргийн хэмжээнд 2020 оны цэргийн бүртгэлийн нээлтийн ажиллагааг 10 дугаар хорооны байранд эхлүүлж, ТВ-5 телевизээр 10 дугаар хорооны Засаг дарга Ц.Цинзоригт, Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, ахмад Н.Насанбат нар мэдээлэл хийсэн.

2020 оны цэргийн бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 02 дугаар сарын 07-ны өдрүүдэд Засаг захиргааны үндсэн нэгж хороонд төвлөрүүлэн, хорооны Засаг дарга нар эрхлэн явуулсан. ЗДТГ-ын Цэргийн штаб цэргийн мэргэжлийн удирдлагаар, хуулийн дагуу Засаг даргын Тамгын газрын дарга захиргааны удирдлагаар ханган ажиллаж, хорооны цэргийн бүртгэлийн хэсгийн ажиллах цагийн хуваарийг баталгаажуулан ажлын өдрүүдэд 09:00-19:00, Бямба гаригт 10:00-17:00, Ням гаригт 12:00-16:00 цагийн хооронд явуулахаар зохион байгуулан, өдөр бүр салбар, комиссын гишүүд хариуцсан хорооны цэргийн бүртгэлийн явц үр дүн, иргэний мэдээллийн баяжилт, шинээр бүртгэгдэж байгаа иргэдэд хөтлөгдөж байгаа маягтуудын хөтлөлтөд хяналт тогтоон ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 60 ААНБ, 16 ерөнхий боловсролын сургууль, 9 их дээд сургуульд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тоот хүргүүлэн 55 ААНБ буюу 88.01 хувь, ЕБС- 100 хувь, их дээд сургууль 86,6 хувь бүртгэлийг хугацаанд нь явуулсан.



Хэвлэл, мэдээлэл сурталчилгааны ажил

2020 оны цэргийн бүртгэл явуулах тухай зар сурталчилгааг төвлөрсөн худалдааны цэгүүд, томоохон ААНБ, хороодын байр, хэсэг гудамж, хүн ам олноор төвлөрсөн газруудад мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг TV-5, NTV, ЭКО телевизүүдэд цэргийн бүртгэлийн сурталчилгааны шторкийг өгч сурталчлах, "Шинэ сонголт" ХХК, "Богд Дэлгэц" ХХК, "Зайсан Скүэр" зэрэг байгууллагуудын LED дэлгэцийг ашиглан сурталчилгааны ажлыг явуулсан.

"Хан-Уул дүүргийн иргэд" Facebook хаяг, хорооны "Facebook" хаягаар цэргийн бүртгэлийн мэдээллийг цацан иргэд цэргийн бүртгэлийн ажилд идэвхтэй оролцох, цэргийн гэрээт алба, цэргийн дүйцүүлэх алба хаах талаар мэдээлэл хүргэн харилцан мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулсан.

2020 оны цэргийн бүртгэлийг хороонд цахим хэлбэрээр зохион байгуулан явуулж байгааг иргэдэд сурталчлах, урьд жилүүдэд цэргийн бүртгэлд хамрагдаж байгаагүй иргэдийг торгууль, шийтгэвэргүйгээр бүртгэлд хамруулах, хорооны зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарыг сургалтад хамруулах зэрэг ажлыг зохион байгуулсаны үр дүнд 2082 иргэн буюу нийт

цэргийн насны иргэдийн 5.1 хувь шинээр бүртгэлд хамрагдаж, дүүргийн хэмжээнд **94.6** хувийн хамралттай бүртгэлийн ажлыг зохион байгуулсан.

Цэргийн бүртгэлийн тоон үзүүлэлт:

2020 оны цэргийн бүртгэлд хамрагдсан цэргийн үүрэгтний тоо: **94,6**

- Бэлтгэл офицер – **0,8**
- Бэлтгэл ахлагч – **0,2**
- 1 дүгээр зэргийн цэргийн үүрэгтэн – **19,2**
- 2 дугаар зэргийн цэргийн үүрэгтэн – **69,8**
- Орон нутагт байгаа цэргийн жинхэнэ алба хааж байгаа офицер, ахлагч- **1,6%**
- Тайван цагт цэргийн жинхэнэ албанд тэнцэхгүй – **0,8%**
- 19-50 насны цэрэгт бүртгэл бүхий эмэгтэйчүүд – **3,6 %**



2020 онд цэргийн бүртгэлд хамрагдсан иргэдийн тоо 0,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан 2020 оны

04 дүгээр сарын 25-ны өдрийн "Орон нутгаас халагдсан дайчдыг хүлээн авах хуваарь", 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Хилийн ангиудаас халагдсан дайчдыг хүлээн авах хуваарь"-ийн дагуу 2020 оны нэгдүгээр ээлжээр Зэвсэгт хүчин болон Хилийн ангиудаас халагдсан дайчдыг хүлээн авах хуваарийг боловсруулан 05 дугаар сарын 01-ний өдөр халагдсан дайчдыг хүлээн авсан.

Зэвсэгт хүчин болон Хилийн ангиудаас халагдсан дайчдыг хүлээн авахдаа бичиг баримтын бүрдлийг шалган авч, шинэ төрлийн коронавируст халдварт өвчнөөс /Ковид-19/ сэргийлэх зорилгоор халагдсан дайчдын болон хүргэж ирсэн офицер, жолооч нарын биеийн дулааныг хэмжиж, нэг удаагийн амны хаалтыг шинээр сольж зүүлэн, гарын халдваргүйтгэл ариутгал хийж, зөвлөгөө мэдээлэл өгч, ар гэрээс нь олон хүн ирүүлэхгүй байхаар зохион байгуулж ажилласан.



Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги, байгууллагаас халагдсан дайчдыг хүлээн аван хүндэтгэл үзүүлэх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон ажил олгогч байгууллагатай хамтран ажлын байранд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги, байгууллагаас халагдсан дайчдыг хүлээн аван хүндэтгэл үзүүлэх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон ажил олгогч байгууллагатай хамтран ажлын байранд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн Соёлын ордонд хүлээн авч, биеийн халууныг үзэж ариутгал халдваргүйжүүлэлтийг хангаж ажилласан.

"Цагдаагийн газар", "Алтан боломж" сургалтын төв, "Эко констракшн" ХХК, "Тэнгэрлэг бамбай" хамгаалалтын алба "Е-март худалдааны төв" зэрэг аж ахуйн нэгж байгууллагын хүний нөөцийн ажилтан, мэргэжилтэн нар ирж оролцсон. Ажлын байранд нийт 73 иргэнийг бүртгэж, 12 иргэн ажил мэргэжлийн сургалтад хамрагдахаар бүртгүүлэн байнгын ажлын байранд 56 иргэнийг зуучилсан.

2020 оны Цэрэг халалт, татлагыг зохион байгуулах чиглэлээр Цэрэг татлагын товчооны гишүүд болон хорооны томилгоот албан тушаалтан нартай мэргэжил арга зүйн сургалт зөвлөгөөнийг зохион байшууллаа.



Цэргийн ар гэрт үзүүлэх халамж үйлчилгээ, халагдсан дайчдыг ажлын байраар хангасан талаар

(давхардсан тоогоор/

Хороод	Байнгын ажлын байранд зуучилсан, оруулсан	Мэргэжил олгох болон давтан сургалтад	Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан	Эд материалын тусламж үзүүлсэн	Бусад халамж үйлчилгээ	Нийт
1-р хороо	1	1	5	3	4	14
2-р хороо	-	-	-	4	2	6
3-р хороо	1	1	2	4	100,000 төг	9
4-р хороо	1	2	5	2	2 хүн 2 тн нүүрс	12
5-р хороо	1	2	3	5	-	11
6-р хороо	-	3	2	-	1	6
7-р хороо	3	1	4	1	2 хүн 0.15 тн нүүрс	11
8-р хороо	3	1	1	-	16	21

9-р хороо	-	-	1	-	3	4
10-р хороо	2	2	7	4	2хүн 0.35тн нүүрс	17
11-р хороо	-	1	-	-	-	1
12-р хороо	-	1	1	-	-	1
13-р хороо	2	1	5	1	3	12
14-р хороо	6	1	5	1	-	13
15-р хороо	-	-	5	-	-	3
16-р хороо	2	1	5	3	2 хүн 2.5 тн нүүрс	13
17-р хороо	1	1	1	-	-	3
18-р хороо	-	-	1	-	-	1
19-р хороо	-	3	4	-	-	7
20-р хороо	-	1	-	-	-	1
21-р хороо	1	-	1	2	1	5
Нийт	24	23	58	33	41	179

Цэрэг татлагын явцын талаар: 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1115, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны А/95 дугаар захирамжаар 2020 оны 10 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд дүүргийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байранд зохион байгуулж, цэрэг татлага явуулахаас 4 хоногийн өмнө дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдээс ирүүлсэн хэргийн учир мөрдөгдөж байгаа болон нийслэлийн Эрүүл мэндийн газраас диспансерийн хяналтад байгаа иргэдийн нэрсийн жагсаалтыг дүүргийн Эрүүл мэндийн төвөөр дамжуулан хүлээн авч Цагдаа болон эрүүл мэндийн байгууллага хяналт тогтоон ажилласан.

- Зарлан дуудах хуудасны тараалт 94,3 хувь
- Цэрэг татлагаар орсон 96,7 хувь

Цэрэг татлагаар орсон нийт иргэдийн:

- Эрүүл мэндээр 17,3 хувь
- Гачигдлаар 1,5 хувь
- Суралцахаар 81,2 хувь
- Хэргийн холбогдлоор 0,1 хувь

Зэвсэгт Хүчин, Хилийн ба дотоодын цэрэгт цэргийн жинхэнэ алба хаалгахаар нийслэлийн Цэрэг татлагын товчооноос өгсөн тоон даалгавраар Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангах цэрэг татлагын тоон даалгавраар Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангах цэрэг татлагын тоон даалгаврыг 100 хувь биелүүлж, цэргийн жинхэнэ албанд татагдагсдын 4 иргэн буюу 2,3 хувь нь дээд боловсролтой, 12 иргэн буюу 7,1 хувь нь тусгай дунд боловсролтой, 150 иргэн буюу 87,7 хувь нь бүрэн дээд боловсролтой, 5 иргэн буюу 2,9 хувь нь бүрэн бус боловсролтой байсан.

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан байдал:

А. Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдал

№		2018	2019	2020
1	Алба хаасан	6	6	13
2	Алба хааж байгаа болон шинээр элссэн		6	13
3	Хасагдсан			3
Одоогоор 16 иргэн дүйцүүлэх албыг биеэр хааж байна.				

Б. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа байдал

№		2020 он
1	Мөнгөн төлбөр тогтоосон	276 иргэн
2	Мөнгөн төлбөр төлсөн	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 276 иргэний 195,073,952 төгрөг төвлөрүүлсэн.
3	Мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн	136 иргэн

Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх ажлын хүрээнд:

В. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/01 дүгээр тушаалаар "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дээшлүүлэх болзолт уралдаан"-ы болзлыг батлуулж, дүүргийн Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нар, Өрхийн эрүүл мэндийн дарга нартай зөвлөгөөнийг 01 дүгээр сарын 09-ний өдөр Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулсан.

Зөвлөгөөнд дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 2019 онд зохион байгуулсан айл, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд болзолт уралдааныг дүгнэж шалгаруулсан тухай илтгэлийг танилцуулсан.

Мөн 2019 оны болзолт уралдаанд тэргүүлсэн Д.Туул даргатай 10 дугаар хорооны "Аминтус" өрхийн эрүүл мэндийн төвөөс цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын тайланг танилцуулсан. Тус зөвлөгөөний төгсгөлд Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд үүрэг, чиглэл өгч, болзолт уралдааны шагналыг дүүргийн Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гардуулсан.

**Цэргийн болон дайчилгааны бэлтгэл сургалтыг зохион байгуулсан талаар:**

Г. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан "Анги, салбарыг бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнээр хангах" сэдвээр дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас илтгэл сонсох хуваарийн дагуу тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер, хурандаа Т.Мөнхбаяр, Төлөвлөлт, сургалтын офицер, ахмад Ц.Энхтайван нар ажилласан.

Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/62 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас өгсөн чиглэлийн дагуу цэргийн дайчилгааны тодотголыг Улаанбаатар цэргийн хүрээний анги

байгууллага болон орон нутгийн цэргийн анги байгууллагуудад хүргүүлэн 2020 оны 05 дугаар сарын 08-29-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний харилцан ажиллагаатай анги, байгууллагад өгөгдсөн командад оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдийг 2020 оны цэргийн бүртгэлийн баримт бичигтэй тулгалт хийн шалгахад /шилжсэн, гадаадад, хаягандаа байхгүй, нас барсан гэх мэт/ шалтгаанаар өөрчлөлт орсон бэлтгэл офицерын 9.2 хувь, цэргийн үүрэгтний 20.4 хувийг шинээр оногдуулан бүртгэж, оногдуулан бүртгэлийн мэдээг нэрийн жагсаалт, анги, команд, хороогоор улирал бүр хорооноос гаргуулан авч, гарсан өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн бүртгэж ажилласан.

Зэвсэгт хүчний харилцан ажиллагаатай анги, байгууллагад дайчилгааны үед харилцан ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө, тодотгол явуулсан тухай акт, оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтэн, автотехникийн жагсаалт, чанар байдлын судалгааг Зэвсэгт хүчний Жанжин штабын нууц шуудангаар хүргүүлж, ангиудын угтах байр, хүч хуралдуулах район, зам маршрут, очих хугацаа, харилцан ажиллагаа, холбоо барих утас, хүн, техник хүлээн авах байр, дүүргийн цугларах, техник шилжүүлэх байрын тодотголыг бүрэн хийсэн.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад хамрагдах иргэдийн судалгааг гаргаж, мэдэгдэх хуудас хүргүүлэн сургалтын гэрээг байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг Зэвсэгт хүчний дугаар ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтын төвийн даргын хамт боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга болон Зэвсэгт хүчний дугаар ангийн захирагчаар батлуулан сургалтыг зохион байгуулсан.

Дүүргийн /Улсын/ дайчилгааны төлөвлөгөөг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тодотгосон. Улсын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулахад оролцсон холбогдох хэлтэс албадын албан тушаалтнуудыг татан оролцуулан улсын дайчилгааны төлөвлөгөөг холбогдох чиглэлээр тодотгох ажлыг зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Эрдэнэчимэгтэй дүүргийн /улсын/ дайчилгааны төлөвлөгөө хариуцсан мэргэжилтнийг холбон заавар, зөвлөмжөөр хангаж хамтран ажилласан.

Дүүргийн бэлэн байдлын дохионы хадгалалт хамгаалалтад сар бүр үзлэг хийн тэмдэглэл хөтөлж, Засаг даргын Тамгын газрын харуул хамгаалалтын албаны ажилчидтай зарлан мэдээллийн дохиог ашиглах заавар, журмыг танилцуулан үүрэг гүйцэтгэх, сургалт дадлагыг 2 удаа зохион байгуулсан.

Цэргийн болон дайчилгааны бэлтгэл сургалтыг зохион байгуулсан талаар:

А. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэд үүрэг гүйцэтгэх хугацаанд дараах үйл ажиллагаанд оролцсон. Үүнд:

Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан тоогоор дүүргийн Засаг даргын 2020 оны А/235 дугаар захирамжаар 13 иргэнийг цэргийн дүйцүүлэх алба хаалгахаар элсүүлэн гэрээ байгуулсан.

Дүүргийн Засаг даргын 2020 оны А/236 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаасан 6 иргэнийг цэргийн жинхэнэ албыг биеэр дүйцүүлэн хааснаар тооцон халж, цэргийн 2 дугаар эргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэлд авсан. Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн шинээр элссэн цэргийн дүйцүүлэх алба хаагч нартай 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан хөтөлбөрийн дагуу 1 өдрийн сургалтыг цэргийн бэлтгэл шатны хичээлээр зохион байгуулсан.

Дүйцүүлэх алба хаагч нарын бэлтгэл болон тусгай үүргийн сургалт:

Б. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8, Монгол Улсын

Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, 2019 оны 336 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий сайдын 2020 оны 92 дугаар захирамж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 18 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1 109 дүгээр захирамжийн дагуу Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт"-ыг дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран 2020 оны 09 дүгээр сарын 18-24-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албаны бэлтгэл, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт 09 дүгээр сарын 18-аас Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Сургалтад хамрагдаж байгаа бие бүрэлдэхүүн Улсын Онцгой комиссын зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин сургалтын хөтөлбөрийн дагуу батлан хамгаалах эрх зүй, цэрэг эх оронч хүмүүжил, цэргийн нийтлэг дүрмүүд, үй олноор хөнөөх зэвсэглэлээс хамгаалах бэлтгэл, цэргийн инженерийн бэлтгэл, биеийн тамирын бэлтгэл, орон нутгийн болон улсын хил хамгаалалт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, амьд гарах ухаан зэрэг хичээл орсон.

Мөн Улсын болон орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Налайх дүүргийн 2,8 дугаар хорооны орчны хог цэвэрлэх дүүргийн автобусны буудлуудыг тохижуулах зэрэг ажил хийж гүйцэтгэлээ. Сургалтын хугацаанд гамшиг ослын үеийн ажил, түймрийн үеийн ажил, аврах ажлын үндэс зэрэг хичээлүүдэд Онцгой байдлын албаны багш багаж хэрэгсэл дээр хичээлийг онол, дадлагаар явуулсан.

Сургалтыг хөтөлбөр, хичээлийн хуваарийн дагуу орон нутгийн хамгаалалт-14 цаг, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа-38 цаг, хүмүүнлэгийн үйл ажиллагаа- 4 цаг, улсын болон орон нутгийн бүтээн байгуулалт-10 цаг, амьд гарах арга ухаан-14 цаг зэрэг 6 сэдвээр 80 цагийн багтаамжтай хичээлээр онолын мэдлэг, дадлага олгож, сургалтын програмыг бүрэн хангаж, хөтөлбөрийн дагуу батлан хамгаалах эрх зүй, цэрэг эх оронч хүмүүжил, цэргийн нийтлэг дүрмүүд, үй олноор хөнөөх зэвсэглэлээс хамгаалах бэлтгэл, цэргийн инженерийн бэлтгэл, биеийн тамирын бэлтгэл, орон нутгийн болон улсын хил хамгаалалт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, амьд гарах ухаан зэрэг хичээл орсон. Сургалтын төгсгөл дүйцүүлэх цэргийн алба хаагчид гэрчилгээ гардуулсан.

В. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/15 дугаар тушаалын дагуу Зэвсэгт хүчний 186 дугаар ангитай явуулах стратегийн команд штабын хээрийн сургуульд нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицерууд 2020 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд оролцсон.

Тус дүүргээс дайчилгааны офицер, дэслэгч Ц.Чингүүнболд



оролцсон.



Г. Бэлтгэл офицерын сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж, тус дүүргийн цэргийн бэлтгэл үүрэгтнүүд цэргийн тангараг өргөж, 2 үе шаттай сургалтад амжилттай оролцсон. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн сургуулийн захирал нарын хамтран баталсан 144 цагийн хичээлийн хөтөлбөрөөр бэлтгэл офицерын дамжааны сургалтыг дайчилгааны бэлтгэл нөөцийг нөхөн хангах шаардлагатай мэргэжлээр нийт 30 цэргийн үүрэгтнүүдтэй Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн сургуулийн Ерөнхий цэргийн болон Цэргийн инженерийн тэнхимийг түшиглэн



явуулсан.

Д. Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны н/01 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/24 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/90 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн 2020 оны 09 дүгээр сарын 10-наас өдрөөс 23-ны өдрүүдэд дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдсан бэлтгэл үүрэгтэнүүдийг онгодуулан дансалж, мэдээллийн санд оруулсан.



Е. Халагдсан дайчдын мэдээллийг Цэргийн штабын мэдээллийн санд бүртгэж, анги, командад оногдуулсан дансалсан.



Нийслэлийн Засаг даргын 2020 оны тоот албан даалгаврыг үндэслэн 2020 онд ашиглах дадлагын дохиог Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны тоот захирамж батлуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас улирлын дохиог нийт 2 удаа, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас дотоодод тогтоосон зарлан мэдээллийн дохиог 2 удаа дүүргийн дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, Цэргийн штабын тайван цагийн бүрэлдэхүүн, Хан-Уул дүүргийн 21 хороо, дүүргийн цугларах, шилжүүлэх байруудад тус тус өгч ажилласан.



Ё. Цэргийн штабын 2020 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтыг коронавирусын цар тахлын нөхцөл байдлын үед бүх нийтийн бэлэн байдлын зэргийг хэрэгжүүлэн "Zoom" програмыг ашиглан сургалтын онлайн хэлбэрээр 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан.

Тус сургалтаар:

"Дайчилгааны тухай хуулийн өөрчлөлт, түүнтэй уялдан шинэчлэн найруулсан дайчилгааны журмуудыг танилцуулах" Батлан хамгаалах яамны СБТГ-ын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа С.Рагчаадорж;

"Төрийн болон албаны нууцын эрх зүйн орчин, нууц хадгалалт хамгаалалтын асуудал" Батлан хамгаалах яамны нууцын дарга, дэд хурандаа О.Ууганбаяр;

"Жендерийн мэдрэмжтэй байгууллагыг төлөвшүүлэх, байгууллага дахь жендерийн соёл". Жендерийн үндэсний хорооны зөвлөх Т.Амгалан;

"Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт" Авлигатай тэмцэх газрын Олон нийттэй харилцах, соёл гэгээрүүлэх хэлтсийн ахлах комиссар Г.Дамдинсүрэн нар тус тус илтгэл тавьсан.

Сургалтын үеэр "Авлигаас ангид төрийн үйлчилгээг үзүүлэх" уриалгыг нийт бүрэлдэхүүнд танилцуулж, гарыг үсэг зуран баталгаажуулсан.

Цэргийн штабын бие бүрэлдэхүүн ажлын байр, дүүргийн шуурхай штаб, гэр болон Исламын Бүгд найрамдах Афганистан Улсад энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын Шуурхай байдлын ахлагч, ахлагч О.Дэлгэрдалай тухайн газар орноос сургалтын орчин бүрдүүлэн оролцож, бие бүрэлдэхүүний 100 хувийн ирцтэй оролцлоо.

Тус сургалтаар тавьсан зорилтоо бүрэн биелүүлж, сургалтын явцад ямар нэг тасалдал, доголдол гараагүй зохион байгуулагдсан нь үр дүнтэй болсон.



Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын талаар:

Төрийн албаны тухай хуулийн дагуу ажилтны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын архивын ажлын төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаа. 2020 оны цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтыг сахин ажиллах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

А. Төрийн болон албаны нууцын тухай хууль, цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр цэргийн бүртгэлийн нэгдсэн семинараар дүүргийн 21 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт танилцуулга хийн зөвлөмж өгч, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа /маягт №2/-г бэлтгэж, нууцын баталгаа гаргуулсан.

Засаг захиргааны бүтцийн дагуу нэмэгдсэн 5 хороо буюу 17-21 дүгээр хороонд 2020 оны цэргийн бүртгэлийн бүртгэлийн тэмдэг шинээр хийлгэж, цэргийн бүртгэлийн тэмдэг, хорооны мэдээллийн сангийн нууц мэдээлэл тээгчийг бүртгэлээр 21 хорооны зохион байгуулагчид хүлээлгэн өгч, мөн бүртгэлийн үед хорооны мэдээллийн сангийн нууц мэдээлэл тээгчийг ажилтнууд хүлээлцэх бүртгэлийн дэвтэр, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах зөвлөмж зэргийг бэлтгэн хүлээлгэн өгч өдөр тутмын зөвлөмжөөр ханган ажилласанаар ямар нэг зөрчил дутагдалгүй зохион байгуулагдсан.

Нэг. Төрийн болон албаны нууцын тухай хууль, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:

Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг судлан албан тушаалтан бүрийн биелүүлэх эрх, үүрэг ажилдаа мөрдөх заавар журмуудыг судлуулсан, нууцын баталгаа авах, ажил үүргийн хуваарьт нь тусгах мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаа.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.

Цэргийн штабын мэдээлэл боловсруулдаг компьютерүүдэд Мэдээллийн технологи, цахим сан хариуцсан мэргэжилтнээр албан ёсны эрхтэй вирусны програмыг суулгуулж бүртгэлийг /маягт №19/ хөтөлсөн.

Цэргийн штабын нууц, албан хэрэгцээний мэдээлэл боловсруулдаг компьютерын файлын эмх цэгцэд үзлэг хийх удирдамж боловсруулан Цэргийн штабын даргаар батлуулан дүүргийн Мэдээллийн технологийн ажилтантай хамтран 2020 оны 09, 11 дүгээр саруудад 2 удаа үзлэг шалгалтыг зохион байгуулж, актыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлсэн. Үзлэгээр офицер, ахлагч нарын компьютерын файл эмх цэгцгүй, он оноор төрөлжүүлээгүй зэрэг нийтлэг дутагдал илэрснийг албан тушаалтан бүрд зөвлөмж өгөн цэгцлэх ажлыг зохион байгуулсан.

Хоёр. Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын хэрэгжилтийн хүрээнд:

Дайчилгааны нууц бичиг хэргийн ерөө нь "Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 10.1 дэх хэсэг, "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын 17 дугаар бүлгийн 17.1, 17.2, 17.4, 17.11- /а, б, в, г, д, е/-ийн заалтуудын дагуу биет хамгаалалтын шаардлагад нийцүүлэн төхөөрөмжилж, гал унтраах багаж хэрэгсэл, сейф, цахим мэдээлэл боловсруулах техник хэрэгслээр хангагдсан нь нууц баримт бичиг боловсруулах, хадгалах, олшруулах, төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын шаардлагыг ханган ажилласан.

Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөө түүнд холбогдох баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг боловсруулж танилцах эрхийн түвшинг тогтоон дүүргийн Засаг даргын 2020 оны А/66 дугаар захирамжаар батлуулан, Засаг даргын Тамгын газрын холбогдох ажилтан, хорооны Засаг дарга нар, цугларах, шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнд Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын холбогдох заалт, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 4 дүгээр бүлгийн 4.3.2, 4.3.4 дэх заалтыг танилцуулан эрх, үүрэг, хориглох зүйлийг танилцуулан зааварчилгаа өгч хүн нэг бүрээр баталгаа гаргуулсан.

Цэргийн штабын бие бүрэлдэхүүнд Төрийн болон албаны нууцын тухай хууль, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам, баримт бичгийн стандартаар 05 дугаар сарын 27-ны өдөр хичээл зааж, мэдлэг шалгах сорилыг авч, харилцан ярилцлага зохион байгуулан ажилласан.

Цэргийн штабаас дүүргийн 21 хорооны зохион байгуулагч нартай 2020 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан цэргийн бэлтгэл сургалтаар мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын талаар хичээл зааж, нууц баримт бичгийн хадгалалт хамгаалалтын талаар зөвлөмжийг өгсөн.

Хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох заалт, нууц хадгалалт хамгаалалтын талаар өдөр тутамд мөрдөн ажиллах санамжийг оруулсан гарын авлагыг бэлтгэн тараасан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/58 дугаар тушаалаар томилогдсон тооллогын ажлын хэсгийн ахлагчид хурандаа Г.Жаргалсайхан, гишүүдэд ахмад Н.Насанбат, ахлах ахлагч М.Төрмандх нарын бүрэлдэхүүнтэй комисс Цэргийн штабын дайчилгааны бичиг хэрэгт хадгалагдаж байгаа дайчилгааны бэлэн байдлын онц чухал-маш нууц, маш нууц, нууц ном, баримт бичгийн 2020 оны жилийн эцсийн тооллого шалгалтыг 2020 оны 11 дүгээр сарын сарын 23-25-ны өдрүүдэд явуулж, тооллогын өгүүлбэр, хүснэгт актыг Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүлсэн.

Гурав. Архивын үйл ажиллагааны хүрээнд:

2010-2014 оны байнга хадгалах нууц, албан хэрэгцээний хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ-техник боловсруулалт хийж, бүртгэлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх ББНШК-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар хурлаар хянан хэлэлцүүлэхээр хүргүүлж, шийдвэрлүүлэн хурлын тэмдэглэлийг ирүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх ББНШК-ын шийдвэрийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/57 дугаар тушаалаар томилогдсон баримт бичиг устгах ажлын хэсгийн гишүүдийн хамт устгах архивын 26 баримтыг бүртгэлтэй нь нэг бүрчлэн тулган шалгаж, 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Онцгой байдлын аврах 34 дүгээр ангийн нам даралтын зууханд шатаах замаар бүрэн устгаж, данс бүртгэлд хөдөлгөөнийг тусгасан.

Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан ББНШК-ын хурлаар Батлан хамгаалахын Төв архивт шилжүүлэхээр шийдвэрлэсэн нууц, илт баримтыг хүргүүлэхэд бэлтгэсэн.

Цэргийн штабын 2015-2020 оны түүхчилсэн лавлахыг 2 хувь боловсруулан 1 дүгээр хувийг 2020 оны н/18 дугаар албан бичгээр Батлан хамгаалахын төв архивт хүргүүлсэн.

Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газраас ирүүлсэн 2020 оны 5/1538 дугаар албан бичгийн дагуу 2014-2019 онд "Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж цэргийн бүртгэлд бүртгэгдсэн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний нэрийн жагсаалт, суралцагчийн бүрдүүлсэн 6 ширхэг архивын баримтыг Төрийн архивт шилжүүлэх акт №02-р ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын Цэргийн дайчилгааны хэлтсийн бэлтгэл нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Л.Батжаргалд 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр хүлээлгэн өгсөн.

а. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт

Цэргийн штабын 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргэдэх ББНШК-ын 2020 оны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулж, жагсаалтын дагуу албан хэрэгцээний 24 хавтаст хэрэг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хөтлөгдөж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтаст хэргүүдийг шинэчилсэн.

б. Баримт бичгийн эргэлт, түүний зохион байгуулалт

2020 оны жилийн эцсийн байдлаар 32 хариутай бичиг ирж, тухай бүр удирдлагад танилцуулан шийдвэрлэлтэд хяналт тавьж, шийдвэрлэлтийн явц үр дүнг тооцон мэдээ тайланг гаргаж ажилласан.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, батлагдсан хуваарийн дагуу Цэргийн штабын офицеруудаас 2020 оны 1 дүгээр улиралд 50 хадгаламжийн нэгжийг хүлээн авч байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийсэн.

в. Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, ашиглалт бүртгэл

Цэргийн штабын тэмдэг, лацны тэмдэгийг шилжүүлэх бүрд дансны бүртгэлийг жилийн турш хөтлөн ажилласан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор засаг захиргааны анхан шатны нэгж 5 хороо нэмж байгуулагдсантай холбогдуулан бүртгэлийн тэмдэгийг 17, 18, 19, 20, 21 дүгээр хороонд /5 ширхэг/ шинээр хийлгүүлэн бүртгэлд бүртгэж, бүртгэлийн үед хүлээлгэн өгч, ашиглалт, хадгалалтад хяналт тавин, хүлээн авсан.

Дүүргийн 21 хорооны Засаг даргын албаны нууц баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 21 ширхэг лацыг хийлгэн бэлтгэсэн.

Цэргийн штабын Хэвлэмэл хуудсыг холбогдох заавар, дүрэм стандартын дагуу хэвлүүлэн, нэр төрлөөр нь ангилж хэвлэмэл хуудасны ашиглалтын бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн.

Цэргийн штабаас аж ахуйн нэгж байгууллагуудад цэргийн үүргийн биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн дүнгийн талаар:

2020 оны жилийн эцсийн байдлаар Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад 12 байгууллагын 18-50 насны 1305 цэргийн үүрэгтний нэрсийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 1020 буюу 72 хувийг хамруулснаас 34.6 хувь нь зөрчилтэй байсан. 1971-1994 онд төрсөн 72 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос 32 иргэн төлбөр төлж, 16,321,320 төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.

д/ д	Байгууллага нэгжийн нэр	Хүний тоо	ЦЖА хаасан	ЦДА хаасан	Мөнгөн төлбөрөөр хаасан	Цэргийн алба хаагаагүй	Мөнгөн төлбөр		
							Төлбөр төлөх хүний тоо /мөнгөн дүн/	Төлсөн хүний тоо /мөнгөн дүн/	Төлөөгүй хүний тоо /мөнгөн дүн/
1	"Атар өргөө" ХК	48	23	3	7	7	4/ 1.493.648	2/ 796.716	696.932
2	Жем-Интернэшнл	138	68	1	20	35	7/ 4.383.585	5/ 3.239.550	1.144.035
3	NTV телевиз	23	9	0	3	11	5/ 2.382.773	1/ 633.420	2.319.431
4	"Биокомбинат" ОНӨҮГ	69	39	1	14	16	5/ 2.583.268	2/ 492.898	2.090.370
5	МИАТ	321	164	7	69	54	6/ 2.132.517	3/ 1.063.550	1.068.967
6	"Таван богд" ХК	98	53	1	17	18	10/ 4.284.464	2/ 1.343.109	2.941.355
7	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Удирдлагын академи"	26	6	0	18	0	-	-	-
8	"Хурд" групп	67	37	0	16	12	7/ 5.030.648	6/ 4.141.523	889.125
9	"ДЦС-З" ХК	409	273	7	61	54	19/ 7.082.926	6/ 3.501.333	3.581.593
10	"Хөнгөн бетон" ХК	12	9	0	1	1	1/ 402.665	0	402.665
11	"Монфреш" групп	16	8	0	5	3	1/ 368.587	1/ 368.587	-
12	"Витавит" групп	78	38	3	7	23	5/ 2.493.553	2/ 1.306.716	1.186.837
	БҮГД	1305	727	23	238	234	28.497.111	16.317.324	16.321.320

Бусад зохион байгуулалтын арга хэмжээний талаар:

Монгол улсад Генерал цол бий болсны 76 жилийн ойг тохиолдуулан Хан-Уул дүүрэгт оршин суудаг 15 генерал цолтнуудад уламжлал ёсоор дүүргийн Засаг даргын мэндчилгээ, дурсгалын зүйлийг Цэргийн штабын дарга дэд хурандаа Г.Жаргалсайхан гардуулж, хүндэтгэл үзүүлсэн.



❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 95 жилийн ойн баярыг тохиолдуулан тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас чөлөөнд гарсан бэлтгэл хурандаа А.Баттулга, Д.Мөнхбат, бэлтгэл дэд хурандаа Д.Даваа, Ж.Жаргалсайхан, бэлтгэл ахмад Б.Ганчимэг нарт хүндэтгэл үзүүлэн нийслэл, дүүргийн дурсгалын зүйлийг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.



❖ 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойн хүрээнд дайнд оролцсон тус дүүргийн ахмад дайчин Р.Лувсанбалдан, С.Чимэддорж, С.Дуламсүрэн нарт Оросын холбооны Улсын Элчин сайдын яамнаас хүндэтгэл үзүүлэн 1941-1945 оны аугаа эх орны дайны ялалтын 75 жилийн ойн медалийг гардуулсан.

1945 оны чөлөөлөх дайны түүхэн ялалтын 75 жилийн ойг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран зохион байгуулсан Тус арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Х.Баттулга хүрэлцэн ирж ахмад дайчдад баяр хүргэж "Сүхбаатарын одонгоор Р.Лувсанбалдан, "Алтан гадас" одонгоор С.Дуламсүрэн, "Цэргийн хүндэт медалиар Г.Цэрэнлхам нарт гардуулсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд, Цэргийн штабын дарга, дэд хурандаа Г.Жаргалсайхан нар ахмад дайчдын гэрт нь очиж дүүргийн "БАХАРХАЛ", буцалтгүй мөнгөн тэтгэмжийг гардуулж, хүндэтгэл үзүүлсэн.

1-р хорооны иргэн, ахмад дайчин Г.Цэрэнлхам, Д.Чимэд нар



❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас ирүүлсэн хуваарийн дагуу

нийслэлээс Зэвсэгт хүчний 120 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа 65 дайчинд коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор амин дэм, гар ариутгагч, 300 ширхэг амны хаалтыг цэргийн албан хаагч нэг бүрт гардуулан өгч, эргэх ажлыг 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан.



❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан тусгай үүргийн онгоцоор ирсэн иргэдэд хоол хүргэх хуваарь, Цэргийн штабын даргын тушаалын дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 04 дүгээр сар болон 7 дугаар сард "Тоёоко инн" зочид буудалд тусгаарлалтад байсан 273 иргэнд Улсын онцгой комиссын шуурхай штабын дарга хурандаа Б.Ууганбаярын баталсан хоол хүргэх цагийн хуваарийн дагуу халуун хоол, цайг тогтоосон хугацаанд хүргэж өгч ажилласан. Ажиллахад хэрэглэх хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын шингэн, нэг удаагийн амны хаалт, малгай, бээлий, нүүрний хаалт, улавчаар үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг бүрэн хангаж ажилласан.



❖ Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойн өдрийг тохиолдуулан төрийн далбаа, нийслэлийн туг мандуулах ёслолын ажиллагааг 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 011, 120, 303, 326 дугаар ангиудад нэгэн зэрэг зохион байгуулсан.



❖ Монгол Цэргийн нэгдсэн холбооны Хан-Уул дүүрэг дэх салбар холбоог байгуулах арга хэмжээг 2020 оны 09 дүгээр сарын 07-ний өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Монгол цэргийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, бригадын генерал Д.Ганбаатар, бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн, бэлтгэл хурандаа С.Маам, Монгол цэргийн нэгдсэн холбооны ажлын албаны ажилтан, бэлтгэл

хурандаа Л.Болдбаатар нар болон салбар холбоог үүсгэн байгуулагч төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас тэтгэвэрт, чөлөөнд гарсан бэлтгэл офицерууд оролцсон.

Хан-Уул дүүрэг дэх салбар холбооны тэргүүнээр дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхланг сонгох саналыг салбар холбоог үүсгэн байгуулагч 16 дугаар хорооны иргэн, бэлтгэл дэд хурандаа Х.Батсүх гаргаж, хуралд оролцогчдын 100 хувийн саналаар Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан сонгогдсон.



3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

2020 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн чиглэлээр нийт 338 тушаалын төслийг боловсруулж батлуулсан. Үүнээс ажлаас чөлөөлөх тухай -130, ажилд томилж тухай -146, ажлаас чөлөөлж, ажилд томилсон тухай -41, буцалтгүй тусламжтай холбоотой -38, нийгмийн баталгааг хангах тухай -2, цалин шинэчлэх тухай -1, чөлөө олгох тухай -4, хугацааны нэмэгдэл олгох тухай -4, нэмэгдэл олгох тухай -17, сургалтын тэтгэлэг олгох тухай -1, урамшуулал олгох тухай -3, жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай -6 тушаалыг тус тус боловсруулан батлуулсан.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд ЗДТГ-ын болон хороодын нийт 41 албан хаагчдад 421,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/173 дугаар тушаалаар Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулж, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу ЗДТГ-ын болон хороодын 8 албан хаагчдыг Япон улсад төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлуулсан. Мөн Удирдлагын Академийн мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад 8 албан хаагчийг хамруулж мэргэшүүлсэн. Албан хаагчдын гаднаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн /EDU S/ байгууллагатай хамтран Англи болон Солонгос хэлний хичээлийг 2020 оны 02 дугаар сараас эхлэн танхимын болон цахим хэлбэрээр үе шаттай зохион байгуулсан. Сургалтад нийт 35 албан хаагч хамрагдаад байна. 2020.10.27-ны өдөр авлигын эсрэг сургалтыг зохион байгуулж 37 албан хаагчийг хамруулсан.

Авлигын эсрэг болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 25 ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд авлигын эсрэг сурталчилгааны самбарыг дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байр, 21 хороодод байршуулсан. Авлигатай тэмцэх газартай хамтран хороодын Засаг дарга, зохион байгуулагч, Хөгжлийн нийгмийн ажилтан,

хэсгийн ахлагч нарт авлигын эсрэг соён гэгээрүүлэх цахим сургалтыг 2020.06.04-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад нийт 237 албан хаагч хамрагдсан. Дүүргийн 21 хороодын иргэдэд авлигын эсрэг соён гэгээрүүлэх 600 ширхэг сурталчилгааны хуудсыг тараасан.

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдал:

Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг төрийн албаны зөвлөлийн www.hr.csc.gov.mn хаягт Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 163 албан хаагчийн мэдээллийг сар бүр шинэчилж оруулсан. Албан хаагчдад, түүний нэмэгдэл олгох тухай саналыг Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04/269 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 15 албан хаагчийн тангарагийг өргүүлж Төрийн жинхэнэ албан хаагч болгон дэвшүүлсэн.

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай ууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажилласан.

2020 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 3233 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд 3127, хугацаа хэтрүүлэн 61 өргөдөл гомдол шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2019 оны тайлант хугацаанд 10 хоног 05 цаг 45 минут байсныг 2020 оны тайлант хугацаанд 08 хоног 22 цаг 08 минут болгон бууруулсан үзүүлэлттэй байна.

Үүнээс: Засаг даргын Тамгын газарт 586 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 570 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 6 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 07 хоног, 09 цаг, 45 минут байна.

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2019/11 сар	2020/11 сар	2019/11 сар	2020/11 сар	2019/11 сар	2020/11 сар	2019/11 сар	2020/11 сар	2019/11 сар	2020/11 сар
ИТХ	1	58	1	58	0	0	07х23 ц 00м	04х07ц 29м	2	77
ЗДТГ	708	586	690	570	4	6	09х02 ц 44м	07х09ц 45м	304	289
Харьяа хэлтэс, алба, тасаг	1498	2045	1402	1974	62	40	11х14 ц 58м	10х06ц 37м	1078	946
Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	26	47	15	45	5	1	08х21 ц 54м	06х19ц 23м	175	52
Хороод	132	270	119	262	11	8	10х 07ц 24м	04х05ц 08м	121	204
Эмнэлэг	133	162	128	154	2	5	09х05 ц 49м	09х21ц 44м	63	257

Сургууль, цэцэрлэг	-	65	-	64	-	1	-	20х22ц 57м	-	0
Дүүргийн хэмжээнд /нийт/	2502	3233	2355	3127	84	61	10х05 ц 45м	08х22ц 08м	1743	1844

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 хоног бүр Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд тус тус танилцуулан, шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөх, өргөдөл гомдлыг удирдлагын түвшинд шуурхай шилжүүлж байх талаар мэдээлэл өгч ажилласан.

Мөн хороодыг "Өргөдөл, гомдлын дэд систем" ERP програмаар иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, уламжлах ажлыг жигдрүүлэхэд анхаарч 14 хоног тутам хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнд шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн танилцуулж, мэргэжил арга зүйгээр хангасан.

Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг "Статистикийн мэдээлэл" гарын авлагад нийтлүүлээ.

Засаг дарга иргэдэд мөнгөн тусламж үзүүлсэн тухай

"Дүүргийн Засаг даргаас иргэдэд үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай журам"-ыг шинэчлэн боловсруулж, Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/189 дүгээр захирамжаар батлуулан мөрдөж байна.

Журамд заасны дагуу мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрээр Хөгжлийн нийгмийн ажилтнууд очиж судлан нөхцөл байдлын үнэлгээ хийж, 2020 оны тайлант хугацаанд нийт 145 иргэнд 52.530.000 /тавин хоёр сая таван зуун гучин мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Үүнд:

- 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/69 дүгээр захирамжаар 25 иргэнд 8.130.000 төгрөг
- 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/170 дугаар захирамжаар 16 иргэнд 5.600.000 төгрөг
- 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/230 дугаар захирамжаар 20 иргэнд 8.050.000 төгрөг
- 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/308 дугаар захирамжаар 22 иргэнд 8.500.000 төгрөг
- 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/345 дугаар захирамжаар 26 иргэнд 9.800.000 төгрөг
- 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/399 дүгээр захирамжаар 18 иргэнд 6.400.000 төгрөг
- 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/433 дугаар захирамжаар 18 иргэнд 6.050.000 төгрөг

Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалт:

Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжаар "Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам"-ыг боловсруулж батлуулсан. Дээрх журмын дагуу долоо хоногийн мягмар гарагт шаардлагатай тохиолдолд пүрэв гарагт батлагдсан хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч уулзан санал, хүсэлтийг сонсон шийдвэрлэж, хариу өгөх зорилгоор чиг үүргийн хамааралтай хэлтэс, албадын удирдлагуудыг оролцуулж газар дээр нь шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бүр шийдвэрлэн иргэдэд хариу өгч хэвшсэн.

Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан олон нийтийн арга хэмжээ буюу хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулахыг түр зогсоосон. 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс хойш газрын асуудлаар 55, хүнс, худалдааны чиглэлээр 8, тохижилт нийтийн аж ахуйн чиглэлээр 9, бусад асуудлаар 31, нийт 103 иргэн Засаг даргатай уулзахаар бүртгүүлсэн бөгөөд иргэдийг холбогдох хэлтэс, албадын дарга нартай уулзуулан газар дээр нь шийдвэрлэх боломжтой асуудлуудыг шийдвэрлүүлсэн.



3.4 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл:

Харилцахын 1369 ширхэг баримтаар 6,300,746,956 төгрөгийн гүйлгээ хийж баталгаажуулсан.




Нэмэлт санхүүжилтын 33 ширхэг баримтаар 271,870,000 төгрөгийн гүйлгээ хийж баталгаажуулсан.



Хөрөнгө оруулалтын сангийн харилцахын 142 ширхэг баримтаар

4,843,174,068 төгрөгийн гүйлгээ хийж баталгаажуулсан.



- 2020 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланг гаргаж Санхүү төрийн сангийн хэлтэст тушааж баталгаажуулсан.
- Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын цалинг хугацаанд бодож олгосон.
- Албан хаагчдын НДШ, ХАОАТ-ын тайлан сар бүр хугацаанд нь илгээн баталгаажуулсан.
- Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан.
- 2019 оны санхүүгийн баримтыг үдэж, цэгцлэн архивлан Архивын тасагт хүлээлгэн өгсөн.
- 2020 оны санхүүгийн тайлан гаргаж, баталгаажуулсан.

Бараа материалын орлогын 641 ширхэг баримтаар 642,157,751 төгрөгийн гүйлгээ шивж баталгаажуулсан.




Бараа материалын 269 ширхэг баримтаар 44,492,413 төгрөгийн

шилжилт хөдөлгөөнийг хийж баталгаажуулсан



Үндсэн хөрөнгийн 4541 удаагийн 1,039,228,802.54 төгрөгийн орлогын гүйлгээг шивж баталгаажуулсан

Үндсэн хөрөнгийн 716,754 ширхэг 725,377,852 төгрөгийн эд хөрөнгийн шилжүүлэх хөдөлгөөнийг хийж баталгаажуулсан.



- 2020 оны 4-р улиралын барьцаа хөрөнгө, байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланг гаргаж Санхүү төрийн сангийн хэлтэст тушааж баталгаажуулсан.
- Засаг даргын Тамгын газрын нийт 34 албан хаагчийн ажлыг хүлээлцүүлж 109.250.890 төгрөгийн шилжилт хөдөлгөөн хийсэн.
- Хэлтэс албад болон жолооч нарын 2020 оны 1-12 сарын хугацаанд 56,890,000, шуурхай штабын 30,399,000 төгрөгийн шатахууны тооцоог бодож шалгасан.
- Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан.

Барaa материалын зарлагыг 1896 ширхэг баримтаар 836,707,625 төгрөгийн зарлагын гүйлгээг хийж баталгаажуулсан.



Барaa материалын зарлагыг улирлын байдлаар эдийн засгийн ангилал тус бүрээр нь харуулбал:



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Хэвлэл мэдээллийн чиглэлээр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын хэлтэс, албадын хийж хэрэгжүүлсэн цаг үеийн ажлуудыг олон нийтэд ил тод, шуурхай хүргэхээр дүүргийн www.khanuul.mn сайт, 21 хорооны цахим сайт, Хан-Уул Эко дүүрэг facebook, "Хан-Уул дүүргийн Иргэдийн бүлэг, сайтуудыг тогтмол хөтлөн 2020 оны жилийн эцсийн байдлаар үйл явдлын нийт 1512 мэдээ, мэдээллийг байршуулсан.



Телевизүүдээр цацсан мэдээ: Хан-Уул дүүргийн төрийн захиргааны байгууллагуудын ажлын явц болон үйл явдлын мэдээ, мэдээллүүдийг олон нийтэд ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх үүднээс NTV, TV5, ECO TV, C1, VTV, Eagle TV, TV9, Монголын Үндэсний Олон нийтийн Радио телевиз, "Like TV" зэрэг телевизүүдэд тухай бүр нийт 584 гаруй үйл явдлын онцлох мэдээллийг бэлтгэн гаргасан. Мөн өглөөний хөтөлбөр, тодруулга ярилцлага, шууд нэвтрүүлэг, шууд дамжуулалт, сурвалжлага мэдээ зэрэгт холбогдох албан тушаалтанг холбон мэдээ, мэдээллийг тогтмол өгч, шуурхай ажилласан.



Цахим сайтуудаар дамжуулсан мэдээ: www.time.mn, www.news.mn, www.zaluu.com, www.ugluu.mn, monnews.mn, www.ontsloh.mn, www.24barimt.mn, zarig.mn, iconnews.mn, gogo.mn, ugluu.mn, murch.mn, eguur.mn, enter.mn, isse.mn, www.Ulaanbaatar.mn зэрэг 10 гаруй тэргүүлэх цахим сайтуудтай хамтран ажилласан.

Ил тод байдлыг ханган ажилласан талаар:

www.khanuul.mn сайт, e-office системд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 250 захирамж, 125 ил тод байдал, 86 үр дүн зэргийг албан хаагчдаас авч нэгтгэн цахим хуудаст байршууллаа. Мөн шинээр 4 цэсийг нээж иргэд үйл ажиллагааны мэдээллийг шуурхай авах хялбар нөхцөлийг бүрдүүлсэн.

"Бидний Хан-Уул" фото мэдээллийн сэтгүүл:



Хан-Уул дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон дүүрэгт 2020 онд хийгдсэн бүтээн байгуулалтын болон бусад мэдээ, мэдээлэл багтсан 56 хуудас бүхий сэтгүүлийг “ХАН-УУЛ ЭКО ДҮҮРЭГ” нэртэйгээр 30.000 ширхэг хэвлэж, дүүргийн иргэдэд түгээсэн.


“Хан-Уул дүүргийн Онцгой комисс”-ын дэд ажлын хэсгийн “Холбоо, цахим олон нийттэй харилцах баг”-ын үйл ажиллагаа:

Бүх нийтийн хөл хорио тогтоосонтой холбогдуулан “Хан-Уул дүүргийн шуурхай штаб” цахим хуудсаар дамжуулан 302 тусгай төрлийн мэдээ, мэдээлэл, зөвлөмж, видео контент, зурагт хуудас, дохион хэлбэрээр видео шторк бэлтгэн өдөрт дунджаар 8746 лайктай, 9074 дагагчтай, давхардсан тоогоор 876254 иргэнд хүргэн ажилласан.


Утасны лавлагаа, мэдээллийн чиглэлээр: 2020 оны жилийн эцсийн байдлаар лавлах

утсанд нийт **14002** дуудлагыг хүлээн авч хариу мэдээлэл өгсөн.

Жилийн эцсийн байдлаар лавлах утсанд ирсэн нийт дуудлагын үзүүлэлтийг графикаар харуулвал:



Лавлах утсанд хамгийн их хандалттай хэлтэс, албадыг графикаар харуулбал




Дүүргийн лавлах утсанд жилийн эцсийн байдлаар нийт 107 өргөдөл,гомдлыг хүлээн авч хариуцсан ажилтан, албан хаагчдад мэдэгдэн шийдвэрлэж ажилласан.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	Нийт
	10	9	11	13	13	7	5	11	17	9	2	107

ХАН-УУЛ ЭКО ДҮҮРЭГ ACCOUNT

ХАН-УУЛ ЭКО ДҮҮРЭГ ACCOUNT нь одоогийн байдлаар 1828 дагагчтай болсон бөгөөд өмнө жилийн мөн үеийнхтэй харьцуулвал 1100 дагагч нэмэгдсэн байна.

Дээрх хаягаар дамжуулан дүүргийн хэлтэс, алба, сургууль, цэцэрлэг, СӨХ, орон сууцны конторууд нийт 190 page болон 174 group-д нэгдсэн бөгөөд мэдээ, мэдээллээ чөлөөтэй нийтлэх харилцах боломж бүрдсэн.



Intro


- Works at Нийслэлийн Хан-Уул Дүүрэг
- Studied at National University of Mongolia
- Lives in Ulaanbaatar, Mongolia
- From Ulaanbaatar, Mongolia
- Followed by 1,828 people
- khanuul.mn

Иргэдээс ирсэн мэдээ мэдээлэл, санал хүсэлт, өргөдөл гомдлыг цагийн хүрд болон хуудасны шуудангаар дамжуулан шийдвэрлэж байна.

ХАН-УУЛ ЭКО ДҮҮРЭГ PAGE нь 2020 оны жилийн эцсийн байдлаар 9637 like 10103 дагагчтай болсон бөгөөд өмнө жилийн мөн үеийнхтэй харьцуулвал 5102 like 5648 дагагч нэмэгдсэн. 7 хоногт дунджаар 60,000-70,000 хүний хандалттай байдаг.



Мөн иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуудасны шуудангаар дамжуулан хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.



2020 оны 12 дугаар сарын байдлаар Хан-Уул Эко дүүрэг хуудас руу нийтдээ давхардсан тоогоор **519621** иргэн идэвхтэй хандалт хийж харилцсан байна. /Хуудасны дэлгэрэнгүй тайланттай танилцахыг хүсвэл доорх холбоосоор нэвтрэнэ үү https://drive.google.com/d/16S11sYZdhtbcy3e_3WtpKjZFNJL5Nb/view?usp=sharing/

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭД GROUP: Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын бодлого, үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэх, иргэдийн санал, хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх зорилго бүхий "Хан-Уул дүүргийн иргэд" нэртэй цахим бүлгэмийг 2018 онд шинээр нээн, хөгжүүлж, 2020 оны 12 дугаар сарын байдлаар 22954 гишүүнтэй болсон бөгөөд өмнө жилийн мөн үеийнхтэй харьцуулвал 11205 гишүүн нэмэгдсэн байна. Иргэд 7 хоногт дунджаар 85000 удаа тус группын мэдээ, мэдээлэлтэй харилцдаг байна.

Дээрх группыг ажиллуулснаар иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг шуурхай ил тод байдлаар шийдвэрлэдэг болсон.

2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Хан-Уул дүүргийн иргэд бүлгэм рүү давхардсан тоогоор нийтдээ **1 095 210** хүн хандалт хийж 945 нийтлэл нийтэлсэн бөгөөд 38583 like, share 6552 сэтгэгдэл бичсэн байна.

Бүлгэмийн дэлгэрэнгүй тайланттай (хэдэн цаг минутад хандалт хийсэн ямар нийтлэл сэтгэгдэл бичсэн гишүүдийн мэдээлэл зэрэг) танилцахыг хүсвэл доорх холбоосоор нэвтрэнэ үү https://drive.google.com/drive/folders/1RW_YrDjrhMD26dHaAkjDDD46L9CqBy2

ТАВДУГААР БҮЛЭГ: “БУСАД МЭДЭЭЛЭЛ”**5.1 Холбогдох чиг үүргийн дагуу нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл:**“Явуулын нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулсан талаар:

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хорооны хөгжил –Төрийн үйлчилгээ” зорилтын хүрээнд тус дүүргийн иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос ойр, хүртээмжтэй, хөнгөн шуурхай хүргэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/370 дугаар захирамжаар “Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-г 2020 оны 09 дүгээр сарын 12, 13,19-ний өдрүүдэд 4,5,6,7,8, 9,10,12,13,14,16,21 дүгээр хороодод зохион байгууллаа. Дээрх арга хэмжээнд дүүргийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Засаг даргын Зөвлөх Ч.Бат-Оргил, Засаг даргын орлогч А.Амартүвшин болон хэлтэс, алба, хороодын дарга нар хүрэлцэн ирж, иргэдийн санал, гомдлыг сонсч, шийдвэрлэх боломжтой асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэж ажилласан.

Дээрх үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Цэргийн штаб, Хууль зүй, архивын тасаг, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Татварын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Албан бус насан туршийн боловсролын төв, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Газар зохион байгуулалтын алба болон Хан-Уул, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Хан-Уул хэрэглэгчдэд үйлчлэх төв зэрэг 17 хэлтэс, албадын 148 албан хаагчид хамтран оролцож, төр захиргааны байгууллагын 100 гаруй нэр төрлийн үйлчилгээг 9772 иргэнд хүргэсэн.

Зар мэдээлэл хүргэсэн байдал: Явуулын нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулах тухай зар, мэдээллийг хорооны цахим хуудас, “Хан-Уул дүүргийн иргэд бүлгэм” цахим хуудсаар болон олон нийтийн зар мэдээллийн самбар, хэсгийн ахлагч нараар дамжуулан иргэдэд хүргэн, үйлчилгээ явуулах ажлын байр болон бусад шаардлагатай зүйлсийг бэлтгэн холбогдох хэлтэс, албадтай хамтран ажилласан.

ЯВУУЛЫН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Явуулын нэг цэгийн үйлчилгээ хороодод үзүүлэх үеэр 100 иргэнээс төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн санал хүсэлтийг бодлого зорилт, өдөр тутмын үйл ажиллагаандаа тусгах зорилгоор санал асуулга авлаа. Энэхүү судалгаанд дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороодын иргэдийн төлөөлөл хамрагдлаа.

Дээрх асуулга нь 10 асуулттай бөгөөд төрийн албан хаагчдийн ёс зүй, харилцаа, иргэд төрийн үйлчилгээ бүрэн авч чадаж байгаа эсэх, 2020 онд дүүргээс иргэдийн амьдрах орчныг сайжруулах, эрүүл аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажил үйлчилгээ иргэдийн санаанд хэр нийцсэн талаар болон 2021 онд тухайн хороонд хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ямар ажил, үйлчилгээ хэрэгтэй байгааг тогтооход чиглэгдсэн.

Судалгаанд 20-30 насны 25, 31-40 насны 13, 41-50 насны 21, 51-с дээш насны 41 иргэн тус тус хамрагдсан байна. Үүнээс эрэгтэй-33, эмэгтэй-67 иргэн санал асуулгад оролцсон байна.

Иргэдийн сэтгэлд нийцсэн, эрэлттэй үйлчилгээнүүдээс дурьдвал:

-Хууль, эрх зүйн зөвлөгөө

-Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээ, оношилгоо, нийгмийн даатгал, газрын асуудал гэх мэт.

Цаашид анхаарч хэрэгжүүлэх ажлууд: /Газар дээр нь шууд шийдвэрлэх боломжтой үйлчилгээнүүд/:

- Өмч, газрын харилцаатай холбоотой зөрчлийг газар дээр нь шууд шийдвэрлэдэг болох /хашаа сунгах, нэр шилжүүлэх/
- Амралт, рашаан сувилалын эрхийн бичиг олгох
- Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх

Иргэдээс өргөдөл гомдол, санал, хүсэлт тус тус хүлээн авч холбогдох хэлтэс, тасгуудад шилжүүлж, шийдвэрлэх боломжтой асуудлуудыг газар дээр нь хариу өгч шийдвэрлэсэн.



Нэг цэгийн үйлчилгээний танхимын үйл ажиллагааны чиглэлээр:

“Нэг цэгийн үйлчилгээ”-ний танхимаар дараах нэр төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг. Үүнд:

- 1 Улаанбаатар хотын банк /2/
- 2 Кадастрын зураглал /2/
- 3 Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн материал хүлээн авах, олгох /2/
- 4 Гадаад паспортын материал хүлээх авах, олгох /2/
- 5 Нотариат /1/
- 6 Нийгмийн даатгал /1/
- 7 Өргөдөл, гомдол хүлээн авах
- 8 Канон, түргэн зурагчин

Дээрх 12 цохноо өдөрт дундажаар 300-400 орчим иргэн үйлчилгээ авдаг бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 101123 иргэн үйлчлүүлсэн байна.

Үүнээс гадна иргэдэд зориулан лавлагааны “ТҮЦ” машин, “Ухаалаг мэдээллийн самбар”-ыг байрлуулж, төрийн үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлтийг хэвлэн авах боломжоор иргэдийг хангасан.

Мөн улсын бүртгэлийн хэлтсээс “ГЭРЭГЭ” автомат машиныг байруулан төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

Нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо /давхардсан тоогоор/

№	Үйлчилгээний төрөл	2020 он /өссөн дүнгээр/
---	--------------------	-------------------------

1	УБ хотын банк /гүйлгээ/	49090
2	Эд хөрөнгийн эрхийн бүртгэл	32500
3	Гадаад паспорт	4765
4	Нотариат	7768
5	Канон, түргэн зурагчин	4100
6	Газрын кадастр	2900
Нийт дүн		101,123

Хяналт, шалгалт: Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААНБ-д хүнсний аюулгүй байдал болон холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах үүднээс МХХ, ЦХ, НЗАА зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 68 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж **1350** иргэн аж ахуйн нэгжийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

❖ Коронавирусуудыг урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйтгэл хийлгэх, орчны 50м хүртэлх газрын цас, мөс, хог хаягдлыг цэвэрлэх, ариун цэврийн өрөөгөөр нийтэд үнэ төлбөргүй үйлчлэх тухай захирамж, мэдэгдэл, зурагт хуудсыг дүүргийн худалдаа, үйлчилгээний газрууд болон томоохон 20 зах худалдааны төв, гахай, шувуу, үхрийн фермийн аж ахуй эрхлэгчдэд хүргүүлэн, ариутгал халдваргүйтгэлийн ажилд Мэргэжлийн хяналтын байцаагчийн хамт хяналт тавин, хэрэгжилтийг шалган, заавар зөвлөгөө өгч ажилласан.



❖ Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хэлтэс, албадтай хамтран

явган эргүүлд **38**, шөнийн эргүүлд **98** удаа гарч хяналт шалгалт хийн, зөрчил дутагдлыг арилган удирдлага болон шуурхай штабд мэдээлж ажилласан.



❖ Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын

дэглэм барьж ажиллаж буй эсэхэд хороод, Мэргэжлийн хяналтын албан хаагчидтай хамтран худалдааны чиглэлийн 750 гаруй аж ахуйн нэгжид хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.

❖ Нөөцийн мах худалдан борлуулах үйл ажиллагаанд УБХЗАА, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Татварын хэлтэс, Мал эмнэлгийн тасагтай хамтран 13 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулж ажиллалаа.



❖ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай хамтран 23 барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, нийслэлийн харилцаа холбооны газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, дүүргийн Хүүхэд гэр бүл залуучуудын хэлтэс, Цагдаагийн газартай хамтран 4 цахим тоглоомын газарт хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулсан.



❖ Дүүрэг дэх мал эмнэлгийн тасгаас "Мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх" журмын хэрэгжилтийг хангах хүрээнд "Фермерүүд", "Лавай" худалдааны төвийн дэргэдэх мал эмнэлгийн лабораториудын байр, итгэмжлэлийн хүрээ, шинжилгээний стандарт, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

❖ Нийслэлийн хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалын дагуу Төвлөрсөн болон бие даасан ариутгах системд холбогдох боломжгүй газар үйл ажиллагаа явуулж буй нийт 270 иргэн ААНБ-уудын ариун цэврийн байгууламжийн судалгааг гаргаж Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар galmaaraa@gmail.com цахим хаягаар хүргүүлэн / manaikhoogo.mn / сайтын "Нэг хот-нэг стандарт" хэсгийн "Судалгаа" цэсэд холбогдох судалгаа, мэдээллийг бүртгэлжүүлэн оруулсан.



- ❖ ХХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй 137 хоршооны нарийвчилсан судалгааг гаргаж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 29 хоршоонд хөгжлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж ажилласан.

Саарал усны ашиглалтын судалгаа хийж, ААНБ-дад танилцуулахын зэрэгцээ, саарал усны технологи ашиглах анхан шатны суурь мэдээлэл бий болгох үүднээс авто засвар, авто угаалгын газруудад байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх шаардлагыг хүргүүлснээр 12 ААН, иргэн үйл ажиллагаандаа байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэсэн.



5.2 Байгууллагын харъяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл:

Засгийн газрын 2017 оны А/89 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны А/213 дугаар захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/61 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,
- Байгууллагын үйл ажиллагаа,
- Байгууллагын ил тод байдал,

➢ Хүний нөөцийн ил тод байдал гэсэн 4 үндсэн агуулгын дагуу 22 үзүүлэлтээр дүүргийн төр захиргааны нийт 25 хэлтэс албадын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хагас жилийн хяналт шинжилгээ, үнэлгээгээр 5 байгууллага бүрэн хангалттай, 17 байгууллага хангалттай, 2 байгууллага ажил сайжруулах шаардлагатай гэж үнэлэгдсэн. Хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг 2020.08.03-ны өдөр Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаар хянуулж, дүүргийн Засаг даргад танилцуулсан. Тайланд тусгасан 4 бүлэг 23 заалт зөвлөмжийг дүүргийн Засаг даргын 2020.08.10-ны 04/485 тоот албан бичгээр дүүргийн төр захиргааны 26 байгууллагад хүргүүлсэн.

Жилийн эцэст нийт 25 байгууллагын 2020 оны үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлд 4 бүлэг 22 үзүүлэлтийн дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 3 байгууллага бүрэн хангалттай, 16 байгууллага хангалттай, 6 байгууллага ажил сайжруулах шаардлагатай гэж үнэлэгдсэн.

Дүүргийн албан хэрэг хөтлөлт, ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ

Тус дүүргийн хариутай бичгийн шийдвэрлэлт нь 97 хувь, Засаг даргын Тамгын газрын ирсэн бичгийн шийдвэрлэлт 94,9 хувь буюу хангалттай үнэлэгдсэн ч нийт 1098 зөрчил бүртгэгдсэний 26,2 хувь нь Засаг даргын Тамгын газарт 35,7 хувь нь дэргэдэх хэлтэс, албадад, 17,1 хувь нь хороод, 10,8 хувь нь дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тус тус зөрчил тооцогдож албан бичгийн индекс 0.72 буюу В үнэлэгджээ.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ ИРСЭН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭНД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ
/2020.01.01-2020.12.16/

№	Хэлтсийн нэр	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч хаагаагүй	Хугацаа хэтэрч хаасан	Зөрчил	Шийдвэрлэлтийн хоног	Зөрчлийн хувь	Албан бичгийн индекс
1	ДИТХ	554	99.3	10		36	119	7.79	10.8	0.58
2	ЗДТГ	4772	94.9	36	1	65	288	6.27	26.2	0.69
3	Дэргэдэх	20581	99.2	87	3	156	392	8.99	35.7	0.78
4	Хороод	5961	97.5	67	0	74	188	7.71	17.1	0.77
5	Сургууль /нийт 18/	2469	95.3	16	8	103	93	6.93	8.5	0.74
6	Цэцэрлэг /нийт 28/	2843	95.6	5	3	134	18	6.49	1.6	0.77
Нийт дүн		37180	97	221	15	568	1098	7.36	100.0	0.72
Албан бичгийн индекс		0.72 - В ҮНЭЛГЭЭ								



Дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ

Дөрөвдүгээр улирлын байдлаар дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй нийт 11 тогтоол шийдвэрийн 30 заалтын хэрэгжилтэд, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 94,58 хувь хангалттай буюу бүрэн хэрэгжсэн гэж үнэлэгдлээ. Илтгэх хуудсыг биелэлтийн хамт тухай бүр хэлтсийн даргаар янхуулж, ЗДТГ-ын даргаар батлуулан НЗДТГ-т edoc-программаар илгээсэн.

5.3 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Иргэд, оршин суугчдаас ирүүлсэн гомдлын дагуу дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран 18 дугаар хороо "Хүннү 2222" хорооллын В1 давхарт үйл ажиллагаа эрхэлж буй "Есо", "Black bull" авто машин угаалгын газруудад хяналт шалгалт хийж, лацдан үйл ажиллагааг зогсоож ажилласан.



Иргэд оршин суугчдын хүсэлтийн дагуу дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарч шинээр баригдаж байгаа барилгын ажлуудад хяналт тавьж хашаанд ил задгай хуримтлуулсан хог хаягдлыг бүрэн тээвэрлүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажилласан. Энэ ажлын хүрээнд дүүргийн 16 дугаар хороо нутаг дэвсгэрт Нисэх 81, 86 дугаар байрны гадна хуримтлагдсан их хэмжээний барилгын хогийг гүйцэтгэгч байгууллага "Монгол Од" ХХК-д шаардлага тавьж ачуулсан. Мөн 11 дүгээр хороо Рома хотхоны барилгын компани болох "Рома инвестмент" ХХК-д албан мэдэгдэл хүргүүлж дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-тай хамтарч хотхоны хог хаягдлыг тээвэрлүүлэх арга хэмжээ авсан.



5.4 Хөрөнгө санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл, болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээлэл:

Хүндрэлтэй асуудлууд:

1. Хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн асуудлаар зохион байгуулах шаардлага гарч буй арга хэмжээнүүд тухайн жилийн батлагдсан төсөвт тусгагдаагүй байдаг тул шийдвэрлэхэд хүндрэлтэй, цаг хугацаа тулсан байдаг.

2. Дээд газруудаас ирж байгаа олон нийтийг хамарсан болон бусад цаг үеийн шинжтэй ажил зохион байгуулах, биелэлт, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичгүүдийн хугацаа тулж ирүүлдэг.

Цаашид анхаарах асуудлууд:

1. Зохион байгуулж буй үйл ажиллагааны үр дүн, авч холбогдлын талаар иргэдээс тухай бүр санал асуулга авч, түүний мөрөөр дүн шинжилгээ хийж ажлаа төлөвлөх

2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын албан хаагчид, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх

3. Төлөвлөсөн ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэл сайтай хийж гүйцэтгэх, үр дүнг тооцож ажиллах

4. Зохион байгуулах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж, олон нийтэд ил тод мэдээлж байх